

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY

2016 ОНЫ 01 САР №02 (104)

Mongolianeconomy.mn




Улаанбаатар-Худалдан авалт 2016



Нийслэлийн Засаг
даргын Тамгын газар




Улаанбаатар хотын
Худалдааны танхим





ПЕТРОВИС
 ХӨГЖИЛ ТҮГЭЭНЭ
 1941 оноос



TRIANGLE



Mobil 1



**PETRO
 MATAD**

*Монгол орны өмнөд булан бүрт
 Бид хурч үйлчилнэ!*

ДЭЛХИЙН ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.

Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.
ЗОВЛОН ЗУДГУУР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

“Дэлхийн 2016”-д Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. “Манай урьдчилан харсан төлөвийн 90 хувь нь биелдэг онцлогтой. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг” хэмээн “The World in 2016” сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцолжээ. Бид ч гэсэн Монголын уншигчдыг энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904



ХӨГЖЛИЙН ГОЛОМТ

Бид нийгмийн хөгжлийн
тулгуур нь байж сайн сайхныг
түгээж ажилладаг

 **ГОЛОМТ БАНК**
Сайн сайхныг санхүүжүүлнэ

 www.golomtbank.com



Э.Бат-Үүл: Бид гурван том динозаврыг хөдөлгөхөд л өндөр хөгжилд хүрнэ

Хүн ирж л байвал тэр хот сайн байна гэсэн үг. Улаанбаатар хотын хүн ам өссөнөөр зах зээл хоёр дахин өслөө, хуудас 12



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:
Б.Үүрийнтуяа
Б.Энхцэцэг
Г.Орхон
Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Барянжанв

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, I хороо, Экспресс тауэр. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn
Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:
“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетин бүх салбар
“Макс” супермаркетин бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн:
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр
“Max mall” дахь салбарууд

Нийслэл

- 10 **Мөрөөдлийн хот**
Автомашингүй гудамжтай болох шийдвэр гаргалаа
- 12 **Э.Бат-Үүл: Бид гурван том динозаврыг хөдөлгөхөд л өндөр хөгжилд хүрнэ**
Харин манай улстөрчид нэг зүйлийг ойлгох цаг болсон.
- 15 **Дарь гуай “моодноос” гарсны маргааш**
Гурван тал дахин төлөвлөлт хийе гэх нэгдсэн ойлголтоотой байгаа тул энэ ажил харьцангуй хурдацтай урагшилж байгаа юм
- 17 **С.Очирбат: Үндэсний компаниудад бизнесийн маш том талбар нээгдсэн**
Харин бизнесийнхэндээ гэр хорооллыг орон сууцжуулах энэ том бизнес талбар руу ханцуй шамлан орохыг уриалж байна
- 19 **Нийслэлийн хөрөнгө оруулалт 2013-2015**
- 22 **2016 оны хөрөнгө оруулалт**
- 24 **Гол тоглогч**
Монголыг зорих жуулчдын аяллын эхний цэг хүссэн хүсээгүй Улаанбаатар хот болдог учир хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь салбарын хувьд зайлшгүй.
- 28 **Ж.Од: Улаанбаатар хот бол маш сонирхолтой зах зээл**
Компаниуд төрийнх байснаараа юу хожих гээд байгаа юм бэ
- 30 **Бүтээн байгуулалтын дээд шагналтнууд**
- 33 **Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр**



Хөгжилд хөтлөх замүүд Амгалан тайван, амьдрахад таатай, стрессгүй хоттой болох нь нийслэлчүүдийн туйлын хүсэл, хуудас 10

- 34 **Төрийн үйлчилгээний хувьсгал**
- 36 **Ү.Энхтайван: Тендерт оролцогч хариуцлагажиж, төрийн байгууллагад хяналт тавих хэрэгтэй**
Компаниудыг бүртгэл-жүүлээд, мэдээллийг баталгаажуулж оролцогчийн чадварыг автоматаар үнэлдэг болох нь гол дэвшил юм
- 44 **Хөгжилд хөтлөх замүүд**
Найман цэгт ус зайлуулах төмөр бетон хоолойг засварлаж шинээр нэг төмөр бетон хоолойг хийж гүйцэтгэсэн
- 45 **Марафон**
Ирэх хоёр жил газар өмчлөл, улс төрийн золиос болчихгүй бол, үргэлжилнэ
- 48 **С.Энхцэцэг: Арбитр нь маргааныг шуурхай шийдвэрлэдгээрээ шүүхээс ялгаатай**
Бид өөрийн орны арбитрын эрх зүйн зохицуулалтыг НҮБ-ын Арбитрын загвар хуульд нийцүүлэхээс өөр арга байхгүй.
- 50 **“Иргэдийн оролцоо, хотын маргааш”**
Зөвлөлдөх санал асуулгаар нийслэлээс хэрэгжүүлэх урт хугацааны 14 томоохон төсөл хөтөлбөрийг иргэдэд танилцуулж, тэдний санал тус бүрийг тусгах юм.
- 51 **Хотын хөгжил иргэдийн нүдээр**
Бүх талаасаа хавчигдах нь
- 52 **“Ногоорох” шийдэл**
Энэ бол “Ногоон” хот хэмээх хөгжлийн хандлага даяаршиж буйн илрэл



Ж.Од: Улаанбаатар хот бол маш сонирхолтой зах зээл

Улаанбаатар хотыг дангаар нь аваад үзвэл маш жижигхэн газарт хүн ам шигүү суурьшсан, эвийг нь олоод ажиллавал маш их зүйл хийх боломжтой зах зээл, хуудас 28



Төрийн үйлчилгээний хувьсгал

Энэхүү албан ёсны нээлтийн ажиллагааны үеэр шинээр мэндэлсэн Нийслэлийн бяцхан иргэдэд төрсний гэрчилгээ, 16 нас хүрч буй охинд иргэний үнэмлэхийг нь гардуулах ёслолыг Ёслол хүндэтгэлийн танхимд хийсэн юм, хуудас 34



Хөгжилд хөтлөх замүүд

Гэтэл тус чиглэлийн замд 30-40 жил огт засвар шинэчлэл хийгээгүй, жолооч нарын төдийгүй зорчигчид ч явахаасаа халширдаг болоод байлаа, хуудас 44

2003-2014

11 жилийн хугацаанд

98000

хүнд газар олгосон

2015






1 жилийн хугацаанд

76000

хүнд газар олгосон

Марафон, хуудас 45

Улаанбаатар хотын Худалдааны Танхим

-  Гишүүдийнхээ болон нийслэлийн бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаална.
-  Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, нийслэлийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
-  Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хувийн хэвшлийн санал санаачилга, шийдлийг нэгтгэн төрд хүргэнэ.
-  УБХТанхимын дэргэдэх арбирт нь гадаад дотоодын бизнес эрхлэгчдийн бизнесийн маргааныг хянан шийдвэрлэнэ.
-  Улаанбаатар хотыг зүүн хойд Азийн бүсийн санхүүгийн томоохон төв болгон хөгжүүлнэ.

Удирдах зөвлөлийн гишүүд:



УЛААНБААТАР ХОТЫН БИЗНЕСИЙН
ХАМГИЙН ТОМ НЭГДЭЛД
ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХИЙГ УРЬЖ БАЙНА.

 www.ubchamber.mn

 info@ubchamber.mn

 7700-3883



Редакцийн зурвас

“Mongolian Economy” сэтгүүл өдрөөс өдөрт өргөжин тэлж, өнгө зүс нэмсээр буй Улаанбаатар хотынхоо тухай дөрөв дэх дугаараа уншигч таны гарт хүргэж байна. Бид анх 2014 онд 1.3 сая иргэнтэй, том хотын эдийн засаг, нийгмийн амьдрал, хөгжил цэцэглэлт ямар байх ёстой, бид хаана яваа талаар хөндөж байсан бол сүүлийн нэг жил хүрэхгүйн хугацаанд Нийслэлийн захиргаатай хамтран гурав дахь дугаараа гаргаад буй.

Өнгөрсөн оны дөрөвдүгээр сард анх удаа болсон “Хөгжлийн төлөө түншлэл” Улаанбаатарын форумын үеэр та бүхэнтэй уулзаж байсан бол сүүлийн шинэхэн дугаараараа “Улаанбаатарын худалдан авалт-2016”-гийн оролцогч та бүхний оюуныг дахин мялааж байна.

Нийслэлчүүд маань тэсгим хүйтний улиралд хорт утаагаар амьсгалж, өвөлждөг баргар амьдралтай ч сүүлийн жилүүдэд хотын тохижилт, үйлчилгээ, соёл, боловсролын чиглэлээр өөрчлөлт авчирсан олон сайхан ажил хийгдсээр байгаад олзуурхуштай.

Тийм ч учраас нийслэлийн тухай нийтлэл бичих сэдэв хөвөрч, ийнхүү бүхэл бүтэн сэтгүүл болон гардаг. Тухайлбал, эдийн засгийн уналт улам гүнзгийрч, ажилгүйдэл нэмэгдэж, ажлын байруудад дүнсгэр орчин бүрхсээр буй сүүлийн хоёр жил орчмын хугацаанд харин нийслэлд ажил маань байнга ундарсаар байгааг харах сайхан.

Хотын захын гэр хорооллуудын дунд орон сууцны барилгууд хаа сайгүй сүндэрлэж, цахимаар газар өмчилж, нийтийн тээвэрээр үйлчлүүлэхдээ ухаалаг карт ашигладаг болсон. Хамгийн бахархмаар нь энэ бүхнийг хөгжсөн орнууд цагтаа нэлээд хугацаа шаардаж, хөдөлмөр зарж ажил хэрэг болгож байсан бол

манайх маш богино хугацаанд нэвтрүүлж чадаж байгаа тухай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа онцлов. Мөн түүний ярианаас хотын бизнес, хөгжилтэй холбоотой сэтгэл сэргээж, итгэл төрүүлсэн олон шинэ мэдээллийг авах болно.

Мөн “Улаанбаатар-Худалдан авалт 2016” форумын үеэр хотын зүгээс гар гараа барин хамтдаа урагшлахыг уриалж буй бизнесийнхэндээ сюрприз болгон барих богц дүүрэн бэлгээс бид энэхүү сэтгүүлийнхээ хуудаснаа урьдчилан задалсан байгаагаа дуулгахад таатай.

Хотын захиргаа болон хувийн хэвшил хөгжлийн төлөө албан ёсоор түншилж, Улаанбаатарын худалдааны танхим байгуулагдаад нэг жил болж байна. Хөгжлийн төлөө түншлэл “Улаанбаатарын худалдан авалт 2016”-аар үргэлжилж буй.

Мөн хотын хөгжлийн хөдөлгөгч хүч нь Улаанбаатарын хөгжлийн корпраци байна гэж харж байгаа аж.

2016 он монголчуудын хувьд сонгуульд хариуцлагатайгаар оролцох, шинэ төр засагтай болж эдийн засгийн уналт хаашаа эргэхийг харах, АСЕМ-ийн томчуудын хөлд дарагдах, Олимпт хүч үзэж, дээлийн зах мушгих гээд олон ажилтай суух жил. Хажуугаар нь Улаанбаатараа улам өөдлөн дэвжихэд хүн бүр хүчин чармайлт гаргах учиртай.

Таны миний нийслэл учраас их хотын соёлд суралцаж, ухаалаг амьдарцаа. Үүний төлөө манай сэтгүүл ажиллаж, хогтой холбоотой мэдээллийг түгээсэн олон дугаар гаргах болно.

“Mongolian Economy”

Түрээсийн орон сууц

Засгийн газрын ээлжит Хуралдаанаар “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолыг баталжээ. Энэхүү тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын захиалгаар нийслэл болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 929 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэхээр шийдвэрлэжээ. Түрээсийн нэг сарын төлбөрийг орон сууцны нийт талбайн хэмжээ, өрөөний тооноос хамааруулан нийслэлд 200-280 мянган төгрөг, орон нутагт 140-230 мянган төгрөг байхаар тогтоосон байна.



Засгийн газраас зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд баригдсан “Буянт-Ухаа 1” хорооллын орон сууцанд иргэдээс захиалга авах журмын 4.3 дахь заалтад өөрчлөлт оржээ. Тухайлбал “Орон сууц худалдан авсан төрийн албан хаагч, зорилтот бүлгийн иргэн худалдан авсан орон сууцны зээл, төлбөрийг бүрэн барагдуулсан тохиолдолд уг орон сууцыг бусдад худалдах, түрээслүүлэх эрхтэй болно” гэжээ. Мөн журмын 6.4, 6.5 дахь заалтыг тус тус хүчингүй болгосон байна.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн яам болон Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран “Дотоодын үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих төр, үндэсний үйлдвэрлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Энэ үеэр салбарын



худалдан авалтыг дотоодын үйлдвэрлэлээр дэмжиж, бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээг Боловсролын сайд Л.Гантөмөр, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нар Аж үйлдвэрийн яамтай санамж бичиг байгууллаа.

Нийтийн тээвэр

Нийслэлийн Тээврийн Газар, “Улаанбаатар смарт карт” ХХК хамтран нэгэн шинэ үйлчилгээг туршиж эхэллээ. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд Удирдлага, Мэдээллийн болон Цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийн хүрээнд Нийтийн тээврийн үйлчилгээний “UB smart bus” аппликейшны эхний хувилбарыг гаргаад байна. Энэ үйлчилгээг андройд үйлдлийн систем бүхий ухаалаг гар утастай хүн бүхэн татаж авч ашиглах боломжтой. Та google play-store хуудсаар дамжуулан “ulaanbaatar smart bus” аппликейшныг татаж авснаар нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, автобусны буудал, чиглэлийн зураглалыг харж болно. Мөн өөрийн сонирхсон буудлыг дамжин өнгөрөх бүх чиглэлийн мэдээлэл, автобусны хоорондын хүлээгдлийн хугацааг ч харах боломжтой. Хамгийн сонирхолтой нь та суух гэж байгаа чиглэлийнхээ бүх автобуснуудын байршлыг харж болохоороо



онцлогтой. Одоогоор Android үйлдлийг системтэй утсанд зориулсан хувилбарыг Play store дээр байрлуулсан бөгөөд тун удахгүй IOS үйлдлийн системд зориулсан хувилбарыг Apple store-д байрлуулах аж.

Нийслэлийн нийтийн тээврийн шинэчлэлийн хүрээнд угсраа автобусыг үйлчилгээнд гаргасан. Угсраа автобус нь 18.7 метр урттай, 38 хүний суудалтай, 163 хүний багтаамжтай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай налуу шагаар үйлчлэн, зориулалтын зай талбайтай гэх мэтийн давуу талтай юм. Эхний ээлжинд 20 автобусыг Энхтайвны өргөн чөлөө буюу 5 шарын уулзвараас Офицеруудын ордны аюулгүйн тойрог хүртэлх шугамд иргэдэд үйлчилж байна.

Нийслэлийн Засаг даргын “Нийтийн тээврийн үйлчилгээний сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн Тээврийн газраас зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд хэд хэдэн чиглэлээр хяналт шалгалт явуулж, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллаж байгаа юм. Түүнчлэн автобусны буудал дээр удаан зогсож хууль бусаар зорчигч тээвэрлэж байгаа автомашин, бага багтаамжийн автобусны зөрчлийг баримтжуулж, холбогдох хууль, дүрмийн дагуу хариуцлага тооцох ажлыг эхлүүлсэн байна.

Нийслэлийн Нийтийн тээврийн хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар



авсан 20 эко автобусыг үйлчилгээнд гаргасан. Уг автобуснуудыг Ч:59 “ХМК-Офицеруудын ордон” чиглэлийн үйлчилгээнд ажиллуулж байгаа юм. Мөн Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны иргэдийн зорчих эрэлтийг үндэслэн Ч:57 “Улаан чулуут-Их наран-МУИС” чиглэлийг шинээр нээж 16 автобус 7 минутын хүлээгдлийн хугацаатайгаар үйлчилж байна. Дээрх хоёр чиглэлийн үйлчилгээг эхлүүлснээр нийслэл хотын баруун хэсгийн иргэдийн буюу 21 дүгээр хороолол, Содон хороолол, Ханын материал, Улаан чулуут, Их наран гэх зэрэг суурьшлын цэгүүдийн иргэдэд хүрэх нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байгаа аж.

Авто тээвэр

Сар шинийн баяр болох гэж буйтай холбогдуулан Нийслэлийн замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор энэ сарын 30, хоёрдугаар сарын 06-ны бямба гаригуудад автомашины улсын дугаарын сүүлчийн орон сондгой тоогоор төгссөн бол 10:00-20:00 цагийн хооронд Саппорагийн уулзвараас Таван шарын уулзвар хүртэлх замд хөдөлгөөнд оролцохыг хязгаарлажээ. Мөн энэ сарын 31, хоёрдугаар сарын 07-ны ням гаригт улсын дугаарын сүүлчийн орон тэгш тоогоор төгссөн бол хөдөлгөөнд оролцохгүй юм.

“Нийслэлд авто тээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөрийн тогтолцоог шинэчлэн нэвтрүүлэх

журам”-ын дагуу авто тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг улсын дугаарын сүүлийн тооноос хамаарч төлөхөөр зохицуулалт хийжээ. Үүнд:

- * 1, 6 тоогоор төгссөн автомашины улсын дугаартай жолооч нэгдүгээр сард,
- * 2, 7 тоогоор төгссөн бол хоёр дугаар сард,
- * 3, 8 тоогоор төгссөн бол гуравдугаар сард,
- * 4, 9 тоогоор төгссөн бол дөрөвдүгээр сард,
- * 5,0 тоогоор төгссөн бол тавдугаар сард албан татвар, төлбөр хураамжаа төлнө. Уг журам хэрэгжсэнээр банк, оношлогооны цэгүүдэд үүсдэг дараалал, ачааллыг бууруулах ач холбогдолтой юм. Иргэд тээврийн хэрэгслийн албан татвараа Дүнжингарав худалдааны төвд байрлах Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хандан өгч болох аж. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв

Нийслэлийн Засаг дарга энэ сарын 04-нд “Үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/01 дүгээр захирамж гаргажээ. Уг захирамжаар 2016 оныг “Мэдээллийн технологид тулгуурласан үйлчилгээний биржийн тогтолцоог бүрдүүлэх жил” болгон зарлалаа. Энэ нь нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах зорилготой аж. Мөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж буй үйлчилгээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологи, шуудан, холбооны зардлыг

бууруулах зорилгоор шилэн кабелийн нэмэлт эх үүсвэрийг шинээр татах, нийт байгууллагуудыг IP технологийн харилцаа холбооны системд шилжүүлэх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахаар болжээ.

Аялал жуулчлал

Нийслэлд аялал жуулчлал хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн онцгой болон эрсдэл бүхий нөхцөл байдлын үед гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах, авран хамгаалах арга замуудыг тодорхойлсон нийслэлийн аялал жуулчлалын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүний дагуу нийслэлийн Засаг дарга “Нийслэлийн аялал жуулчлалын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г баталлаа. Энэхүү төлөвлөгөө нь аялал жуулчлалын салбарт сөргөөр нөлөөлж болох газар



хөдлөлт, объектын түймэр, үер, хүний халдварт өвчин, хүчтэй салхи, химийн болон цацрагийн осол, ой, хээрийн түймэр, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэсэн 8 төрлөөр эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн өмнө болон дараа нь авах арга хэмжээг тодорхойлсноороо чухал ач холбогдолтой юм.

Авто зам

Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулж, замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилгоор

Нэгдүгээр эмнэлэгийн хашаан дундуур С.Зоригын гудамжийг зүүн тийш Чин Ван Чагдаржавын гудамжтай холбосон шинэ зам тавилаа. Энэхүү автозам нь 2,8 метр өргөн зорчих хэсэгтэй 0,7 метр явган замтай, 3,5 метрийн өргөнтэй 75 метр урттай юм. Шүүхийн шинжилгээний үндэсний төвөөс нас барагсдыг гаргахад Улсын клиникийн нэгдүгээр эмнэлгийн хойд болон баруун талын авто замаас өөр гарц байдаггүй учир дээрх замуудад хөдөлгөөний ачаалал нэмэгдэж, түгжрэл ихээр үүсдэг төдийгүй замын хөдөлгөөний дүрэм зөрчигддөг гэж Замын цагдаагийн газраас тайлбарладаг. Иймд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн хойд талаар урдаасаа хойшоо чиглэлтэй нэг урсгалтай замыг шинээр гаргаснаар Энхтайваны өргөн чөлөөний авто замын ачаалал тодорхой хэмжээгээр буурах юм.

Нийслэлийн удирдлагын зөвлөлийн ээлжит хуралдаанаар хотын замын хөдөлгөөний нөхцөл байдлын талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Зам тээвэр, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч Н.Гантөмөр танилцууллаа. Тус ажлын хэсгийн судалснаар Улаанбаатар хотод зорчих тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж замын хөдөлгөөний ачаалал ихэсжээ. Тухайлбал, өнгөрсөн оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 719 343 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй



байгаагаас 68,6 хувь буюу 443 279 нь нийслэл хотод, 31,8 хувь буюу 276064 нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Сургууль

Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч С.Очирбат “Шинээр бага сургууль байгуулах тухай” А/951 дүгээр захирамж гаргалаа. Захирамжийн дагуу боловсролын үйлчилгээг иргэдэд ойртуулж, сургалтын хүртээмж, чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор зургаан бага сургуулийг шинээр үүсгэн байгуулахаар болжээ. Уг шинээр байгуулсан бага сургуульд холбогдох хууль тогтоомжийн дагуу сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгохыг нийслэлийн Боловсролын газарт, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах аж.



Шинэ оны эхэнд Сүхбаатар дүүрэг нэгэн шинэ цэцэрлэгийнхээ өргөтгөлийг ашиглалтад оруулж, бяцхан хүүхдүүдэд хүлээн авлаа. Энэхүү цэцэрлэг нь 109 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Канад модон технологиор барьсан 100 хүүхдийн ортой юм. Дүүргийн XV хорооны 1-24 дүгээр гудамжны цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байсан 60 гаруй хүүхэд ийнхүү шинэ цэцэрлэгтэй болсонд эцэг, эхчүүд нь талархаж байгаа аж. ■



2012 оноос хойш цэцэгжүүлэлт дөрөв дахин нэмэгджээ

ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

Өнгө

Мөрөөдлийн хот

Ц.БАДРАЛ

Амгалан тайван, амьдрахад таатай, стрессгүй хоттой болох нь нийслэлчүүдийн туйлын хүсэл. Өвөлдөө утаагүй, зундаа чимээ шуугиан багатай, хүүхдүүдэд цэцэрлэг нь хүрэлцээтэй, эмнэлэгт орны хүлээлтгүй, ус нь цэнгэг, ургамал цэцэг дэлгэр, яарсан нэгэн нь саадгүй зорчдог, ямар ч үед аюул осолгүй, аз жаргалтай улаанбаатарчууд болоход юу дутуу вэ. Мэдээж олныг нэрлэж болно. Хийх ёстой их зүйл буй. Харин өнгөрсөн хугацаанд юуг хийж амжуулсан билээ.

Энүүхэндээ гэхэд шар хантаазтай хүмүүс хаа таарсан газраа ажлаа хийж л харагдах нь нэг үеэ бодох нь ээ сэтгэлд өөг. Нөгөө талаас нийслэлчүүд ч хүний хөдөлмөрийг хүндэтгэж, үнэлдэг болжээ гэж бодно. Юуны өмнө олон нийтийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөнийг үүнээс ажиглаж болох юм. Энэ нь магад өнгөрсөн хэдэн жилд бий болсон хамгийн

чухал ололт амжилт байж ч мэднэ. Гэхдээ иймэрхүү хийсвэр зүйлд дулдуйдаж боломгүй. Нүдэнд үзэгдэж, гарт баригдах үр дүнгээр л илэрхийлэх нь зүйд нийцнэ.

Улаанбаатарт өдрөөс өдөрт олон зүйл өөрчлөгдөж байгааг бид харж, гэрч нь болж буй. Ойрын жишээ нь зуны улиралд хотын гудамжаар алагладаг нэг наст цэцгүүд. Их мөнгө, зарлагадлаа үрэн таран хийлээ гэж шүүмжилдэг боловч энэ бол хотын шинэ соёл. Улаанбаатарын зун илүү өнгөлөг болсон нь маргашгүй зүйл. Нийслэл 470 мянган га газар нутагтай. Үүний 61 мянга нь суурин газар аж. Гэтэл ердөө 376.07 га нь нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж юм. Үүнд өнгөрсөн жил засаж тохижуулсан цэцэрлэгт хүрээлэн, зам талбай орж байгаа. Ер нь сүүлийн жилүүдэд хотын ногоон байгууламжийг нэмэх ажлыг эрчимтэй хийж эхэлжээ. Тухайлбал, өнгөрсөн онд Хан-Уул дүүргийн нэг-

дүгээр хорооны 13 дугаар байрны урд талбайн 0.45 га тохижилтын ажил, Баянгол дүүргийн 53 га мөрөөдлийн цэцэрлэгт хүрээлэн зэргийг дурьдаж болно. Ногоон байгууламж тохижилтын ажлыг хийснээр хотын өнгө үзэмж сайжирснаас гадна тоосжилт багасах давуу талтай. Тиймдээ ч Цэвэр агаар төслийн хүрээнд олон цэцэрлэгийг байгуулахаар ажиллаж буй.

Өнгөрсөн жил “Улаанбаатар цэвэр агаар” төслөөс Чингэлтэй дүүргийн тавдугаар хороон дахь Тасганы овоо орчмын 1.7 га талбайг “Бичил цэцэрлэгт хүрээлэн” болгон тохижуулж ашиглалтад оруулсан. Тэнд өмнө нь байсан олон жижиг овоог нэгтгэж, усалгааны систем, замын гэрэлтүүлгийг ажиллуулж, нийт таван төрлийн 4129 ширхэг мод, сөөгийг тарьж ургуулжээ. Бичил цэцэрлэгт хүрээлэн 1073 ам.метр явган замтай иж бүрэн ногоон орчин болсон байна. Нийслэлчүүдийн түүх соёлын үнэт зүйлсийн нэг болох Тасганы овоог хүндэтгэх шашны зан үйл сүсэгтэн олны итгэл, бишрэлийг бадраах ном хурах ёслолыг үйлдэж цэцэрлэгт хүрээлэн ашиглалтад оруулснаар нийслэлийн ногоон байгууламж нэмэгдэж, өнгө үзэмж сайжирч, иргэдэд амрах зугаалах таатай ▶

► орчин бүрдэхээс гадна ямар төрлийн мод ургамал ямар хөрс, ус, бордоонд цаг агаарын нөхцөлтэйгөө зохицон ургаж болохыг турших боломж олгож байгаагаараа онцлог юм.

Стрессгүй, уур бухимдалгүй, чимээ шуугиангүй тайван хот болоход нэн түрүүнд шийдэх ёстой тулгамдсан асуудал бол замын хөдөлгөөний нягтрал, ачааллыг сийрүүлэх явдал. Үүнд чиглэсэн хэдэн ажил төлөвлөсөн. Тухайлбал, зуун айл, автомашин, техникийн эд анги худалдааны захуудыг нүүлгэх. Авто худалдааны цогцолборын эхний хэсэг ашиглалтад ороод байна. Худалдаа эрхлэгчид тийш нүүгээд оччихвол хотын зүүн хэсгийн ачаалал үлэмж буурна. Улаанбаатар хотын 25 га талбайд техникийн есөн зах, бусад 27 жижиг цэгүүдээр авто машин, тэдгээрийн дагалдах сэлбэг хэрэгслийн худалдаа явагддаг. Өдөр тутам 8000-10000 хүн эдгээр захыг зорьж байгаа нь хотын замын түгжрэлд үлэмж хэмжээгээр нөлөөлж буй.

Автомашингүй гудамжтай болох шийдвэр гаргалаа. Гудамж төслөөс хэрэгжүүлж байгаа хотын дэд төв төслийн хүрээнд “Автомашингүй гудамж” бий болгон тохижуулахаар төлөвлөсөн. Нийт 20 жилийн хугацаанд хотын төв болон гол гудамжуудыг автомашингүй гудамж болгон тохижуулан худалдаа үйлчилгээ, жуулчны гудамж болгохоор төлөвлөснөөс эхний ээлжинд Чингисийн талбайн ойролцоох дөрвөн байршилд төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүний тулд нэн түрүүнд авто машины зогсоолыг шийдэх хэрэгтэй болж төлөвлөж буй байршилд газар доогуур автомашины зогсоол байгуулахаар болсон юм. Тус зогсоолыг тухайн газрын эзэмшигч байгууллагууд өөрийн хөрөнгөөр хийхээр урьдчилан тохиролцжээ.

Өөр нэг шийдвэрийн тухай цухас дурьдахад Улаанбаатар хотын брэндбүүк буюу хотын ерөнхий өнгө төрх, гудамж талбайн тоноглол, барилга байгууламж, төрийн үйлчилгээ, хувцаслалтын өнгө, дизайныг хэн ч хаанаас харсан шууд таних брэнд бий болгох ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаяг, зар сурталчилгааг Монгол бичгээр бичих төслийг боловсруулж эхэлжээ.

Соёл урлаг талаас нийслэлийн өнгө төрхийг чимж буй зүйл ч мөн их. Ялангуяа зуны улирлыг уйдаагүй өнгөрүүлдэг болсон. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлчүүд сонгодог урлагийн сор бүтээлүүдийг задгай тайз-


наас үзэж, төв талбай дээрээ Венийн вальс эргэлдэн бүжиж, Жазз хөгжим, соёл урлагийн оддын уран бүтээлийг үзэж баясдаг уламжлал тогтоод байна. Эрүүл амьдралын хэв маягийг эрэлхийлдэг иргэд нэг өдөр автомашинаа гэртээ орхин дугуй унаж, явган алхан, марафон гүйж бусдадаа эрч хүч бэлэглэдэг. Мөн хөтөлбөрийн хүрээнд урласан 3D зургууд жилийн турш хотын гудамжинд дулаан өнгө нэмсээр байгаа билээ. Төслийн хүрээнд Зүүн дөрвөн замын

уулзвараас баруун дөрвөн замын уулзвар хүртэл ашиглагддаггүй болон хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлөхүйц 16 байршилд бодит мэт сэтгэгдэл төрүүлэхүйц зураг зурсан нь залуусын болоод жуулчдын дурсгалын зургаа татуулдаг цэг болоод байгаа билээ.


Мөрөөдлийнхөө хотыг бий болгохын төлөө хийх ажил их буй. Түүний төлөө хийж буй ажил ч багагүй. Алдаа дутагдал байв ч эсрэгээрээ юу ч хийхгүй бол хамгийн том алдаа тэр болох биз ээ. ■

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хот тохижилт, ногоон байгууламж



Мод, сөөгний хэмжээ 5 дахин өссөн.
Зүлэг тарилт 3 дахин нэмэгдсэн.
Цэцэгжүүлэлт 4 дахин нэмэгдсэн.
Зэрлэг ургамлын устгал 3 дахин нэмэгдсэн.
Ногоон байгууламжийн арчилгааны түвшин 7.5 дахин нэмэгдсэн.



- Нийт 2145ш сандал, 2340ш хогийн сав байрлуулсан.
- 2013 оноос шинээр 223061м² явган хүний зам тавьсан.
- Өнгө үзэмж, аюулгүй байдалд өндөр түвшний шаардлага хангаагүй гадна сурталчилгааны байгууламжийг 3 дахин бууруулсан.
- 12ш усан оргилуурын урсгал засварын ажил хийсэн.



Хөгжил

Э.Бат-Үүл: Бид гурван том динозаврыг хөдөлгөхөд л өндөр хөгжилд хүрнэ

Д.БЭХЭЭ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлтэй ярилцлаа.

-Улаанбаатар хотын 2015 оны өнгө ямар байдалтай өнгөрсөн бэ, хотын бодлого, үйлчилгээ, төсөл хөтөлбөр ажлуудыг дүгнээд хэлбэл?

-Миний нэг зарчим байдаг. Би ийм тийм юм хийсэн гэхээс илүүтэй бидний юу хийснийг иргэд үнэлж дүгнэж хэлэх хэрэгтэй л дээ. Гэхдээ хийсэн асуусан болохоор ажлуудынхаа талаар товчлон хэлэхэд өнгөрсөн хугацаанд нийслэлийн замаа шинэчлэх, ялангуяа захын дүүрэг, хотхонуудыг хотын төвтэй холбосон замуудаа засварлаж, сургууль цэцэрлэгүүдийг нэмж барилаа. Иргэдээс хамгийн их талархал хүлээсэн нь бага сургууль, цэцэрлэгийн хэд хэдэн цогцолбор барьсан. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил явсан гэх мэт бүтээн байгуулалтын олон ажлыг дурдаж болно.

Үүн дотроос зориуд онцолж хэлэх хамгийн том ажил бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн тээврийн шинэчлэлийг хийж чадсан. Ухаалаг картын систем рүү шилжсэн. Хүн харахад картаар төлбөр хийдэг л систем шиг боловч үнэндээ маш том хэмжээний бүтцийн өөрчлөлт хийсэн. Нийтийн

тээврийн компаниуд оператор компаниуд болж хувирсан. Нийтийн тээврийн компаниудад чиглэлүүдийг хуваарилж өгснөөр тэд орлогын, тооны хойноос хөөцөлддөг биш шугам дээрээ цагийн хуваариар ажилладаг систем рүү орлоо.

Бусад газарт ийм шилжилт хийхэд амаргүй байх байсан. Бэлэн мөнгө эргэлдүүлж сурсан энэ салбарт картын системийг нэвтрүүлэхэд эсэргүүцэлтэй ихээхэн тулсан байдаг. Бэрхшээл бол байсан. Гаднынхан биднийг гайхаад байгаа юм. Ямар богино хугацаанд энэ ажлыг хийчихэв гээд. Ер нь тэрбум тэрбум төгрөгийг гар дээрээ бэлнээр эргэлдүүлж байсан компаниуд операторын үүрэг гүйцэтгэнэ гэхээр сайхан хандахгүй. Сайн дураар явах ажил биш. Харин манай нийтийн тээврийн компаниуд бидний иргэддээ үйлчлэх үйлчилгээг сайжруулах зорилготой энэ ажлыг ухамсарлаж хүлээж авсан. Бид иргэдээ бараа ачсан юм шиг авч давхидаг байдлыг л халахыг хүссэн. Хотын энэ бодлогыг нийтийн тээврийнхэн ойлгож дэмжсэн учраас богино хугацаанд хэрэгжээд эхэлсэн.

-Улаанбаатар хот бизнесийнхэнтэй албан ёсоор түншлэлд нэг жил боллоо. Энэ хугацаанд түншлэл ямар байдалтай явж ирэв?

-Хувийн хэвшлийнхэн хоттой

түншлэхийн тулд зохион байгуулалтад орох ёстой. Энэ зохион байгуулалтаа тэд хийсэн. Танхимаа байгуулж, дэргэдээ Арбитртай боллоо. Арбитр нь төр, хувийн хэвшлийн түншлэлд/PPP/ маш чухал. PPP-гээр явах гэрээнүүдээ арбитр дээр бүгдийг бүртгүүлдэг байх ёстой. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд гэрээнээсээ эхлээд хэрэгжилт хүртлээ тэгш бус зарчим үйлчилдэг шүү дээ. Тухайлбал, хувийн хэвшлийнхэн л хохироод дуусдаг. Төр үүргээ биелүүлдэггүй. Шүүхэд хандахаар хүнд сурталтай, хугацаа их авдаг, шударга бусаар шийдэх хандлагатай. Харин Арбитр өөр. Гэрээнд маргаан үүсвэл талууд тэгш эрхтэй оролцдог онцлогтой. Хот, бизнесийн хооронд маргаан үүслээ гэхэд хувийнхан төлөөний арбитрчаа, хот ч өөрийн төлөөний арбитрч гаргах замаар

оролцогч талуудын тэгш байдлыг хангаж, илүү шударга шийдвэр гаргаж чаддаг. Одоо хотоос төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдээ хотын танхимын арбитрт бүртгүүлнэ. Гэрээний үүрэг биелүүлээгүй бол арбитр хотод торгууль хүлээлгэдэг, хариуцлага тооцдог ийм зарчимтай ажиллана.

Мөн Улаанбаатар хотын танхимтай хамтраад дундаасаа Нийслэлийн хөгжлийн корпорацийг байгууллаа. Энэ бол засаг захиргааны байгууллага биш. Хотын мэдлийнх ч биш. ТУЗ-ийн есөн гишүүний гурав нь л хотын төлөөлөл, бусад нь хувийн хэвшил, хараат бусад гишүүд. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гол байгууллага байх юм. Түншлэлийн бэлтгэл ажлуудыг нэг жилийн хугацаанд хийгээд бараг дууслаа. Гэхдээ PPP-н түншлэл яваад л байсан шүү. Гэр хорооллын дахин төлөвлөлт, нийтийн тээврийн шинэчлэл гэх мэт. Урсгалын шинжтэй явж ирсэн. Одоо бол албан зохион байгуулалтад орж байгаа юм. Гол шаардлага нь олон улсын санхүүгийн зах зээл дээрээс хамтраад мөнгө босгох. Сайн ТЭЗҮ хийгээд, хувийн хэвшлийнхэнтэйгаа хамтраад очвол мөнгө өгье гэсэн санал олон байна. Тэнд их мөнгө байна.

-Бусад улсын нийслэл нь гадаад, ▶

► **дотоодын хөрөнгө оруулалтаар хотоо цэцэглүүлэн хөгжүүлсэн байдаг. Өнөөдөртөө гадаадын хөрөнгө оруулалт УБ-аас дайжчихсан байгаа. Энэ дайжсан, бас хилийн чанадаас хөрөнгө оруулалтыг татахын тулд засаг, юу хийх шаардлагатай байна вэ?**

-Манайд аймшигтай нэг зүйл байна. Бидний hardware-ийг социализмын үед олж авсан коммунист software ажиллуулдаг байна. Энэ нь хөгжилд хамгийн том гай болж байна. Гадаадын хөрөнгө оруулагчийг колончлогч гэж харах жишээтэй. Шулаачин ирлээ гэж үзэх. Тэдэнд дайсагнах байдлаар ханддаг. Социализмын үед хөрөнгө оруулагчийг колончлогч гэж нэрлэдэг тэр сэтгэлгээ хэвээр байна. Тэдэнд найрсаг биш байна. Ийм сэтгэлгээ, ийм уур амьсгалтай оронд хөрөнгө оруулалт биднээс нэг л цэрвэсэн байдалтай байна.

Энэ дэлхий дээр хөгжлийн нэг л хууль үйлчилдэг. Тухайн улс орон хөгжихөд хөрөнгө оруулалт л урсаж орж ирэх ёстой. Тэгвэл хөгжинө. ОХУ-ын Ерөнхийлөгч Путин гадаадын хөрөнгө оруулагчдыг эх орондоо хөрөнгө оруулахыг уриалаад гуйж байна. Хойд хөрш маш их баялагтай, чадалтай том гүрэн. Гэтэл Ерөнхийлөгч нь том форум зохион байгуулж, хөрөнгө оруулалтын орчноо танилцуулаад л хөрөнгөө оруулахыг барууныхнаас гуйж байна. Нөгөөдүүл нь хориг, улс орны янз бүрийн харилцаанаас болоод Оросод хөрөнгөө оруулахгүй байх шиг байна. Хятадын Ерөнхийлөгч ч гуйж байна. Дэлхий дээр эдийн засгийн хамгийн гайхалтай амжилт үзүүлж байгаа улс орон ч хөрөнгө оруулахыг гуйж, хүсэж байна.

Хөрөнгө оруулалт татахгүйгээр ямар ч улс орон хөгжихгүй. Ямар ч ухаантай хүн байгаад хөрөнгийн хомсдолтой бол хөгжихгүй ээ. Техник технологи, ноу хау бүгдийг оруулж ирэх ёстой. Гэтэл бид хөрөнгө оруулагчдыг колончлогч гэж хараад суугаад байдаг. Энэ сэтгэлгээ хөгжлийг баллаж байна. Тухайлбал, Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 18-20 тэрбум ам.доллар хэрэгтэй. Манайд ийм мөнгө байхгүй. Хөрөнгө оруулалтыг үргээсэн хүмүүс манай хотын ажилгүйдлийг яах гээд байгаа юм бэ. Нийслэлийн иргэдийн ядуурал ихслээ. Хөрөнгө оруулагчдын хүчээр ажлын байр олноор бий болно.

Бид орлоготой болно. Манай хөрш том гүрнүүд хөрөнгө оруулалт татахын төлөө хөлөө хугалахаас ч наагуур явж байна. Гэтэл бид юунд пээдийгээд байгаа юм бэ. Ажилгүй, орлогогүй, бизнесгүй суугаад байх уу. Иргэдээ улам л ядууруулаад байх уу. Популизмын гайгааг салмаар байна.

-Хотод ядуурал ихэслээ гэлээ. Хир ихэсэн бол?

-Хөрөнгө оруулалт дайжиж, уул уурхай зогссоноор энэ салбарт ажиллаж байсан 50 мянган хүн ажилгүй болсон. Өрхийг гурван ам бүлтэй гэж тооцвол 150 гаруй мянган хүн орлогын эх үүсвэрээ алдлаа. Ядуурал хотод үнэхээр хүнд болж ирлээ. Гэр хороололд ядуучуудын тоо 86 хувьд хүрчихлээ. Хөрөнгө оруулалт, бизнес зогсчихсонтой холбоотойгоор.

-Нийслэл, Улаанбаатар хотын танхим хамтраад энэхүү чуулганыг хоёр дахь жилээ хийж байна. Энэ жилийн сэдэв Хотын худалдан авалт. Хот ямар зүйлс худалдан авахаа танилцуулах уу?

-Өнгөрсөн жил нийслэлийн зүгээс 300-гаад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Төсвөө батлуулахдаа би хэлж байсан. "Хөрөнгө оруулалт дайжлаа. Хомсдлоо. Үүнээс улбаалан ажилгүйдэл, ядуурал хүчээ авлаа. Зөөллөх, сааруулах хэрэгтэй байна. Үүний тулд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлье" гэж. Манайхны тооцоогоор 30-50 мянган ажлын байр бий болох дүр зураг өнгөрсөн жил харагдаж байлаа. Үнэндээ бол 2015 онд хотод л ажил явсан шүү дээ. Бусад газар зогссон. Үр дүнд нь ажилгүйдэл,

ядуурлын их өсөлтийг бууруулах гэж оролдлоо. Энэ жил дахин ийм хэмжээний хөрөнгө оруулалт хийнэ. Дээр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө гаргуулна. Хотын зүгээс ажилгүйдэл, ядуурлыг л бууруулах оролдлого дахин хийнэ.

Худалдан авалт гэдэг бол зам, барилга, сургууль, эмнэлгээ яриад байгаа юм. Хотоос мөнгө өгье, та нар бариад өгөөч л гэж хэлээд байгаа хэрэг. Зөвхөн худалдан авалтаар хязгаарлахгүй. Хувийн хэвшлийнхэнтэйгээ хамтраад олон улсын зах зээлээс мөнгө босгоно. Нэг л зүйл ойлгох хэрэгтэй. Би иргэдээ ажилтай, орлоготой байлгамаар байна. Тиймээс миний хувьд хөрөнгө оруулалт оруулж ирэхийн төлөө Путин, Си Жинпинээс дутахгүй л гуйж явна. Уг нь УИХ өөрсдөө Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий

төлөвлөгөөг баталж өгсөн. Биелүүлэх үүрэг нь яамд, Засгийн газарт байгаа. Гэтэл зөвхөн хот руу асуудлыг чихчихээд яваад байж болохгүй санагдана.

-Энэ онд улс орны эдийн засаг ямар байх бол?

-Нэлээд хүнд байх болов уу. УИХ-ын сонгууль болно. Угаас ааш нь олддоггүй хувирамтгай хүмүүс, дээрээс нь засаг солигдоно гээд хөрөнгө оруулагчид карданаа бүр татаад эхэлчихсэн. Харин Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Оюутолгойн гүний уурхайн төслийг урагшлууллаа. Саарал, хар бараан талдаа байсан эдийн засаг, нийгэмд гэрэл гэрээ өгсөн. Баярлаж байна. Оюутолгой бол динозавр. Энэ аварга үлэмж биетнийг дагаад маш их зүйл орж ирнэ. Их итгэл, найдвар төрүүлж байна.

Дараагийн том динозавр бол гэр хороолол. Энэ том ажлыг хөдөлгөх гэж байна. Гэр хорооллын газар нийтдээ 7,2 тэрбум ам.долларын актив. Оюутолгойгоос дутахгүй том төсөл. Тэгэхээр Оюутолгой, гэр хороолол, Тавантолгой гэсэн том гурван төслийг хөдөлгөхөд л манай улс гайхамшигтай эдийн засгийн өсөлтийг 20 жилд барьж чадна. Баталгаатай. Гэр хороололд 200 мянган айл газраараа хоршоод хөрөнгө оруулалт хийж орон сууц барина. Шинэ Улаанбаатарыг сүндэрлүүлэхийн хирээр эдийн засгийн эрэлтийг өндөр хэмжээнд байлгаж чадна. Хүмүүс хөшиг оёж, модон тавилга хийж эхэлнэ. Дотоодын үйлдвэрлэл босоод ирнэ. Дагаад ажилгүйдэл байхгүй болно. Газрыг эргэлтэд оруулснаар ажилгүйдэл, ядуурлын асуудлыг шийдчихнэ. 20 жилийн хугацаанд шүү. Дээрх гурван динозаврыг хөдөлгөчихвөл харин 2016 он хямралыг сөрсөн жил болно.

-Хөдөлгөхгүй бол?

-Бүх юм зогсоно. Бүр хүнд байдалд орно.

-Нийслэлийн иргэдээ татвар аваад эхэлчихсэн. Энэ ажлын явц ямар байна вэ. Татварын орлогыг юунд зарцуулах юм бэ?

-Дөнгөж эхэлж байгаа ажил. Урамшуулал, янз бүрийн арга хэмжээ авахаар ярьж байна. Бээжин хотод нэг туршлага байна. Иргэдийн авах талон, тасалбар дээр нь тоо тавиад сугалаа болгочихдог юм байна. Тэгэхээр хүмүүс тасалбараа дэлгүүр хоршоо, үйлчилгээний газруудаас их авдаг. Хотын татвар бол аж ахуйн нэгжид ногдуулсан татвар биш. Аж ахуйн нэгж нь татвар хураагч болж, татвар нь иргэнд ногдож буй юм. Дээрээс нь хотын ►

► иргэний татварыг юунд зарцуулдгыг хянах зорилготой татвар төлөгчдийн төлөөллөөр Удирдах зөвлөлийг байгуулна. Тэднээс бид зөвшөөрөл авч, ажилдаа зарцуулна. Эргээд аялал жуулчлал татах, бизнесийн хэрэглээ, эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлд зарцуулах татвар. Бусад улс ч ийм замаар явдаг.

-Их хотын хөгжлийг дагаад сайн ч, саар ч зүйл бий. Хотын удирдлагын хувьд улсын нийслэлд хамгийн ихээр тулгамдсан ямар асуудал байна, давах гарц шийдэл юу байна вэ?

-Хот сайн засаглалтай л болох ёстой. Эдийн засгийн зогсонги байдал, өнөөгийн хөгжлийн дэгэн догонтон байдал явж явж засаглал муу байгаатай холбоотой. Монголчууд гайхалтай ухаантай үг хэлдэг. Дээдх нь суудлаа олохгүй бол доодох нь гүйдлээ олохгүй гэж. Хөгжлийг муу засаглал гацааж байна. Түүнээс дэлхийн хямрал руу чихэх гээд байх хэрэг байхгүй. Бид сайн засаглалтай байсан бол хямралыг сөрж зогсох боломжтой байж. Засгийн газрын ордны зүүн талын хэвлэлийн үйлдвэрийн багахан талбай ямар үнэд хүрэв. Эдийн засаг хямарсан үед үнэд хүрлээ. Тэгвэл өсөлттэй үед бүр л том дүнд хүрэх нь.

Урд нь ийм замаар газруудаа үнэд хүргэсэн бол гэр хорооллыг орон сууцжуулах хэмжээний мөнгө босгох байсан байна. Энэ мөнгө хаашаа алга болчихов. Муу засаглалын гай энэ. Хотыг дээд зэрэглэлийн өндөр технологийн дэд бүтцээр хангах л байлаа.

-Улаанбаатар хотын засаглалыг сайжруулах чиглэлд та юу хийсэн бол?

-Асуудлыг ил тод, иргэдийн оролцоотойгоор шийддэг болгож байна. Дэлгүүр шиг хурдан үйлчлэх зорилготой төрийн үйлчилгээний супермаркет нээлээ. Ажил хийж буй хүнд саад болохгүй, хурдан үйлчилдэг систем нэвтрүүлэх нь чухал байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл бол засаглалыг сайжруулах нэг том хэлбэр. Хувийн хэвшлийнхэн эрсдлээ хүлээсэн байдаг. Төр муу ажиллавал эрсдэлтэй. Бизнесмэнүүд зөвшөөрөхгүй. Түншээ сайн засаглалтай, хурдан үйлчилгээтэй байхыг тэд шаардана. Тэд муу түнштэй, муу засаглалтай төртэй хамтрахыг, түншлэхийг хүсэхгүй. Хоёулаа л сайн засаглалтай байж олон

улсын зах зээлээс мөнгө босгоно шүү дээ.

Харин манай улстөрчид нэг зүйлийг ойлгох цаг болсон. Сэтгэлийнхээ гүнээс ойлгоосой. Бид энэ оронд л амьдарна шүү дээ. Зугаах гээгүй л юм бол. Гэр орноо өөд татмаар байна. Юун их шунал вэ, юун их хувийн сонирхол вэ. Шунаад байхааргүй л амьдарч байгаа. Орлогогүй, ядуу амьдарч буй иргэдээсээ ичдэггүй юм уу.

-Иргэд бас бизнесмэнүүд шилэн, тунгалаг хоттой болохыг хүсэж байгаа.

-Дансаа, гүйлгээгээ, төсвөө ил



Э.Бат-Үүл: Юун их шунал вэ, юун их хувийн сонирхол вэ

тод болгож байна. Нэг сонин зүйл ажиглагдлаа. Шилэн дансыг иргэд ерөөсөө сонирхохгүй байна. Харин улстөрчид хааяа шүүрч авах юм. Тухайлбал, хотоос Мобиком руу иргэдийн утгах үйлчилгээний утасны зардал 20 сая төгрөг шилжүүлсэн юм. Гэтэл нэг хүн шүүрч аваад Бат-Үүл даргын утасны төлбөрт 20 сая төгрөг өгсөн байна лээ гэнгүүт бүгд тийм юм байна гэж ойлгогчихно. Би үүнийг ихэд гайхсан. Шилэн данс нийтийн хэрэглээ биш, улс төрийн хэрэглээ болоод байна. Би Тамгын газрынхандаа шилэн дансыг олон нийтийн зөв хэрэглээ болгох, хүмүүст ойлгуулах талаас санал санаачилга гаргаж ажиллах талаар хэлсэн байгаа.

-Ер нь Монгол Улс түүхэндээ нийслэлдээ нэг сая хүн амтай, суурьшмал байдлаар амьдарч байгаа. Нүүдлийн хүмүүс нэг дор суурьшмал суурин нөхцөлд амьдрахад багагүй л түвэгтэй асуудалтай учирдаг байх.

-Энэ бол гайхамшиг. Хүмүүс буруу ойлгоод байна. Хөдөө орон нутгаас

хүмүүс ирээд зах зээлийг томруулж байгаа нь том хотын хөгжлийн өмнөх бэлтгэл юм. Хотод хүн битгий ирээсэй гэж боддог дарга бол тэнэг хүн. Хүн ирж л байвал тэр хот сайн байна гэсэн үг. Улаанбаатар хотын хүн ам өссөнөөр зах зээл хоёр дахин өслөө. Гол хүндрэл нь хөдөө орон нутгаас хүмүүс гэрээ ачиж ирээд хашаанд барьж, нүх ухаад хүндэрчихээд байгаа юм. Энэ асуудлыг л шийдчих хэрэгтэй. Нийслэлд хүмүүс ирснээр Улаанбаатар саятан, дэлхийн том хотуудын нэг боллоо. Хөгжлийн гарааны бэлтгэл яваад байна.

Тиймээс хашаатай иргэдээ хашаа, газраараа хоршчих. Дээр нь орон сууц бариад өөрсдөө ороод илүүг нь зарж худалдаж бизнес хий гэж байгаа юм. Гэр хорооллынхон маань ханцуй шамлан орчихсон явж байна. Тэд нөхцөлийг бүрдүүлээд өгөхөөр сэтгэж, санаачилж эхэллээ. Том том төлөвлөлт хийж газраа хоршоод 280 иргэн ороод ирлээ. Энэ хавар ажлыг нь эхлүүлнэ. Газар бол мөнгө. Дэлхийд газар, алт хоёр шиг мөнгө болох чадвартай зүйл байдаггүй.

-Нийслэлд томоохон төслүүд эхэлчихсэн явж байгаа. Харин зургаахан сарын дараа гарч ирэх шинэ засаг

захиргаа эдгээр төслийг үргэлжлүүлэх эсэхэд иргэд, бизнесмэнүүд санаа зовж байна. Манайд өмнөхөө шинээрээ солиод л үр дүнг нь үздэггүй уламжлал тогтсон шүү дээ.

-Гэр хорооллын эхлүүлсэн ажлыг зогсоох зүрх хэнд ч байхгүй ээ. Зогсоовол хотын дарга долоо хонохгүй, суудал дээрээ. Нээрээ шүү. Миний хувьд зогсоох гэдгээс айхгүй байна. Чадахгүй, харин буруу хэрэгжүүлэх вий л бодож байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хоёр үе шаттай хийж байгаа. Эхнийх нь хөрөнгөтэй компаниудыг урьж оруулж ирээд газрын эзэдтэй ярьж зөвшилцөж, газрыг эргэлтэд оруулаад үнэ цэнэтэй болгосон.

Дахин төлөвлөлт эхлэхээс өмнө газар ямар үнэтэй байсан, өнөөдөр ямар үнэд хүрэв. 10, 20 дахин өслөө. Өнөөдөр газар үнэ цэнэтэй хөрөнгө болчихсон учраас компаниудаар дахин төлөвлөлт хийлгэх ажлыг зогсоосон. Газрыг өндөр үнэтэй болголоо, баярлалаа. Одоо харин иргэдийг газраа барьцаалаад өөрсдөө орон сууцаа ►

► барь гэж байгаа. Нэг динозаврыг л амьруулах гээд байгаа хэрэг.

-Та бүхний гурван жилийн өмнө эхэлж дэвшүүлсэн хашаандаа хаус барих санал мөн үү?

-Тиймээ. Тухайн үед шууд эхлүүлэх гэхээр газар үнэгүй, тавхан сая төгрөгийн үнэтэй байгаад байсан юм аа. Барьцаалах гэхээр хаусын үнэд ч хүрэхгүй. Одоо газар үнэтэй гэдгийг иргэд ойлгосон.

-Хөгжлийн корпорацийн системийг Монголд байхгүй зүйл гэж бизнесмэнүүд үзэж байгаа. Өмнө нь асуудлыг зөвхөн засаг захиргааныхан л шийддэг байсан бол одоо хувийн хэвшлийнхний оролцоотой шийдэх нь гэж.

-Хотын хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь цаашид Хөгжлийн корпораци байна. Төр, хувийн хэвшлийнхнийг уулзуулдаг цэг нь байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайн явуулж чадах юм бол эхний ээлжинд ногоон хөгжлийг дэмжих үүднээс бид нэлээд их хөрөнгө босгохоор ажиллаж байна. Олон улсын зах зээл дээрээс босгох боломж байна. Би бизнесмэнүүдтэйгээ хамтраад түншлээд тийшээ очно гэсэн үг. Хувийн хэвшлийнхэн эрсдэл хүлээх чадвартай учир асуудалд хэрсүү ханддаг. Төр нь баталгаа болно. Амжилт олно гэдэгт эргэлзэхгүй байна. АХБ болон бусад олон улсын байгууллагууд энэ санаачлага, ажлыг маш их дэмжээд байгаа.

-Монгол Улсад нүүрлэсэн улс төрийн хямралыг та хэрхэн харж байна вэ?

-Хамаг бүгдийн шалтгаан нь төрийн эрх мэдэл хувь хүмүүсийн бизнесийн хэрэгсэл болсон байна. Өөрөө өөрийнхөө бизнесийг хийх хэрэгсэл болгочихлоо. Энэ бол ардчиллын нэр хүндийг барлаа, эдийн засгийг унагалаа. Зах зээл дээр бизнес хийж, чөлөөт эдийн засгийн боломжийг ашиглаж чадахгүй хүмүүс төрд олноор орж ирсэн. Тэгээд төрийн эрх мэдэл ашиглаж бизнес хийдэг болсон. Монголд хоёр төрлийн бизнес байна. Зах зээл дээр ажиллаж буй нөгөө нь төрд ажиллаж буй бизнесийнхэн. Төрд орсон нь төрийн эрх мэдлийг ашиглаад зах зээл дээр ажиллаж буй бизнесмэнүүддээ гай болж, зах зээлийг хүчээр булааж авч, ажлыг нь зогсоогоод байна. Үүнээс болж хамаг зүйл гацаж байна.

Би алив зүйлийг хөөрүү, хийсвэр байдлаас биш нэлээд хянуур ярихыг боддог хүн. Нэг л зүйлийг баттай хэлье. Дээдх нь суудлаа зөв олоод засаглалаа сайжруулж чадавхжуулаад явах юм бол манай улсын ойрын 20 жил дэх эдийн

засгийн өсөлтийг хэн ч гүйцэхгүй. Ийм ирээдүй харагдаж байна.

-Хотын дарга Э.Бат-Үүл гэж хүнийг магтах ч юм, шүүмжлэх ч юм. Бас олон асуудлаар оролдох ч юм. Та залхдаг уу?

-Би ч хувьдаа асуудалгүй. 20 настайдаа хийсэн миний сонголт. Харин гэр орон, үр хүүхдэд маань л хүнд байдаг

байх. 30 жил бид ингэж явлаа, 30 жил хэлмэгдэж түүртэж ирлээ. Одоо өөрөөр амьдарч болохгүй юм уу. Болж өгвөл хотын даргын суудлаа өгчих гэх гээд л.. Би үнэндээ үр хүүхдээ, ач зээгээ сайхан хотод л амьдруулахыг хүсэж байна. Бусад сайхан хотод очиж агаархаж явдгыг нь болиулмаар байна. Миний зорилго л энэ. ■

Дахин төлөвлөлт

Дарь гуай “моодноос” гарсны маргааш

Г.ОРХОН

...Хүүхээн энд юу болох гэж байгаан.

-Ажил хийж байна шүү дээ. Эмээ та жаахан хоошоо болоод өгөөч.

-Күй Хойлоог чи дуугүй байгаад өгөөч. Ямар ажил болохоороо айлын гадна эрээн мод барьж зогсож байдаг байна аа...

Энэ бол 1960-аад онд бүтээсэн өнөөгийн 40 мянгатын бүтээн байгуулалтын талаарх “Аман хуур” киноны хэсэг. Хот тохижуулах газрыг “бусниулах” газар хэмээн газраа чөлөөлөлгүй улсын ажил уядаг зөрүүд Дарь гуайн дүр уншигч таны ойлголт тодорч байгаа биз. 2013 оноос Нийслэлийн захиргааныхан Гэр хорооллыг дахин төлөвлөж барилгажуулах төслийг хэрэгжүүлэхээр болж, гэр хорооллын зарим өрхийг

нүүрсний “машинаа” халаалтаар солих боломж олгосон юм. Улмаар иргэд эл төслийн талаарх мэдээлэл дулимаг байсан тул учраа ололгүй Дарь гуайн түүхийг эргэн сөхөхөд хүргэсэн үе өчигдөрхөн. Харин өнөөдөр Дарь гуай нар “моодноос” хэдийнэ гарчээ. Гэр хорооллын нийт иргэний 71 хувь нь уг төслийг дэмждэг болж хашаагаа байраар солих хүсэлтэй байна. Зөвхөн хашаагаа гэлтгүй Хан-Уул дүүргийн 10-р хорооны иргэн С.Бэхжихийн адил хуучин байраа шинээр солих бодол өвөртлөн яваа хүн олон бийг төслийн багийнхан онцлов. Үүнд, тортог суусан бор гэрүүдийн дунд шил даран сүндэрлэж буй орон сууцны бүтээн байгуулалт нөлөөлсөн нь дамжиггүй. ►



Гэр хорооллын нийт иргэний 71 хувь нь хашаагаа байраар солих хүсэлтэй байна

► Ер нь төслийн эхний ээлжийн барилгууд ашиглалтад орохоор компаниуд түрээсийн зардлаас чөлөөлөгдөх, их хэмжээгээр газар чөлөөлөх боломж бүрддэг аж. Улмаар бүтээн байгуулалтын ажил эрчимждэг байна.

Өдгөө дахин төлөвлөлтийн төслийг нийслэлийн гэр хорооллын нийт нутаг дэвсгэрийн 14 хувьд хэрэгжүүлж буй. Одоогийн байдлаар 2100 гаруй иргэн газраа чөлөөлөн тохилог сууцандаа тухлаад байгаа төдийгүй уг төсөлд хотын хүн амын есөн хувь буюу нийт 78 мянга гаруй хүн хамрагдаад байна.

2014 онд 580, өнгөрсөн жил 1656 айлын орон сууц ашиглалтад оржээ.

ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД АШИГЛАЛТАНД ОРОХ ОРОН СУУЦ:



1104

2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛД АЙЛЫН ОРОН СУУЦЫГ
АШИГЛАЛТАНД ОРУУЛНА

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Баганат өргөө ХХК – 144 айлын орон сууц
Гангар инвест ХХК – 168 айлын орон сууц
Зургаан талт ХХК – 150 айлын орон сууц

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

262 айлын орон сууц
Стандарт проперти групп ХК

320 айлын орон сууц
Хера пропертийз ХХК

СҮХБААТР ДҮҮРЭГ

60 айлын орон сууц
Пример инвестмент групп ХХК

Харин энэ оны эхний хагаст 1100 гаруй айлын орон сууцыг ашиглалтад оруулах бөгөөд 2016 ондоо нийт 4000 гаруй иргэн тохилог сууцанд орох нь. Түүнчлэн, гэр хорооллыг дахин төлөвлөж барилгажуулах ажилд хүч нэмэн Азийн хөгжлийн банкны зээлийн тусламжтайгаар хотыг дэд төвтэй болгох ажил зэрэгцэн явж буй. 2013 онд Нийслэлийн удирдлага хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагыг УИХ-аар батлуулсан. Энэ хүрээнд хотыг зургаан дэд төвтэй болгохоор болсон бөгөөд эхний хоёр Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ажлыг АХБ-ны тусламжтайгаар хэрэгжүүлж буй.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг нийслэлийн 24 байршилд 38 аж ахуйн нэгж хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд буюу 2020-2022 он хүртэл нийт 80 гаруй мянган айлын орон сууц барихаар төлөвлөснийг Гэр хорооллын хөгжлийн газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга М.Энхбаатар яриу.

Тэрбээр “Уг ажлын бэлтгэлд ихээхэн хугацаа шаарддаг бөгөөд наад зах нь төслийн гүйцэтгэгч компанийг дөрвөөс таван сарын хугацаанд сонгон шалгаруулдаг” гэсэн. Компанийн хувьд бусдын өмч дээр барилга барьж байгаа учир иргэдтэй ойлголцохоос гадна гэр хорооллын ихэнх газар инженерийн зураг төсөл хийгдээгүй зэрэг хүндрэл багагүй бий. Мөн тэд орон сууц барих зардал, газраа чөлөөлсөн иргэдийн түрээсийн зардлыг хариуцдаг. Гэсэн ч гуравхан жилийн хугацаанд 7300 гаруй айлын орон сууцны ажил эхлүүлээд байна. Одоогийн байдлаар нийт 1360 айлын 86.5 га газрыг чөлөөлжээ.

Дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд төр, аж ахуйн нэгж, иргэн гурав маш хурдан ойлголцож буйг япончууд гайхаж байгаа тухай хотын дарга ярьсан удаатай. Учир нь гурван тал дахин төлөвлөлт хийе гэх нэгдсэн ойлголттой байгаа тул энэ ажил харьцангуй хурдацтай урагшилж байгаа юм.

Иргэд газраа ганцхан байраар солих хүсэлгүй бөгөөд гэрээ хэлцлүүдээс харахад дийлэнх нь 2-3 байраар сольжээ. Мөн хашаандаа үйлчилгээний газар ажиллуудаг байсан айл газраа байр болон үйлчилгээний талбайгаар сольж буй. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн

Нийслэлийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн Эх сурвалж: “ММСГ” ХХК



зургадугаар хорооны иргэн Л.Батжаргал 500 ам.метр хашаа, 117 ам.метр бүхий цайны газраа ийн сольсон байх. Тэрбээр өдгөө дахин төлөвлөлтийн салхийг хагалсан анхны 168 айлын орон сууцанд хоёр өрөө байрандаа тухлан, 80 ам.метр бүхий талбайд ресторан ажиллуулж байна. Багжаргал өвөлд нүүрс, модыг хэдэн шуудайгаар нь өрдөн байж цайны газраа ажиллуулж амьжиргаагаа залгуулдаг байсан бол өдгөө эдгээрийг умартан хотын төвийн сайн үйлчилгээтэй газраас дутахааргүй ресторан ажиллуулж байна.

Гурван тал дахин төлөвлөлт хийе гэх нэгдсэн ойлголттой байгаа тул энэ ажил харьцангуй хурдацтай урагшилж байгаа юм

Гэр хорооллыг орон сууцжуулж иргэдийн амьдралыг ийнхүү сайжруулах нь Нийслэлээс зорьж буй гол зорилго аж. Өмнө нь утаан дунд амьдарч байсан иргэдийн адаглаад амьдрах орчин нь сайжрахад хүүхдүүдийн сурах өсөх орчин, ахуй амьдралд багагүй өөрчлөлт бий болж буй.

Гэхдээ уг төсөлд хамрагдсан зарим иргэний чөлөөлсөн газарт одоог хүртэл орон сууцны барилга баригдаагүй асуудал бийг дурьдах хэрэгтэй. Үүнийг Гэр хорооллын хөгжлийн газрынхан “Энэ бол ганцхан байшин барихтай адилгүй” хэмээн тайлбарлав. Гэр хорооллын дахин төлөвлөх ажил нь хөрөнгө оруулалт, дулаан цэвэр бохир ус бусад нийгмийн дэд бүтэц зэрэг хорооллын хэмжээнд барих учир дан ганц байшин барихтай адил биш гэдгийг хаа хаанаа ойлгох хэрэгтэйг төслийн менежер М.Энхбаатар учирласан.

Төсөл хэрэгжиж эхэлсэн хоёр жилд иргэд, компани хоорондоо тохиролцохгүй асуудал үүсч байсан бол өнгөрсөн онд аж ахуйн нэгжүүдийн зүгээс Нийслэлийн захиргаа болон төр засаг рүү чиглэсэн хөрөнгө оруулалт, дэд бүтцийн асуудлыг багагүй хөнддөг болж. Энэ нь өнөөх Дарь гуай нар “моодноос” гарсны маргаашийн дүр зургийг илтгэж байгаа юм. ■

Хөрөнгө оруулалт

С.Очирбат: Үндэсний компаниудад бизнесийн маш том талбар нээгдсэн

Д.БАЯР

Нийслэлийн Засаг даргын хот байгуулалт, хөрөнгө оруулалт, хариуцсан орлогч С.Очирбаттай ярилцлаа.

-Нийслэлийн хөрөнгө оруулалтын хувьд 2015 он ямар жил болж өнгөрсөн вэ?

-Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хувьд их сайхан амжилттай, өрнүүн жил боллоо. Улсын төсөв болон нийслэлийн санхүүжилтээр 478 төсөл арга хэмжээ, 560-аад тэрбум төгрөгийн ажил хийжээ. 16 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барьж, ашиглалтад орууллаа. Гурван ээлжээр хичээллэж, нэг ангид олноор шахцалдан суудаг байсан хүүхдүүд ангидаа хэвийн хэмжээнд сурч боловсрох нөхцөлөөр хангасан. Энэ бол боловсролын салбарт хийсэн том ажил гэж үзэж байгаа.

Дэд бүтцийн чиглэлд Энхтайваны өргөн чөлөөний газар доорх инженерийн шугам сүлжээг 40-өөд жилийн дараа шинэчиллээ. Ингэснээр гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжих үндэс суурь нэмэгдсэн гэж болно. Үндэсний компаниуд маань энэ ажлыг богино хугацаанд гүйцэтгэсэн. Мөн Дамбадаржаагаас 100 айл хүртэлх 4,7 км бохирын шугамыг хийж чадлаа. Сэлбэ голын бохирдлыг бууруулах чухал ач холбогдолтой ажил болно. Автозамын ямархуу ажлууд хийснийг хүмүүс мэдэж байгаа. Зуслангийн замыг гурав хүрэхгүй сарын хугацаанд засаж шинэчиллээ. Бас л олон жилийн дараа засаж шинэчилсэн зам.

-Энэ онд ямар ажлууд төлөвлөсөн бэ. УИХ болон нийслэлийн сонгууль болно. Ажил цалгардах болов уу?

-Хэдийгээр эдийн засгийн сааралт, уналт гэж байгаа ч бид өнгөрсөн жилийнхээс дутахааргүй ажлууд хийхээр төлөвлөсөн. Засгийн газрын Концессоор баглагдаж, хөрөнгө нь шийдвэрлэсэн 72 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын 30-ыг нь энэ жил барина гэж үзэж байгаа. Авто замын хувьд өмнө нь нийслэлээс гардаг ганцхан чиглэл байлаа. Энхтайваны



Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хоёр дахь хэлбэрийг энэ хавар эхлүүлнэ

өргөн чөлөөний зам баруун тийш 22-ын товчоо, зүүн тийш Баянзүрх байсан шүү дээ. Тэгвэл өнөөдөр Богд уулын араар, Дүнжингаравын урдуур зам тавилаа. Хотоос гардаг замуудаа зассан. Одоо хоёр л зам дутуу байна. Нэг нь Налайх, нөгөө нь Найрамдлынх. Энэ жилд амжуулж, засварлах зорилттой байгаа.

Өнөө жилийн хөрөнгө оруулалтын ажилд 160 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөсөн. Улсын төсвөөс хэдий хир ажил шилжиж ирэхийг мэдэхгүй байна. Өмнөх жилүүдийнхээс дутахааргүй хөрөнгө оруулалтын ажил хийнэ гэж төлөвлөөд эхний хагас жилд багтааж бүх ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Сонгуулийн жилтэй холбоотойгоор ажил цалгардуулж, удаашруулдаг байдлыг бид халах ёстой. Тиймээс дээрх бүх ажлын бэлтгэлийг богино хугацаанд хангаад дөрөвдүгээр сараас ажлууд руу ханцуй шамлан орохоор ажлаа зохион байгуулах болно.

-Нийслэл, хувийн хэвшлийнхний түншлэлийг та хэрхэн харж байна вэ?

-Бид Хөгжлийн төлөө түншлэл форумыг 2013 онд анх удаа хийж байлаа. Тэгэхэд хувийн хэвшлийнхэн долоон тэрбум гаруй төгрөгийн ажлыг өөрсдийн хөрөнгө оруулалтаар хийж өгсөн. Хотын зүгээс ажиллах нөхцөлийг нь л бүрдүүлж өгвөл хувийн хэвшлийнхэн ажил хийдэг гэдгээ харуулж чадсан. Өнгөрсөн жил Улаанбаатар хотын худалдааны танхим байгуулагдсанаар хот, бизнес эрхлэгчдийн түншлэлийн чуулганыг зохион байгуулсан нь маш амжилттай, үр дүнтэй болсон. Түүний хүрээнд 10 гаруй санамж бичгийг хувийн хэвшлийнхэнтэй зурж, ажлаа эхлүүлээд явж байна. Энэ бол том амжилт. Ер нь бизнесийнхний ажиллах нөхцөлийг л бүрдүүлж, хот, улсаас дэмжлэг үзүүлчихвэл, хот ч, аж ахуйн нэгж ч хөгжих маш их боломж байна.

Ер нь хотын цааш хөгжих бодлого тодорхой шүү дээ. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг УИХ-аар батлуулсан. Олон улсын, гадаад дотоодын хөрөнгө ▶

▶ оруулагчдад хэлэх, харуулах зүйлтэй болсон, бид. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нийслэл 2030 он хүртэл яаж хөгжихийг ерөнхий төлөвлөгөөнөөс хараад хаана нь, аль бүтээн байгуулалтад нь хөрөнгө оруулах уу гэдгээ шийдчих “гарын авлагатай” болсон гэсэн үг. Энэхүү төлөвлөгөөг батлаад жилийн дотор АХБ-наас Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг хөгжүүлэх хөрөнгийг босгож чадсан. Өнөөдөр ажлаа эхлүүлээд явж байна. Эхний ээлжийн орон сууцнуудыг ашиглалтад оруулчихлаа, мөн инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн. Ерөнхий төлөвлөгөө баталснаас цаашир хөрөнгө оруулалтын бодлого бол энэхүү ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэх юм. Хэсэгчилсэн төлөвлөлт, зураг төсөл, үе шаттай ажлууд хийж байна. Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гээд Жайка байгуулагатай хамтраад хийгээд Засгийн газарт хүргүүлчихсэн байгаа. Батлагдаад ирэхээр нь түүнд тусгасан хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөө хувийн хэвшлийнхэндээ танилцуулна. Бизнесмэнүүдтэйгээ зөвшилцөөд чадах ажлаа аваад, болохгүйг нь хот, улс хариуцаад явах юм. Нийтдээ эхний ээлжийн дунд хугацаанд хэрэгжих 96 төслийг санал болгоно.

-Гэр хорооллыг орон сууцжуулах ажлын явц өнөөдөр ямар байна вэ? Таны хариуцах асуудалд ордог байх аа?

-Энэ бол үнэхээрийн том ажил. Иргэн, бизнесийн байгууллагуудын хоорондын тохиролцоон дээр үндэслэсэн шинэлэг ажил. Өнөөдөр гэр хорооллын 26 талбарт орон сууцны барилга барьж байна. Долдугаар хороолол бараг барилгажчихлаа. Нийтдээ хоёр мянга гаруй айлын орон сууц ашиглалтад орчихсон байгаа. Нийслэлийн үзгээс борлуулалтад нь дэмжлэг үзүүлж, нийслэлийн төрийн албан хаагчийг дээрх барьж буй хорооллуудад байранд ороход нь урьдчилгаа 30 хувийн талыг нь ажил олгогчийн хувьд хотоос гаргахаар шийдвэрлэсэн. Үүний дүнд 93 төрийн албан хаагч оны босгон дээр шинэ сууцтай боллоо. Одоо дараагийн хүмүүс ээлжээ хүлээж байна. Энэ оны эхний хагаст цөөнгүй айлын орон сууцны хороолол ашиглалтад орохоор байна. Ерөнхийдөө 26 орон сууцны хорооллын барилгажих суурь тавигдсан гэсэн үг. Гэр

хорооллын дахин төлөвлөлтийн хоёр дахь хэлбэрийг энэ хавар эхлүүлнэ.

Би нэг харьцуулалт хэлье. Социализмын бүтээн байгуулалтын үе буюу 1954 онд хотын анхны ерөнхий төлөвлөгөөг хийж, орчин үеийн төлөвлөлтөөр хөгжиж эхэлснээс хойш нийслэлд 21 хороолол баригдсан байдаг. Тухайн үед Оросын СОТ 1, 2 гээд барилгын том трэстүүд ажиллаж байсан. Тэгвэл бид гурван жилд 26 орон сууцны хорооллыг эхлүүлээ. Гэхдээ зөвхөн үндэсний компаниуд ажиллаж байгаа. Дотоодын компаниудад бизнесийн маш том талбар нээгдэж байгаа юм. Олон жил үргэлжлэх бизнесийн том боломж.

Зарим нэг аж ахуйн нэгжийн ажил удаашралтай байгаа. Хөрөнгө оруулалтаа шийдэж чадахгүй, хэлцэл нь удааширч буй зүйл бий. Дотоодын 46 компани гэр хорооллыг орон сууцжуулах ажилд оролцож байна. Дахин төлөвлөлт иргэдийн хүсэн хүлээсэн ажил боллоо. Одоо иргэд манай орчинд хэзээ ирэх вэ, хэзээ барилга барих вэ гэдэг болсон байна. Тэд газраараа хоршиж, газар зохион байгуулалтад орж байна. Иргэд өөрсдөө санал нэгдээд газраа томсгоод тэр газар дээрээ юу барихаа шийднэ. Амины орон сууц, эсвэл таун хаус барих, дунд хэмжээний орон сууц барих нь тэдний мэдлийн хэрэг. Газраа барьцаалаад хөрөнгө босговол иргэд ажилтай, орлоготой, ажлын байртай болно. Ийм ажлыг найман газар эхлүүлэх бэлтгэл хангагдлаа. Гэтэл ганцхан асуудал гарсан. Газраа барьцаалаад зээл авах асуудал Үндсэн хуулийн цэц дээр очоод унасныг хүмүүс мэдэж байгаа. Цаашдаа асуудал хэрхэхийг хэлж мэдэхгүй байна.

Дэд бүтцийн хувьд улсын, хотын, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар томоохон ажыг хийлээ. Дахин төлөвлөлт хийж буй газруудад дэд бүтэц ихэнхэд нь хүрчихсэн байгаа нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтын үр дүн. Монголын цаг уурын нөхцөлөөс шалтгаалан богинохон хугацаанд барилгын ажил явдаг болохоор хугацаа их авах юм. Гэтэл иргэдийн хүлээлт их. Иргэдийнхээ хүслийг биелүүлэхийн төлөө бид шаргуу ажиллана. Харин бизнесийнхэндээ гэр хорооллыг орон сууцжуулах энэ том бизнес талбар руу ханцуй шамлан орохыг уриалж байна.

-Зах зээл дээр эзнээ хүлээсэн олон барилга байх. Гэтэл нэмээд л барьж

байна. Та ямар бодолтой байна вэ?

-Орон сууцны хороолол олноор босч байгаа нь сайшаалтай хэрэг. Нийслэлд 200 мянган орчим орон сууцны хэрэгцээ байгаа гэсэн судалгаа бий. 30 хувийн урьдчилгаа төлөөд найман хувийн зээлд хамрагдаж чадах нь 64 мянга гэсэн судалгаа гарсан. 2014 онд Улаанбаатар хотод анх удаа 20 гаруй мянган айлын орон сууц ашиглалтад орсон. Ихэнх нь борлогдсон. Өнгөрсөн оны дун удахгүй гарч ирэх байх. 30-40 ам.метр буюу жижиг талбайтай 2-3 өрөө бүхий орон сууц маш их хэрэгцээтэй, бас гүйлгээтэй байдаг.

Зах зээл дээр борлогдохгүй байгаа орон сууцны тоог янз бүрээр л хэлдэг. Гэхдээ 10 мянга гаруй айлын орон сууц борлогдоогүй байгаа гэсэн тоо үнэнд ойртох байх гэж би үздэг. Том талбайтай, зэрэглэл өндөр орон сууцнууд борлуулалтгүй байх шиг байна. Хямралтай холбоотой орон сууцны борлуулалт удааширч, саарсан зүйл байна. Эдийн засаг сэргээд ирэхээр борлуулалт эргээд нэмэгдэнэ. Цаг зуурын л асуудал гэж харж байгаа. Харин УИХ дээр өнөөдөр ипотекийн зээлийн асуудлыг ид ярьж байгаад баяртай байна. ■



Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчид 1351 нэгж талбай бүхий 78.3 га газрыг иргэдтэй байгуулсан хоёр болон гурван талт гэрээний дагуу чөлөөлсөн. 2015 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 40.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд шинээр 14 байршилд инженерийн шугам сүлжээний зураг төсөл, есөн байршилд авто замын зураг төслийн ажлыг хийжээ.

2013-2015 ОНЫ НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2013	2014	2015
Нийслэлийн төсвийн нийт орлого	474.085.2	522.545.9	550,599.7
Нийслэлийн төсвийн нийт зардал	432.671.7	483.487.5	583,332.3
Үүнээс: Урсгал зардал	208.599.1	285.483.4	367,063.2
Хөрөнгө оруулалтын зардал	224.072.6	198.004.1	216,269.1
Нийслэлээс Улсад төвлөрүүлэх орлого	15.382.1	44.538.8	-
Орон нутгийн хөгжлийн сан	27.766.3	32.137.6	19,101.8

Боловсролын салбар

▶ Бага сургууль
цэцэрлэгийн
цогцолбор **8**

Сургуулийн суудал 1440
Цэцэрлэгийн ор 960

▶ Сурагчдын
143
Автобус

55 сургуулийн 7541 сурагчийг автобусаар
тээвэрлэж байна.

Дэд бүтэц

▶ Улаанбаатар хотындулаан
хангамжийн 3А,Б гол шугамын
өргөтгөл, шинэчлэлт **1.7** км

▶ Их тойруугийн цахилгаан дамжуулах
110кВ агаарын шугам,
дэд станц

▶ **Амгалан дулааны
станц**

Бүтээн байгуулалт

▶ Гэр хорооллын дахин төлөвөлт
1506.1 га

▶ Төсөл хэрэгжүүлэгч
34

▶ Төсөлд хамрагдсан
75,964
хүн ам

▶ Шинээр
барьсан
авто зам **100.93** км

▶ Өргөтгөж
шинэчилсэн
авто зам **120.87** км

Инженерийн дэд бүтэц

▶ Шинээр барьсан дулааны шугам **15.4км**

▶ Шинэчилсэн дулааны шугам **21.9км**

▶ Өргөтгөл шинэчлэлт хийсэн насос станц **2ш**

ДЭД БҮТЦИЙН САЛБАРТ 2013-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТОМООХОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Гадаадын зээл тусламжийн хөрөнгө	Нийт
Орон сууцны хороолол доторх гаднадулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажил	км	15.9			15.9
Ус дулаан дамжуулах төвийн шинэчлэлт	тоо	7		42	49
Ус хангамжийн шугам	км	14.9		26.1	41
Ариутгах татуургын шугам	км	4.2			4.2
Үерийн хамгаалалтын барилга, байгууламж	км	34.5			34.5
Нийслэл хотын аналогий өргөн нэвтрүүлгийн телевизийн станцуудыг тоон технологид шилжүүлэх	тоо	6			6
Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн засвар	тоо	200	32		232
Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны засвар	тоо	184	250		434

Цахилгаан шугам сүлжээ

▶ Хотын төвийн кабель шугам шинэчлэлтийн ажил **109.9км**

▶ Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн ажил **14866ш**

▶ Гэр хорооллын цахилгаан эрчим хүчийг сайжруулах ажил **13657 өрх**

Авто зам


▶ Шинээр барьсан авто зам **100.93** ▶ Өргөтгөл шинэчлэлт хийсэн авто зам **120.87**

▶ Орон сууцны хорооллын доторх авто зам **22.20** ▶ Шинээр барьсан гүүр **640.9** ▶ Өргөтгөл шинэчлэлт хийсэн гүүр **230.8**

▶ Авто машины нүхэн гарц, туннел **3** ▶ Явган хүний нүхэн болон гүүрэн гарц **5** ▶ Борооны ус зайлуулах шугам сүлжээ **9**

▶ Өргөтгөж шинэчилсэн уулзвар **25** ▶ Хүй долоон худгийн авто зогсоол **5100** машин

Гэр хорооллын дахин төлөвлөлт



8 дүүрэг 37 хороо
 24 байршил тогтоон 75 хэсэгчилсэн
 талбайд хуваасан
 16109 нэгж талбар 1506.1 га талбай
 50 хэсэгчилсэн талбайд 34 төсөл
 хэрэгжүүлэгч ажиллаж байна

▶ Төсөлд хамрагдсан
75,964
 хүн ам

- ▶ Дулааны **12.99км** шугам
- ▶ Бохир усны **7.57км** шугам
- ▶ Цахилгааны хаалттай **47** дэд өртөө
- ▶ Ашиглалтад орсон **1670** орон сууц
- ▶ Цэвэр усны **8.49км** шугам

Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

/Сэлбэ, Баян хошуу дэд төв/



- Азийн хөгжлийн банк
- Буцалтгүй тусламж
- Нийслэлийн төсөв
- Европын сэргээн босголт хөрөнгө оруулалтын банк

ТӨСЛИЙН ҮР ДҮН

- Хотын төвлөрөл саарна.
- Хотын дэд төвүүд шинээр бий болно.
- Дэд бүтцийн сүлжээ үүснэ.
- Ажлын байр бий болно.
- Иргэдийн амьжиргаа дээшилнэ.
- Тав тухтай, аюулгүй орчин бий болно.

Нийслэлийн төсөв


Орлого
Зардаг



700.3 тэрбум
632.1 тэрбум

Нийслэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд

Нийслэлийн төсөв
Улсын төсөв
Хөгжлийн банк
ОНХС



169.5 тэрбум
84.5 тэрбум
120 тэрбум
18.9 тэрбум/

Төрийн үйлчилгээ

▶ Төрийн үйлчилгээний салбар төв **3**

▶ Нийслэлийн архивын барилга **1**

▶ Хороо өрхийн эмнэлэг, цагдаагийн хэлтсийн цогцолбор **15**

▶ Дүүргийн цагдаагийн хэлтсийн барилга **3**

▶ Дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн барилга **1**

Эрүүл мэндийн салбар

▶ Шинэ амаржих газар **1** | **100** ортой

▶ Шинэ хүүхдийн эмнэлэг **2** | **200** ортой

▶ Амбулаторин барилга **2** | **100** ортой

▶ Нэгдсэн эмнэлэг **3** | **250** ортой

▶ Эрүүл мэндийн төв **2** | **100** ортой

Инженерийн шугам сүлжээний байгууламж

- ▶ Шинээр барих дулааны шугам **5.3** км
- ▶ Шинээр барих насос станц **1**
- ▶ Усан хангамжийн шугам **6** км
- ▶ Өргөтгөл шинэчлэл **4.5** км
- ▶ Хорооллын дулаан, ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл **6.8** км
- ▶ Ус, дулаан дамжуулах төвийн шинэчлэл **4.5** км
- ▶ Ариутгах татуургын шугам **7.2** км
- ▶ Үерийн хамгаалалтын барилга байгууламж **5.4** км
- ▶ Буянт-Ухаа бохир ус цэвэрлэх байгууламж **20,000** м³

Авто замын салбар

- ▶ Шинээр барих авто зам **63.9** км
- ▶ Өргөтгөж шинэчлэх гүүр **108** у.м
- ▶ Шинээр барих гүүр **2411** у.м
- ▶ Шинэ Нүхэн гарц туннел **3**
- ▶ Авто замын өргөтгөл шинэчлэл **58.8** км
- ▶ Хороолол доторхи зам **7.5** км



Найрсаг Улаанбаатар

Гол тоглогч

Б.ЭНХ

Монголыг зорих жуулчдын аяллын эхний цэг хүссэн хүсээгүй Улаанбаатар хот болдог учир хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх нь салбарын хувьд зайлшгүй. Гэхдээ гаднынхан нийслэлд хоноцын сэтгэлгээгээр хандах хэмжээнд бус Монгол дахь аяллын чухал бүрэлдэхүүн хэсэг байх хэмжээнд хотын аяллыг хөгжүүлэхэд өдгөө холбогдох албаныхан бодлого, хөтөлбөр гаргаад эхнээс нь хэрэгжүүлээд явж байна. Энэ ажлын тод илрэл нь “Найрсаг Улаанбаатар хөтөлбөр”.

Тус хөтөлбөрийн хувьд тунхагийн чанартай биш гэдгээ өнгөрсөн жил гаруйн хугацаанд хийсэн ажлаараа батлан харууллаа. Аялал жуулчлалын тавьдаг тухайлбал, дугаарын хязгаарлалт, автозогсоол зэрэг цөөнгүй асуудлыг шийдсэн. Мөн жуулчин татвар хэмээх шинэ тогтолцоог нэвтрүүлж, дараагийн ирэх жуулчдыг тагах төслүүдийн санхүүжилтийг босгож буй. Хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн жил л гэхэд 30 гаруй олон нийтийн арга

хэмжээг зохион байгуулсан бөгөөд эдгээр нь зөвхөн гадныхныг бус монголчуудыг ч мөн үзэх харах зүйл ихтэй болгосныг Чингисийн талбайн хүн зон ихтэй завгүй өдрүүд гэрчилнэ. Ерөнхийд нь тус хөтөлбөрийг зөвхөн нийгэм соёлын арга хэмжээнүүдээр хэмжих нь өрөөсгөл гэдгийг Нийслэлийн аялал жуулчлалын газрын /НАЖГ/ дарга Э.Баттулга хэлж буй.

Гурван жилийн өмнө дэлхийн хамгийн найрсаг бус ээлгүй орнуудын нэг болж байсан Монгол саяхан CNN travel-ийн 2016 оны хамгийн ёс зүйтэй орнуудын нэгээр нэрлэгдлээ.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр батлагдсанаар нийслэл хот 2015 оноос эхлэн гадаад маркетингийг явуулж эхэлсэн байдаг. Дэлхий даяар үндэсний, бүсийн, хотын хэмжээний аялал жуулчлалын байгууллага бүр маш их мөнгө, цаг хугацааг сурталчилгаанд зарцуулдаг. Энэ нь үндсэндээ дөрвөн төрлийн үйл ажиллагааг хэлдэг: зар сурталчилгаа, хэвлэн нийтлэх, олон нийтийн харилцаа, урамшуулал хөнгөлөлтүүд. Хөрөнгө

оруулалт гарздахгүйн тулд зорилтот зах зээлийг тодорхойлж боломжоо тооцоолж төлөвлөх нь зайлшгүй гэдгийг дэлхийн аялал жуулчлалын байгууллагынхан зөвлөдөг.

Монгол Улсад жуулчны визээр хил нэвтэрсэн зорчигчийн тоо 2015 онд 386 мянга байсан ба энэ өмнөх жилтэй нь харьцуулахад 1.7 хувиар бага үзүүлэлт болж байна. Тус үзүүлэлтийг голлох 10 улсаар задлан харвал Монголыг хамгийн их зорьсон ТОП 5 орон нь Хятад, Орос, Япон Солонгос болон Какахастан байна.

Нийслэлийн аялал жуулчлалын газрын хувьд хөтөлбөрийн хүрээнд энэ жил манай улсыг зорих шууд нислэгтэй орнуудыг чиглэж маркетингаа хийнэ гэж байгаа. Үүнд Орос, Хятад, Япон, Герман Солонгос, Хонконг багтаж буй. Тэд бүгд жуулчдын аялал сонгодог шалтгаан, зардлын хувь хэмжээ, аяллын зах зээлийг нь эзэлдэг насны бүтэц гэх мэт олон талаараа өөр хоорондоо ялгаатай. Хятадыг л гэхэд тухайлбал, зах зээлийг нь хэдхэн том компани атгадаг бол Японы зах зээлд аялал жуулчлалын холбоод дээр суурилж ажил нь урагшилдаг байна. Харин Солонгосын зах зээлийн хувьд үндэстэнд суурилсан бизнес давамгайлдаг тул гаднын компани жуулчин авахад хамгийн хэцүүд тооцогддог аж. Солонгосын аялал жуулчлалын зах зээл барж иддэггүй хоол гэгддэг тул НАЖГ-аас Сөүл хотын төвд ▶



▶ Улаанбаатар хотын соёлын өдрүүдийг зохион байгуулж, солонгосчуудын дунд Монгол руу очиж үзэх хүслийг өдөөх тактик барьжээ. Ингэснээр хэрэглэгчид нь манай орныг асуугаад ирэхээр тур операторууд нь өөрийн эрхгүй Монголыг сонирхох болно гэж тооцсон байна.

Акулуудын нүдэнд өртөхийн тулд

Өдгөө Монголын хамгийн том компани 10.000 жуулчин хүлээн авдаг бол дэлхийн акулууд үйлчлүүлэгчдээ 30-40 саяар тоолдог. Дэлхийн аялал жуулчлалын салбарын зах зээлүүдийг харвал томоохон хэдэн компани тухайн улсынхаа зах зээлийг атгачихсан байдаг. Жишээ нь Хятадын CITS, Японы JTB Travel Corporation, Германы TUI, Их Британийн Thomas Cook зэрэг компани байна. Эдгээр компаниудын аль нэг жилийн хөтөлбөрт нь орсон онцлох аяллуудын нэгт манай улс багтвал Монголын аялал жуулчлалын салбарт тоо ба чанарын өсөлт мэдэгдэхээр тийм нөлөөтэй. Аяллыг хувь хүн өөрөө би ийшээ тийшээ явмаар байна гэж бодоод л сонгогчихдог гэвэл өнгөц ойлголт. Үүнд олон хүчин зүйл нөлөөлдөг. Томоохон компаниуд тухайн жилдээ онцлох орнуудаа жагсаасан хөтөлбөр, тараах материал гаргаад түүнийгээ хэдэн мянган салбар нэгжүүд рүүгээ тараан байршуулж, хөнгөлөлт урамшуулал бэлэг сэлт амлаж, найрсаг шахаа хийдэг. Германы

TUI групп л гэхэд л 1800 тур оператор, зургаан агаарын тээврийн компани, 300 зочид буудал, 30 сая үйлчлүүлэгчтэй. Тэдний жилийн онцлох аяллуудын нэгт Монгол багтвал “тэнгэрийн унадаг” атгалаа л гэсэн үг. Хэрвээ том компаниуд биднийг сонирхоод ирнэ гээд шийдчих л юм бол захиалгаар онгоц нисгээд, транс сибирин галт тэргийг ашиглах зэргээр манай дэд бүтэц муу байсан ч өөрсдийн хүчин чадлаа ашиглаад аялагчаа зөөгөөд манайхыг “моданд” оруулчиж дөнгөхөөр.

Тэгвэл тэдэнд яаж тоогдох вэ. Дээрх том компаниудын хувьд манай улсыг гадаад сурталчилгаагаа сайн хийж танигдахыг хүлээж буй. Тэдэнд худалдан авалт султай бүтээгдэхүүн хэрэггүй. Өдгөө манай улсын хувьд нарийвчилбал хотын зүгээс “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлж буй нь зөвхөн дотооддоо чиглэсэн ажлуудыг хийх бус мөн Монголыг сурталчлах гадаад ажлуудыг мөн зохион байгуулахад чиглэж буй.

Энэ хүрээнд 2015 онд холбогдох хүмүүс гаднын жуулчдыг татах тал дээр иргэд рүү хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан илүүтэй ажилласан бол мэргэжлийн оролцогчдыг татахын тулд томоохон үзэсгэлэн чуулганд орж, тэднийг цааш хэрэглэгчиддээ Монгол хэмээх аяллын бүтээгдэхүүнийг зарах талаас нь анхаарал хандуулан ажиллажээ. 2015 онд хамрах

хүрээ, оролцогчдын тоогоороо дэлхийд тэргүүлдэг ‘ITB Berlin’ аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс түнш орноор, Улаанбаатар хот үндсэн оролцогчоор оролцож, гадаад сурталчилгааны гараагаа НАЖГ жинтэйхэн тавьсан. Түүнчлэн үзэсгэлэнгийн үеэр болдог хэлэлцүүлгийг ‘Монгол улс MICE жуулчлалын зах зээлд’ сэдвийн дор явуулж, нийслэл хотыг бизнес жуулчлалын бие даасан зорих газар болгон гадаадад сурталчлах ажлыг эхлүүлсэн. Дээрх томоохон үзэсгэлэнд оролцсон амжилтаа бататгаж, НАЖГ-аас Германы ням гарагийн тогтмол хэвлэлүүдийн зах зээлийг тэргүүлэгч, 2012 оны Европын оны шилдэг сонин, 2013 оны Европын долоо хоног тутмын шилдэг сонин Welt am Sonntag-ийн 2015 оны арванхоёрдугаар сарын тусгай дугаарыг Улаанбаатар хотын аялал жуулчлал сэдвээр бэлтгэн гаргажээ. 1.1 сая уншигчтай сонин ба түүний 45,7 сая хүн уншдаг цахим хуудас Welt.de-д хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг онцолсон уг сурталчилгаа нь Монголын аялал жуулчлалын түүхэнд хамгийн далайцтай медиа маркетинг болж байгааг нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл онцолсон.

Өнгөрсөн жил маркетингийн хувьд хийсэн хамгийн том ажлуудын нэг нь Токио хотноо Улаанбаатар хотын аялал жуулчлалын төлөөлөгчийн газрыг нээсэн явдал юм. Япон шиг ▶


► аяллын агентлагуудын холбоо, үндэсний аялал жуулчлалын холбоо зэрэг мэргэжлийн холбоодын уялдаа дээр салбар нь урагшилдаг орны хувьд маркетингийн арга барил тэдэнтэй холбогдох ёстойг аялал жуулчлалын холбогдох хүмүүс олж харжээ. Тиймээс тэдэнтэй өнгөрсөн жилийн тухайд Э.Бат-Үүл дарга хоёр ч удаа очиж уулзан, санал тавьсан. Мөн энэ хүрээндээ ч Японы олон улсын аялал жуулчлалын “JATA” үзэсгэлэнд мөн оролцсон байна. Тус улсын хувьд бид шууд нислэгтэй, визгүй, Монгол улс харьцангуй сайн сурталчлагдсан зэрэг олон давуу талтай.

Харин Өмнөд хөршийн хөлгүй их өргөн зах зээлд шунгахын тулд хятадуудын дунд хэвлэл мэдээлэл, цахим хуудаст суурилсан сурталчилгаа өндөр нөлөөтэй байдаг талыг нь ашиглаж байна. Хятадын аялал жуулчлалын бизнесийг хэдэн том компани хариуцдаг хараа хяналт ихтэй ч гэсэн тэдэн лүү чиглэсэн сурталчилгааг олон улсын үзэсгэлэнгүүдээр нь дамжуулан хийж байгаагаа НАЖГ-ын дарга Э.Баттулга танилцуулсан юм.

Хувийн хэвшил рүү нь томоохон үзэсгэлэн хуралд идэвхтэй оролцох замаар өөрсдийгөө таниулж байгаа бол гаднын иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааны хувьд түлхүү хэвлэл мэдээлэл, цахим ертөнцийн сувгуудыг ашиглах чиг барьж байна. 2015 онд хийгдсэн судалгаагаар жуулчдын Монголын болон Улаанбаатар хотын талаарх мэдээлэл авсан гол эх сурвалжийн 61 хувь нь интернетэд ногдож байгаа бол, аяллын хөтөч 50.5 хувь, нийгмийн сүлжээний цахим хуудсууд 14.8 хувь байжээ. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд цахим маркетинг үр дүнтэй гэж үзсэн учир www.ulaanbaatour.mn цахим хуудсыг монгол, англи, орос, солонгос хэл дээр ажиллуулж эхэлжээ. Мөн жуулчид, гадаадын иргэд мэдээлэл ихээр авдаг Wikipedia, Wikitravel чөлөөт нэвтэрхий толиудын Улаанбаатар хот, хотын аялал жуулчлалын мэдээллийг зургаан хэл дээр шинээр болон шинэчлэн оруулаад байна.

Улаанбаатар хотын маркетингийн иж бүрдлийг өнгөрсөн жил гарснаар хотын нэгдсэн дүр төрхтэй сурталчилгааг нийслэлийн бүх байгууллагууд, хувийн хэвшлийнхэн өөр өөрсдийн сувгаар үр дүнтэй явуулах боломж бүрдэж байгаа. Манай хотын дэлхийд танигдах уриа үг нүүдэлчин сэтгэхүйтэй хөгжил хөдөлгөөн дундах хот гэсэн утга бүхий “Dynamic city with nomadic soul” болсон.

Хотууд нь соёл, худалдааны хамгийн идэвхтэй солилцооны цэгүүд. Өдгөө дэлхийн хүн амын тал нь хот суурин газар амьдарч байгаа бол 2030 он гэхэд таван тэрбум хүн хотын иргэд болно гэж Дэлхийн аялал жуулчлалын байгууллага тооцжээ. Хотуудын зочдын тоо жил, жилээр өсөх тусам дотоодын эдийн засагт ажлын байр бий болгох, валют арилжааг тэтгэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эерэг нөлөөлөл авчирч буй. Энэ нь эргээд оршин суугч, аялагч аль алинд нь өгөөж болдог. ■







January

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31




February

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29						




March

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
1	2	3	4	5	6	
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			



April

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	



May

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
30	31				1	
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29



June

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	



July

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
						1
4	5	6	7	8		
11	12	13	14	15		
18	19	20	21	22		
25	26	27	28	29		



August

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				

2016.02.06
"ULANBAATAR WINTER FESTIVAL"

2016.03.26-04.10
"WORLD CIRCUS IN MONGOLIA"

2016.05.15-05.21
"SAINT MUSE" theatrical festival

2016.05.20-21
"ULANBAATAR BOOK FAIR"

2016.05.28
"THE SPLENDOR OF MONGOLIAN SOLDIERS" festival

2016.06.04
"ULANBAATAR INTERNATIONAL MARATHON"

2016.06.04-05
"ULANBAATAR" international travel expo

2016.06.11
"ULANBAATAR-VIENNA DANCE NIGHT"

2016.06.18
"UB DANCE" festival

2016.06.24-06.26
"PLAY TIME" live music festival

2016.07.02
"THE BEST OF CLASSICS" open air concert

2016.07.10
"MONGOLIAN NATIONAL COSTUME" festival and parade

2016.07.10
"THREE DRAMATIC CHARACTERS" national opera day

2016.07.11
"UB NIGHT" festival

2016.07.12
"SILENCE WHITE" dance event

2016.07.12
"MONGOLIAN DANCE FESTIVAL"

2016.07.13
"MORIN KHUUR" traditional music festival

2016.07.14
"ULANBAATAR SWING NIGHT" "Giant steppes of jazz" international festival

2016.07.30
"STAR OF FAME" music festival



September

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	



October

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
31					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30



November

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
1	2	3	4	5	6	
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30				



December

Mon	Tue	Wed	Thu	Fri	Sat	Sun
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

2016.08.06-07
"DANSHIG NAADAM" culture festival

2016.08.06
"THE TALE OF MOUNTAIN AND WATER" Mongolian contortion festival

2016.08.07
"MELODIC HARMONY-MYSTIC ENERGY" ethno concert

2016.08.13-14
"UB FOOD" festival

2016.08.15-20
"MONO DRAMA" festival

2016.09.25-30
"UB ART FAIR AND STREET ART" festival

2016.10.11-10.15
"ULANBAATAR" international film festival

2016.12.05-12.15
"THE NUTCRACKER" ballet



Бизнес

Ж.Од: Улаанбаатар хот бол маш сонирхолтой зах зээл

Д.БЭХЭЭ

Улаанбаатар хотын танхимын Ерөнхийлөгч, MCS группийн ерөнхийлөгч Ж.Одтой ярилцлаа.

-Улаанбаатар хотын танхим байгуулагдаад нэг жил боллоо. Энэ хугацаанд бизнес, түншлэлийн ажил ямар байдалтай явж ирэв?

-Хотод үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийг нийслэлийн бүтээн байгуулалтад оролцуулах, тэдний хүчийг дайчлах, мөн улс, хотоос санхүүжүүлж буй төслүүдэд хувийн хэвшлийг өргөнөөр татах зорилготой байгуулагдсан, манай танхим. Өнгөрсөн жилийн хугацаанд хамтын ажиллагааны суурийг тавьж чадлаа. Хотын зүгээс Хөгжлийн корпорацийг байгууллаа. ТУЗ-д нь хотын танхимаас гурван гишүүн орсон. Өмнө нь байгаагүй зүйл л дээ. Танхим өөрийн оффистой болж, бүтэц зохион байгуулалтаа хийж, дэргэдээ арбитрай боллоо. Богинохон хугацаа ч түншлэлийн харилцаа сайн явж байгаа. Хямралтай ч ажил урагшилж

байна.

Эдийн засгийн үзүүлэлт дээшээ доошоо болж л байдаг. Гэлээ ч амьдрал үргэлжилдгээрээ л үргэлжилнэ. Тэр тусмаа хотын амьдрал. Тиймээс хотын эрчимтэй хөгжилд бизнесийнхний оролцоо их байх тусам олон хүнд хүртээлтэй, тустай, зөв явна. Эдийн засгийн уналттай үед хот, танхимынхан түншилж чадсан бөгөөд энэхүү түншлэл эерэг зүйлийг авчирна гэдэгт итгэлтэй байна.

-Хотын хөгжилд бизнесийнхэн тэргүүлэх үүрэгтэй оролцох ёстой гэж та хэлсэн.

-Хотын бүх л төсөл дээр хувийн хэвшлийнхэн гүйцэтгэгчээр ажилладаг. Харин оролцоо, сонгон шалгаруулалтын хэлбэр, төр хувийн хэвшлийн нөхцөлөөр оролцуулах тэр боломжуудыг нээх нь л бидний зорилго. Хамгийн ололттой нь хотын удирдлагуудын зүгээс PPP-гийн / төр, хувийн хэвшлийн түншлэл/ зарчмаар төслүүдийг хэрэгжүүлэхийг, шийдвэр гаргах үйл явцад хувийн хэвшлийнхнийг

татан оролцуулахыг ихэд дэмжиж байгаа явдал юм. Дөнгөж эхэлж буй процесс. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төслүүд хэрэгжүүлэхэд эрх зүйн үндэс суурь болон бусад механизмыг бүрдүүлэх нь их чухал байдаг. Тухайлбал, хоёр талын хүлээх хариуцлага, үүрэг, санхүүжилтийн хэлбэрүүд гэх мэт.

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци байгуулагдаад удаагүй байна. Энэхүү байгууллагаар дамжин төслүүд хэрэгжинэ. Корпораци бол хотод ямар төслүүд хамгийн түрүүнд хэрэгтэй, шаардлагатай байна, аль төсөлд хувийн хэвшлийн хөрөнгийг татах уу, ямар хэлбэрээр төслийг явуулах уу гэдэг асуудлыг, миний ойлгож буйгаар аж ахуйн шийдвэр гаргах процесстд аж ахуйн байгууллага, хотын иргэдийн төлөөллийг оролцуулан шийдэж ажиллах юм. Өмнө нь зөвхөн захиргааны ажилтан л асуудлыг дангаар шийддэг байсан бол өнөөдөр олон талын төлөөллөөр шийдвэр гаргана гэсэн үг.

Тус корпорацийн ТУЗ есөн гишүүнтэй, гурав нь хувийн хэвслээс, гурав нь иргэдээс, үлдсэн нь хотын захиргаанаас төлөөлж бодлогын асуудал дээр төвлөрч хамтарч ажиллах юм. Мөн алив маргааныг шүүх бие даасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөрөнгө оруулагчдад сонголттой сайн арбитрай байх ёстой. Улаанбаатар хотын Танхимын дэргэдэх Арбитрай одоо арбитраудаа сонгох, урих, мөн байгууллагаа бэхжүүлэх, сургалт хийх зэрэг олон ажил хийнэ.

-Их хотын хөгжлийг дагаад сайн ч, саар ч зүйл байх юм. Улсын нийслэлд хамгийн ихээр тулгамдсан ямар асуудал байна, давах гарц шийдэл юу байна гэж та харж байна вэ?

-Олон асуудал ярьдаг. Утаа, гэр хорооллын дахин төлөвлөлт, хөрсний, усны бохирдолт, түгжрэл гэх мэт. Хот гэхээр зөвхөн байшин барилга, зам биш. Олон хүний харилцааг нэг дор зохицуулах ёстой. Тэдний ая тух, амьдрах орчныг бий болгох ёстой. Дэд бүтцийн том асуудлуудаас гадна техник технологи болоод программ хангамжийг хөгжүүлэх шаардлагатай байдаг. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө баталсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу хот цаашид төлөвлөлтөө хийж хөгжинө гэж бодож байна.

-Бусад улсын нийслэл гадаад, довтоодын хөрөнгө оруулалтын хүчээр хотоо цэцэглүүлэн хөгжүүлсэн байдаг.

► **Өнөөдөртөө гадаадын хөрөнгө оруулалт Улаанбаатараас дайжчихсан байгаа. Энэ дайжсан, бас хилийн чанадаас хөрөнгө оруулалтыг татахын тулд юу хийх шаардлагатай байна вэ?**

-Хөрөнгө оруулалтын орчин дээр Улаанбаатар хот гэж ярихад хэцүү л дээ. Улсын макро эдийн засаг, улс төрийн байдал, улстөрчдийн ааш араншин гээд олон зүйлээс хөрөнгө оруулалтын орчин, тогтвортой байдал хамаарна. Өнөөдөр байдал нэлээд дордсон байгааг хүмүүс мэднэ. Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин гэж ярихаас нийслэлийнх нь гайгүй гэж ярихгүй. Өнгөрсөн жилийн анхдугаар форумд ирж оролцсон гадаадынхан “Танайхан сайхан юм ярьчихаад яг бодит байдал дээр өөр зүйл ярьж, шийдвэр гаргадаг” гээд ирэхгүй гэж байна. Гадаадынхан ингэлээ гээд бид нүүгээд явчихгүйгээс хойш өөр арга зам хайх ёстой. Яаж, ямар байдлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах уу гэдэгт анхаарч ажиллах шаардлагатай.

Миний бодлоор Улаанбаатар маань хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах боломжтой, маш сонирхолтой зах зээл. Монгол Улсыг том газар нутаг дээр цөөн хүн ам амьдардаг гэж үздэг бол Улаанбаатар хотыг дангаар нь аваад үзвэл маш жижигхэн газарт хүн ам шигүү суурьшсан зах зээл. Эвийг нь олоод ажиллавал маш их зүйл хийх боломжтой зах зээл. Бараа үйлчилгээ үзүүлэх хууль тогтоомжууд гаргах, худалдааны, аялал жуулчлалын чөлөөт бүс эсвэл хоёр том зах зээлийн дунд ложистикийн чөлөөт бүсийг байгуулах боломж байгаа. Шинэ баригдаж буй онгоцны буудлаа дагуулаад ойр орчмын улсын иргэдэд, мөнгөтэй жуулчдад зориулаад худалдааны тусгай бүс байгуулж болно. Хотынхоо онцлогт тохируулж, хууль тогтоомжоо гаргаад эрх зүйн орчныг бүрдүүлвэл гадны хөрөнгө оруулалтыг татах боломжтой. Хийе гэвэл маш их ажил бий.

Манай танхим дээр Улаанбаатар хотыг санхүүгийн төв болгох төсөл явж байгаа. Хууль дүрмийг нь зөв гаргавал энэ мэт хийж, бүтээж болохоор төслүүд олон бий.

-Та 2016 оны эдийн засгийн байдлыг хэрхэн харж байна вэ?

-Зөвхөн манай улс ч биш, дэлхий дахинаараа хямралтай таагүй байна. Энэ

жил Монголын хувьд УИХ-ын сонгууль болно. Улстөрчид сонгуульд чиглэсэн арга хэмжээнүүд авч явуулах байх. Нөхцөл байдал сүрхий сайжирчихна гэж бодохгүй байна. Ер нь сонгууль угтаж хийсэн ажил, алхмууд эдийн засагт сайнаар нөлөөлөх нь бараг л байдаггүй шүү дээ. 2016 онд эдийн засаг сайнгүй л байх дүр зураг харагдаж байна. Оюутолгойн гүний уурхайн төсөл явж магадгүй. Тавантолгойн цахилгаан станц явах юм уу мэдэхгүй. Ер нь том төслүүд явах эсэх нь улс төрийн шийдвэрүүдээс шалтгаалдаг.

-Тэгвэл бизнес?

-Хувийн хэвшлийнхэнд сүүлийн хоёр жил хүнд тусаж байгаа нь үнэн. Зөв бодлогууд л хэрэгтэй. Эдийн засаг, санхүү, улс төрийн тогтвортой, зөв бодлогууд хэрэгжүүлэх шаардлагатай. Манай хувийн хэвшлийнхэн зах зээлд ажиллаад сурчихсан. Нөхцөлийг нь бүрдүүлээд өгвөл бизнесийнхэн төдийгүй хувь хүмүүс ч тэр ажил руу ханцуй шамлаад орно. Салбар салбартаа мэргэшсэн, манай компаниуд. Нэг үеэ бодвол компаниуд босож, өндийж, мэргэжилтнүүд нь чадвартай болсон. Хийж чадахгүй гэх ажил байхгүй болсон шүү дээ.

Манай компани гэхэд л АСЕМ-ын өндөр хэмжээний төлөөлөгчдийг хүлээж авах хотхоныг барьж байгаа. Гүйцэтгэгчид бүгд монгол компани, монгол хүмүүс. Европын холбооны хүмүүс нь ирж, барилгын явц, материал, чанар, хийцийг үзээд гайдаг. Зураг төслөөсөө эхлээд бүх шат дамжлагад монгол хүн ажиллаж, хийж бүтээж байгаа гэхээр тэд үнэмшдэггүй. Манайхан өндөр түвшинд хүрчихсэн. Нэг бодлогоор хөрөнгө оруулалтыг татаад, зөв бодлогоор хүмүүсээ ажилтай орлоготой байлгаж чадвал манайх шиг жижигхэн орон богино хугацаанд хөгжих боломжтой.

-Танай компанийн хувьд байдал хэр байна вэ?

-Уул уурхай уналттай байгаа нь дэлхийн хэмжээний үзэгдэл. Бусад жижиг салбарын хувьд уул уурхайгаа дагаад нэлээд савладаг. Ялангуяа үл хөдлөх хөрөнгө. Манай компанийн хувьд олноор нь барьчихсан, борлуулах орон сууц байхгүй учир байдал гайгүй. Бусад өргөн хэрэгцээний бараануудын өсөлт өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад бага бай-

гаа. Манай групп улсад өнгөрсөн онд 200 тэрбум төгрөгийн татвар төлсөн. Хямралтай, уналттай үед энэ бол бага мөнгө биш. Компанийн үйл ажиллагаа хэвийн явж байгаа. Гэхдээ өмнөх онуудаас илүү их хөрөнгө оруулалт татах, хийх, илүү олон ажлын байр бий болгох бололцоо байсан байх.

-Төрийг бизнесийг дэмжиж, урамшуулахгүй юмаа гэхэд бизнест оролцохгүй л байхыг Монголын бизнес эрхлэгчид хүсдэг. Монгол Улсад хамгийн их татвар төлдөг хувийн хэвшлийн төлөөллийн удирдлагын хувьд та ямар бодолтой явдаг вэ?

-Хамгийн сонгодог онол. Хамгийн сайн төр хамгийн жижиг байдаг. Тоглоом шоглоомоор ярьдаг даа. УИХ-ын гишүүд, сайд дарга нар бид яаж туслах уу, дэмжих үү гэхээр нь та нар юу ч битгий хий. Тэр чинь хамгийн том тус болно гээд л. Энэ бол зах зээлийн зарчим. Төр татвараа л авах ёстой. Авсан татвараа төрийн зүгээс туслах ёстой хүндээ зориулах ёстой. Ахмад, хүүхдүүд, нийгмийн эмзэг бүлгийнхэн ч юм уу. Түүнээс төр нүүрсээ ухна, үйлдвэрлэнэ, борлуулна гээд арайхийж хөл дээрээ босож буй компаниудтайгаа өрсөлдөөд эхлэхээр асуудал бишдээд ирж байгаа юм.

Төрийн огт оролцоогүй байна гэж байхгүй л дээ. Төрийн оролцоотой салбар бий. Ер нь ном ёсоороо бол төр хэзээ ч дампуурдаггүй. Дампуурах ч ёсгүй. Төр эрсдэлтэй салбар руу орж, үйл ажиллагаа хэзээ ч явуулах учиргүй. Зөвхөн татвараа аваад байвал мөнгө орж ирээд л байна гэсэн үг. Орж ирсэн мөнгийг зөв хуваарилж, нийгмийн харилцаанд зөв, сайн оролцох ёстой. Бизнес бол эрсдэлтэй. Эрсдэлгүй бизнес гэж байхгүй.

Барууны орнуудад төр бизнес рүү ордоггүй, иргэдийн, татвар төлөгчдийн мөнгийг эрсдэлтэй зүйлд оруулдаггүй, зөвхөн татвараа л авдаг учраас төр нь дампуурдаггүй. Хөдөлж буй болгоноос татвараа сайн авдаг учраас баланс нь байнга нэмэхтэй гардаг. Тэр мөнгөөрөө ядуу зүдүү хүмүүстээ тусалж, эмнэлэг, сургуулиа анхаардаг. Гарцаагүй барих дэд бүтэц, замд хөрөнгө оруулна.

Уул уурхай, газар тариалан, хөдөө аж ахуй бүгд эрсдэлтэй. Хэн нэгэн эрсдэлтэй салбарт ард түмний, татвар төлөгчдийн мөнгийг төрийн нэрээр барьж эрсдэл хүлээхийг хориглосон байдаг. Тийм учраас төр мөнгөгүй болж байгаа бол буруу бодлого, менежменттэй л холбоотой. Түүнээс төр мөнгөгүй болох ►

► ёсгүй. Төр том уурхайд хувьцаа эзэмшлээ гэж байна. Том өрөнд л орж байна гэсэн үг. Тухайлбал, Оюутолгойд хувьцаа эзэмшдэг. Хэрвээ уг төсөлд хувь эзэмшээгүй байсан бол эхнийхээ өдрөөс л татвараа аваад өнөөдөр нэмэх баланстай явж байгаа. Гэтэл хувьцаа эзэмшсэн учир тэр хувьдаа тааруулсан хөрөнгө оруулах ёстой, мөнгө байхгүй учраас зээлсэн. Зээл авсан тул хүү төлнө гээд л явчихаж байгаа юм. Ер нь Монголын улс төрийн бодлого, улстөрчдийн ааш араншин тодорхойгүй, тогтворгүй учраас хувийн хэвшлийнхэн төлөвлөлт хийхэд хүндрэлтэй байдаг.

-Төрийн компаниуд муу ажилладаг, хувийнх сайн гэсэн үг манайд бий.

-Компаниуд төрийнх байснаараа яах гээд байгаа юм. Төрийнх байснаар юу хожих гээд байгаа юм гэдэг асуулт гардаг. Компани гэдэг чинь хар ажил хийнэ л гэсэн үг. Тэр татварын машинаасаа орлогоо л авах сонирхолтой болохоос биш дотор нь эргүүлэг шурга болох хэрэг байгаа юм уу. Би үүнийг ойлгохгүй байгаа. Шаардлагагүй зүйлд заавал оролцох хэрэг байна уу.

Төр мөнгөгүй болж байгаа бол буруу бодлого, менежменттэй л холбоотой. Түүнээс төр мөнгөгүй болох ёсгүй

Аливаа бизнес өнөөдөр ашигтай ч, маргааш ашиггүй л байдаг. Тэгвэл төрийн нуруун дээр ард түмэн, хүүхэд хөгшчүүл, олон түмний амьдрал

байгаа. Гэтэл ийм олон хүнийг суулгасан байж морь шиг хаа хамаагүй давхиад байж болох уу. Хүүхэд нялхсыг, ахмадуудыг унагавал яана.

-Энэ удаагийн бизнес форумын гол онцлог юу байх бол?

-Хотын төсвөөр хийх төсөл хөтөлбөр ажлуудыг хувийн хэвшлийнхэнд танилцуулахаас гадна, тэдний санал санаачлагыг авъя, санал болгох төслийг сонсоё, зөвхөн форумын үеэр биш, дараа нь ч бизнесийнхнийгээ сонсдог, хүлээн авч уулздаг сувгийг бий болгоё гэж байгаа.

-Хотын иргэний хувьд таны мөрөөдөл?

-Хүн амьдрахад таатай, аюулгүй, найрсаг, иргэн бүр нь орлого олох боломжтой, гадны дотны хэн ч ирэх дуртай, орлого оруулж, мөнгөө үлдээгээд сэтгэл хангалуун явдаг нөхцөл бүрдсэн гоё хот байгаасай л гэж хүсэж байна. Мөн энэ онд хүмүүсийн амьдрал дээшлээсэй, бизнесийн шинэ шинэ боломжууд гараасай гэж л ерөөе. ■

Бүтээн байгуулалтын дээд шагналтнууд

Буянт-Ухаа хорооллын 972 айлын орон сууцыг ашиглалтад оруулна

Дотоодын томоохон таван компанийн нэгдэл Үндэсний бүтээн байгуулалтын корпораци нь 2015 оны Нийслэлийн бүтээн байгуулалтын дээд шагналыг “Буянт Ухаа-1” хорооллын ажлаар хүртсэн билээ. Тус корпорацийн ерөнхийлөгч Б.Жүгдэртэй ярилцлаа.



-“Буянт Ухаа-1” хорооллыг та бүхэн богино хугацаанд хийж гүйцэтгэсэн. Тус хорооллын бүтээн байгуулалтын ажил танай корпорацийн анхны ажил байсан уу?

-Тийм ээ, бид 2013 оны нэгдүгээр сараас эхлэн хамтарч бүтээн байгуулалтын ажлыг хийж байна. Тухайн онд Засгийн газраас дунд болон бага орлоготой иргэдэд зориулсан орон сууцны төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарч Орон сууц санхүүжилтын корпорацийг ТОСК болгон өөрчилсөн. Тэр үед бид удирдлага зохион байгуулалтын хүрээнд нэгдэж Засгийн газрын бүтээн байгуулалтын томоохон төслүүдэд оролцохоор шийдвэрлэсэн. Улмаар ТОСК-ийн захиалгаар “Буянт Ухаа-1” хорооллын 1764 айлын сууцны тендэрт хүчээ нэгтгэн оролцож, 2013 оны тавдугаар сараас барилгын ажилдаа орж 2014 ондоо ашиглалтад оруулсан. Бид тус хорооллын үндсэн барилгаас гадна 60 хүүхдийн хоёр цэцэрлэг, үйлчилгээний төвийн барилгууд, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилт хашааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Бидний энэ ажлыг Нийслэлээс үнэлж 2015 оны барилгын салбар дахь бүтээн байгуулалтын дээд шагнал “Хангарьд” цомыг олгосон.

-Хотын хөгжлийг нэг талаар шил даран сүндэрлэж буй барилгын бүтээн байгуулалтаар хардаг. Үүнд Үндэсний бүтээн байгуулалтын корпораци түүний бүрэлдэхүүн компаниудын барилгачид хэрхэн оролцож ирсэн бэ?

-Үндэсний бүтээн байгуулалтын корпораци нь харьцангуй залуу ч уг корпорацийг нэгтгэж буй компаниуд 10-80 орчим жил барилгын салбарт ажиллаж байна. Тухайлбал, “Улаанбаатар барилга” компани нь Монголын барилгын анхны байгууллага. Тус компани нь хотын бүтээн байгуулалтад 1990-ээд оноос оролцсон байгууллагын суурин дээр үүсч бий болсон. Тэдний түүхээс авч үзэхэд социализмын үед баригдсан сургууль, цэцэрлэг зэрэг бүх барилга тус компанийн барилгачдын гараар бүтсэн. “Улаанбаатар барилга” компани хамгийн сүүлд нарны гүүрний томоохон бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэсэн. “Дельта констракшн” компани нь

10 гаруй жилийн түүхтэй бөгөөд “Кристал таун, “Эмиралд резиденс” зэрэг өндөр хорооллыг барьсан байх жишээтэй. Бид хөрөнгө оруулагч биш. Барилгын цэвэр гүйцэтгэгчид. Манай корпорацийн бүрэлдэхүүнд 180 гаруй компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж буйгаас 100 орчим нь цэвэр барилгын ажил гүйцэтгэдэг, 80 гаруй нь барилгын материал, түүхий эд үйлдвэрлэдэг болон импортоор нийлүүлдэг. Нийт 6000 орчим хүний бүрэлдэхүүн бүхий томоохон корпораци.

Барилгын салбар дахь аж ахуйн нэгжүүд нэгдэн нийлэх замаар дотоодын зах зээлээ хамгаалах бодлогоор тус корпорацийг байгуулсан. Үүнд Засгийн газраас дэмжлэг үзүүлж, 2014 онд гадаадаас авах барилгачдын квотыг 20 хувиар

бууруулсан. Мөн бид салбарын удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, барилгыг богино хугацаанд чанартай барих, орон сууцны салбарт бодит үнийг тогтоох зэрэг бодлогыг хэрэгжүүлж байгаа. 2015 оны босгон дээр ТОСК-ийн захиалгаар 1620 айлын орон сууцны “Буянт Ухаа-2” хорооллыг 240 хүүхдийн цэцэрлэгийн хамт ашиглалтад орууллаа. Энэ оны эхний хагас жилд багтаагаад “Буянт Ухаа-2” хорооллын үлдэгдэл 972 айлын орон сууцыг ашиглалтад оруулна. Одоогийн байдлаар 18 барилгыг бүрэн угсарч дууссан. Өнгөрсөн онд хийхээр төлөвлөж байсан ч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан 30 орчим тэрбум төгрөгийн ажил он дамжин үлдээд байна. Үүнийг эхний хагас жилдээ багтан хийнэ. ■

Хотын зам дээр жил бүр урсгал засвар хийх ёстой

2015 оны Нийслэлийн бүтээн байгуулалтын дээд шагналын авто замын салбар дахь эзэн “Оч наран” ХХК-ийн салбарын захирал О.Наранбаатартай ярилцлаа. Тэрбээр авто замын гүүрийн инженер мэргэжилтэй бөгөөд салбартаа 14 жил ажиллаж байгаа юм.



-Бүтээн байгуулалтын дээд шагналыг авахад танай компани ямар шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан бэ?

-Бид нарны замыг 19 дүгээр хорооллын замтай холбох 48 метрийн урттай гүүр, туннель бүхий 1.5 км авто замын ажлыг 2013 онд тендерт шалгарч, өнгөрсөн онд хийж дуусгасан. Ингэхдээ замын гэрэлтүүлэг, дугуйн зам, тохижилтыг цогцоор нь хийж өгсөн. Нийслэлээс уг ажлыг төмөр замаар хоёр хуваагдсан хотын замын хөдөлгөөний төвлөрлийг сааруулах, Энхтайвны гүүрний ачааллыг 20-30 хувиар бууруулах зорилгоор хийлгэсэн. Энэ хүрээнд бид тус замын ажилдаа инженерийн олон байгууламжийг цогцоор нь шийдэж өгсөн төдийгүй Энхтайвны гүүрний ачааллыг бууруулах гол объект болсон тул энэ шагналыг хүртсэн гэж ойлгож байгаа. Замын ажлын нийт санхүүжилт болох 4.4 тэрбум орчим төгрөгийг Нийслэлийн Авто замын сангаас гаргасан.

-Нийслэлийн авто замын салбарт та бүхний оролцоотойгоор хийсэн томоохон ажлууд өөр юу байна вэ?

-Манай компани 1998 оноос хойш авто зам, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Авто замын салбар руу 2007 оноос шаргуу орсон. 2014 онд Налайх

хотын төвөөр 1.3 км явган хүн, дугуйн зам бүхий авто зам, Бээжингийн гудамжны доогуур орсон Сэлбийн эрэг дагасан 700 метр иж бүрэн замыг хийсэн. Мөн Бэлхийн таван км зам дээр “Үйлсийн зам” компанитай хамтарч ажилласан бөгөөд орон сууцны хорооллуудын доторх замын тохижилтын ажил зэргийг онцолж болно.

-Манай хотын замын ус зайлуулах систем муу үнэлгээ авдаг. Таны хувьд хотын замын төлөвлөлтийг хэрхэн харж байна вэ?

-Нийслэлийн Авто замын газар гэж хариуцсан байгууллагатай болсноор манай хотын замын салбарт хийж буй ажил хөгжингүй орнуудын хэмжээнд байгаа гэж мэргэжлийн хүний хувьд ойлгодог. Сүүлийн үед иргэдийн хэрэгцээнд тулгуурлан дугуйн замыг зам төлөвлөлттэй хамт хийж өгдөг болсон. Манай компанийн сүүлийн гурван жилийн бүтээн байгуулалтын бүх ажил дугуйн замтай холбоотой.

-Ер нь замд хэдий хугацаанд засвар шинэчлэлт хийх ёстой байдаг вэ?

-Манай улсын стандартаар 11 жилд урсгал засвар, 25 жил болоод бүрэн шинэчлэхээр байдаг. Гэхдээ хотын зам дээр жил бүр урсгал засвар хийх ёстой. Одоо бол замыг ашиглалтад оруулснаас хойшхи гурван жилийн хугацаанд гүйцэтгэгч байгууллага, үүнээс хойш Улаанбаатар нэгтгэл засварыг нь хариуцаад явж байгаа. Ялангуяа, манай цаг уурын эрс тэс байдал нь инженерийн байгууламжийг их хэмжээгээр эвддэг. Ус өөрөө гол эвддэг дайсан. Зам дээр үүссэн жижиг ч гэсэн хагарлыг ус оруулахгүйгээр нөхөх, гадны хүчин зүйлээс шалтгаалсан эвдрэлийг байнга арчилж, засах ёстой. Энэ арчлалт дээр мэргэжлийн байгууллагынхныг ажиллуулмаар байгаа юм.

-Та бүхэнд эдийн засгийн хямрал хэр мэдрэгдэж байна вэ?

-Хямрал компанийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа. Гэхдээ нийгмийн шаардлагаар замын бүтээн байгуулалтын ажлыг хийж байгаа тул төлөвлөсөн хугацаандаа дуусахын төлөө ажилладаг. Бидний хувьд хүн хүч олдохгүй бэрхшээл байна. Манай компани үндсэн 60, гэрээт 100 гаруй ажилтантай. Гэвч зуны улиралд үүнээс олон ажиллах хүчин хэрэгтэй болдог. Тэр үед нь Хөдөлмөрийн хэлтэст хандан, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зар өгөөд ч олдохоо байгаад байна. Хүмүүс ажиллах нөхцөл, цалинг нь голдог. Оюутнууд дадлага хийдэг ч үндсэн ажилтнаар авахад хүндрэлтэй. Учир нь тэд ажлын талбар дээр шууд ажиллахад бэлэн бус байдаг. ■

Хот төлөвлөлтийн хамгийн чухал ажил нь дулааны шугам

Барилга, сантехник, инженерийн шугам сүлжээ, эрчим хүчний барилга байгууламжийн угсралт, зураг төслийн “Хангилцаг” ХХК 1997 онд байгуулагджээ. Тус компани нь 2015 онд Нийслэлийн бүтээн байгуулалтын дээд шагналыг хүртсэн бөгөөд уг шагналыг хүртэхэд түлхэц өгсөн гол ажлын талаар компанийн дулаан, сантехникийн инженер Н.Эрдэнэхүүтэй ярилцлаа.



-Нийслэлийн бүтээн байгуулалтын дээд шагналыг хүртэхэд та бүхний 2015 онд хийсэн хамгийн гол ажлын үр дүн нөлөөлсөн гэж ойлгож байна. Уг ажлын талаар сонирхуулахгүй юу?

-Бидний өнгөрсөн онд хийсэн ажлуудаас хамгийн том нь хотын дулааны шугам сүлжээний гол хэсэг болох 3 а, б гэх магистрал шугамыг солих, шугам хоолойн угсралтын ажил байсан. Уг ажлаараа Нийслэлийн бүтээн байгуулалтын дээд шагнал, Хангарьд цомын эзэн болсон.

Улсын драмын эрдмийн театраас Төв шуудан, баруун дөрвөн замын чиглэлд нийт 1.7 км урттай хос шугамыг шинэчилсэн. Мөн тус хэсэгт Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын санаачлагаар 1.4 км-ын урттай цэвэр усны шугамыг хийсэн. Ер нь энэ чиглэлийн шугамын нэг хэсэг нь анх 1959 онд, нөгөө нь 1987 онд хийгдсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд шинэчлэлт огт хийгээгүй. Тиймээс шугамыг шинэчлэх, дулааны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалга, Хөгжлийн банкны санхүүжилтээр энэ ажлыг гүйцэтгэсэн.

Шугам хоолойд насжилт бий болж, маш их зэв гарч, хогжруу үүсч, ус алдсан байсан. Бид энэ хэсэгт 300-350 мм-ын диаметртэй шугам хоолой байсныг 500-600 мм болгож хүчин чадлыг хоёр дахин өргөтгөсөн. Мөн зам талбай, орчны тохижилтыг хамтад нь хийсэн. Ингэснээр захын хорооллуудад дулаан хангамж хүрэхгүй байх асуудлыг шийдэж өгч байгаа

юм.

Мөн өнгөрсөн онд Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд орон сууцны дулаан дамжуулах төвийн барилгыг иж бүрнээр нь барьж хүлээлгэн өгөөд байна.

-Танай компанийн хувьд өөр ямар байдлаар хотын бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэд оролцож ирсэн бэ?

-Өнгөрсөн хугацаанд зөвхөн нийслэлд гэлтгүй Монгол Улсын өнцөг булан бүрт бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулж ирлээ. Улаанбаатар хотын дулааны үр ашгийг дээшлүүлэх тал дээр бусад захиалагч байгууллагатай хамтран ажиллаж байна. Хотын дулааны хамгийн гол шугамуудын нэг болох дээр дурьдсан 3 а, б магистрал, Их болон бага тойрууг дулааны хангамжаар хангадаг 6 б, г гэх магистралууд мөн Хан-Уул дүүргийн дулаан хангамжийг найдвартай хангах зорилгоор “Атар өргөө” ХХК-ийн байрын зүүн талаар газар дээгүүр хийж өгсөн том шугамыг шинэчлэн газар доогуур бүрэн нэвтрэх сувагт оруулсан. Энэ нь хотын өнгө үзэмж талаас дорвитой ажил болсон төдийгүй газар доогуур хүн явж засвар хийх бүрэн боломжтой болгож өгсөн.

-Мэргэжлийн хүний хувьд та хотын дулааны шугам сүлжээний төлөвлөлтийг хэрхэн харж явдаг вэ?

-Дулааны шугам сүлжээнд манай орны өөрийн онцлог нөлөөлдөг. Зундаа маш өндөр халалттай, өвөлдөө хөрсөн дээрээ 30-40 хэм хүрдэг ийм нөхцөлд дулааны шугам төвлөрсөн шугамаас шийдэгддэг. Өндөр хөгжилтэй Япон, Солонгос зэрэг орон нь өөр өөрийн зохион байгуулалтаар шийддэг. Сүүлийн жилүүдэд Төр засаг, нийслэлийн зүгээс хотын шугам хоолой, дулаан төлөвлөлтийн асуудал дээр нэлээд анхаарч багагүй хөрөнгө гаргаж байгаа. Харин иргэд “хавар, зун болохоор л ухаад байх юм” гэж дургүйцдэг тал бий. Гэтэл шугам сүлжээний засварыг дулааны улиралд хийхгүй бол өвөл түүнээс их зардал ордог. Хотын төлөвлөлтийн хүрээнд хийх ажлын хамгийн чухал нь дулааны инженерийн ажил. Цаашид хотын тэлэлттэй холбоотойгоор дулааны инженер, шугам сүлжээний ажлыг хийх шаардлага их гарна. Учир нь барилга байгууламж барихын зэрэгцээ дулааны асуудлыг хамт шийдэж өгдөг шүү дээ.

-Та бүхний үйл ажиллагаанд эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал хэр нөлөөлж байна вэ?

-2015 онд бидний хийсэн Төв шуудангийн урд талын шугам сүлжээний ажил нь нийгэмд хамгийн чухал, шаардлага нь бүрдсэн ажил байсан тул бидэнд санхүүжилтийн тал дээр хүндрэл гараагүй. Манай компани инженер техникийн 15, тогтворт суурьшилтай 90 орчим ажилтантай. Харин зуны ажлын явцад ажилтны тоо 170-д хүрдэг. Энэ ажилд нийслэлийн төрийн өмчит болон хувийн олон компани хамтарч ажилласан гэдгийг энд хэлмээр байна. ■

Төсөл

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр

Төсөл 1-ийн хүрээнд: (i) бохир ус зайлуулах гол коллектор шугамын 6.1 км өргөтгөл, ариутгах татуургын шугамын 2.9 км өргөтгөл; (ii) дэд төвүүдэд тэргүүн ээлжинд баригдах 15 км авто зам, цэвэр усны 18.6 км шугам, ариутгах татуургын 20 км шугам, төвлөрсөн дулаан хангамжийн 21 км шугам, байгаль орчинд ээлтэй сүүлийн үеийн технологи бүхий халаалтын 5 байгууламж; (iii) нийгэм, эдийн засгийн байгууламжууд, үүнд: (а) хүүхдийн 2 цэцэрлэг, ногоон байгууламж, (б) дэд төвийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 2 төв, тэдгээрийг түшиглэн байгуулах бизнесийн 2 инкубатор; (iv) УСУГ-т үзүүлэх олон талт дэмжлэгийн хүрээнд түүний үйл ажиллагааны болон ус хангамж, бохир ус татан зайлуулах үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх; (v) институцийг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх дэмжлэгийг: (а) нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын ажилд хяналт тавих, (б) оршин суугчдын оролцоог дэмжих, тэдний ойлголтыг төлөвшүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; (в) дэд төвүүдийг дахин төлөвлөж хөгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох; (г) Хөтөлбөрийг удирдах алба (ХУА)-ны чадавхийг бэхжүүлэх;

(д) дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын шинэчлэлийг дэмжих чиглэлээр тус үзүүлнэ. Хөтөлбөрийг 2014-2023 оны хооронд нийт есөн жилийн хугацаанд гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Одоогийн байдлаар төслийн хэрэгжилт явагдаж байгаа ба дөрвөн төрлийн Зөвлөх үйлчилгээг БНСУ-ын (Дохва Инженеринг ба Солонгосын дүүргийн халаалтын корпорацийн түншлэл), БНФУ-ын (Эжис Интернэшнл), Япон улсын (Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн салбар) ба Энэтхэг улсын (Ай Пи Ии Глобал лимитед) байгууллагууд тус тус хэрэгжүүлж байна. Дэд бүтцийн шугам сүлжээ, авто зам ба нийгэм эдийн засгийн байгууламжуудын иж бүрэн ажлын зураг төсөл 2016 оны 2 дугаар сард багтан бэлэн болно. Санхүүжилтийн гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтын дагуу Улаанбаатар хотын захиргаа Төслийн 1-р үе шатанд нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх иргэдийг түр суурьшуулах зориулалт бүхий 50 айлын үйлчилгээтэй хоёр орон сууцны Төслийн дэд төвүүдэд өөрийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж дуусгаад байна.



Тээврийн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө ба хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд (i) Тусгай замын автобус (ТЗА)-ны дэд бүтцийн бүтээн байгуулалт (авто зам, гүүр ба зогсоол); (ii) Автобусны удирдлагын систем (АУС) Автобусны мэдээллийн систем (АМС)-ээс бүрдсэн ТЗА-ны системийг хөгжүүлэх. Үүнээс гадна нийтийн тээврийн салбарын чадавхийг бэхжүүлэх, дотоодын гүйцэтгэгч компаниудыг дэмжих, төслийн менежмент ба хэрэгжүүлэлтийн чиглэлээрх өргөн хүрээний ажлын байран дээрх сургалт ба салбарын шинэчлэлийн санаачлага зэрэг ажлууд хийгдэнэ.

Улаанбаатар хотын захиргаа нь Азийн хөгжлийн банктай хамтран нийтийн тээвэр ба замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээдэлсэн үр өгөөжтэй, төлбөрийн чадварт нийцсэн, байгаль орчинд ээлтэй тээврийн тогтолцоог хөгжүүлнэ. ТЗА нь нийтийн тээврийн системийн цөм хэсэг байх ба энэ хүрээнд дэд бүтцийг сайжруулах, бодлогын шинэчлэлийг хийх, чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл технологийн орчин үеийн аргуудыг нэвтрүүлэх, нийтийн тээврийг тусгайлсан замаар явуулах зэргээр зорчигчдын зорчилтод зарцуулах хугацааг багасгах, улмаар хэмнэсэн цаг хугацааг илүү эдийн засгийн бүтээмж бий

болгох үйл ажиллагаанд зарцуулах, ингэснээр иргэдийн (тэр дундаа орлого багатай иргэдийн) амьдралын чанар сайжрах нөхцлийг бүрдүүлнэ. ■





Дэлгүүр шиг шуурхай үйлчилнэ

Өдрийн сурвалжлага

Төрийн үйлчилгээний хувьсгал

Х.ХУЛАН

Төрийн үйлчилгээг нэг дороос шуурхай хүргэх, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх нь Засгийн газрын гол зорилт. Энэ зорилтын хүрээнд төр, иргэн, аж ахуйн нэгжээ ойртуулах, иргэдийн санал хүсэлтийг сонсох ажлын үргэлжлэл болж нэгэн том ажлыг эхлүүлжээ.

“Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн албан ёсны нээлтийн үйл ажиллагаа энэ сарын 14-нд болж, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл, НИТХ-ын дарга Д.Баттулга нар оролцож нээлтийн туузыг хайчилсан юм. Энэхүү үйлчилгээний төв нь “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлээс иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдийг нэг дор төвлөрүүлэн, учруулж буй хүндрэл чирэгдлийг багасгах зорилгоор байгуулагдсанаараа онцлогтой. Нээлтийн үеэр Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл хэлсэн үгэндээ “Саяхан нэг иргэн билдний өнөөдрийн нээж байгаа энэ төвд

ирж шаардлагатай бүх үйлчилгээг нэг цонхноос авч, найман нэрийн барааны дэлгүүрийн зөвшөөрлийн гэрчилгээг хүргэл албан тушаалтны гарын үсэгтэй нь баталгаажуулаад авсандаа бүр цочирдсон байна. Ингээд л миний зөвшөөрөл болчихсон юм уу гэж бүр дахин дахин лавласан гэнэ. Яг л ийм үйлчилгээг бид үзүүлэх гэж 25 жилийн турш хүсч, мөрөөдөн. Иргэд шаардлагатай бичиг баримтаа л аваад ирвэл аль ч даргын өрөөний үүдийг сахихгүйгээр хуулийн хугацаанд зорьсон ажлаа бүтээчихдэг боллоо шүү дээ” хэмээн онцлов.

Энэхүү төв нэг удаад 180, өдөрт 2880-6480 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай бөгөөд Нийслэлийн захиргааны 25 байгууллага, төрийн 230 гаруй үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлэх юм. Мөн ажлын өдрүүдэд уртасгасан цагаар, бямба гарагт мөн ажиллана. Түүнчлэн үйлчилгээний төвөөр иргэд асуудлыг ямар хугацаанд, хэрхэн шийдвэрлэхийг ойлгомжтой байлгах үүднээс өнгөөр ялгасан үйлчил-

гээний маягтыг нэвтрүүлсэн бөгөөд банк, нотариат зэрэг дагалдах үйлчилгээг иж бүрнээр нь бүрдүүлжээ. Тухайлбал, иргэдэд үйлчилж буй захиргааны ажилтан ногоон өнгөтэй хуудастай иргэнд асуудлыг нь шууд шийдвэрлэж өгч явуулах ба харин шар байвал нэг хоногийн дотор, улаан өнгөтэй бол бага зэргийн хугацаа шаардлагатай гэж ойлгох нь. Жишээ нь, барилгын зөвшөөрөл хүсч буй иргэний хүслийг биелүүлэхийн тулд барилга барих газарт нь очиж техник болон норм стандартыг хангаж чадсан эсэхийг шалгах хугацаа хэрэгтэй юм. Уг өнгөөр ялгасан үйлчилгээг гэрлэн дохионы гурван өнгөнөөс санаа авсан. Мөн иргэн бага насны хүүхэдтэйгээ хамт яваа нөхцөлд, ажлыг нь хөнгөвчлөх үүднээс хүүхэд саатуулах тоглоомын өрөө хүртэл байгаа нь тун догь.

Тус төвөөр үйлчлүүлж байсан СБД-ийн иргэн У.Байгальмаагаас сэтгэгдлийг нь сонсоход “Би өнөөдөр энд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтөө авахаар ирсэн. Энэ нь нэгдсэн үйлчилгээний төв нэг цэгийн гэдэг утгаараа шуурхай санагдаж байна. Өмнө нь дүүрэг дээрээ урт дараалалд зогсдог байсан болохоор хугацаа их алддаг байсан. Одоо бол тайлангаа өгөөд л асуудлаа шууд шийдвэрлүүлэх боломжтой болсонд баяртай байна” гэлээ.

Мөн энэхүү албан ёсны нээлтийн ажиллагааны үеэр шинээр мэндэлсэн ▶

► Нийслэлийн бяцхан иргэдэд төрсний гэрчилгээ, 16 нас хүрч буй охинд иргэний үнэмлэхийг нь гардуулах ёслолыг Ёслол хүндэтгэлийн танхимд хийсэн юм. Цаашид энгийн өдрүүдэд ч эдгээр ёслол, бүртгэлийн ажиллагааг тогтмол хийж байх гэнэ. Мөн иргэн өөрийн асуудлаар цахим угтах үйлчилгээний өрөөнд нийслэлийн удирдлагуудтай онлайнар холбогдож асуудлаа шууд шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

“Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг хотын гурван цэгт байгуулахаар төлөвлөсөн бөгөөд эхний ээлжинд Дүнжингарав худалдааны төвд байгуулж байгаа юм. Үүний дараа нь СХД-ийн Содон хороолол, ХУД-ын Мишээл экспо төв дээр тус тус байгуулахаар төлөвлөжээ. ■



Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Нэгдсэн үйлчилгээний төв дэх Ёслол хүндэтгэлийн танхимд шинэ мэндэлсэн хүүхдэд төрсний гэрчилгээ олголоо



Ё.Гэрэлчулуун: Удахгүй дахин ийм хоёр төвийг нээнэ



Дүнжингарав дахь нэгдсэн төвийн нээлтийн үеэр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ё.Гэрэлчулуунаас зарим зүйлийг тодрууллаа.

-Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийг анх ямар зорилгоор байгуулсан бэ?

-Иргэд өмнө нь аль нэг төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ урт дараалалд зогсож, хэн нэгэн ажилтны ая талыг харж байж үйлчилгээгээ авдаг байсан. Харин үүнийг бид халж, улам дэвшилттэй, ухаалаг системээр иргэддээ үйлчлэх байх үүднээс энэхүү төвийг байгуулсан. Өөрөөр хэлбэл, нийслэлээс иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдийг нэг дор төвлөрүүлж, зарим үйлчилгээний шийдвэрлэх хугацааг богиносгон, иргэдэд учруулах хүндрэл, чирэгдлийг багасгах зорилготой юм.

-Нэгдсэн төвийн бүтэц, зохион байгуулалтын хувьд хэрхэн ажиллаж байгаа вэ?

-Энэхүү төвд 25 байгууллагын 230

гаруй үйлчилгээ нэгэн зэрэг төвлөрч байгаа бөгөөд нийтдээ 180 гаруй хүн байнга ажиллаж байгаа. Энэ нь хэд хэдэн том ач холбогдолтой. Нэгдүгээрт, төвийг байгуулснаар төвлөрлийг сааруулах буюу механик утгаараа, хоёрдугаарт, иргэд ажилтантай шууд холбогдож асуудлаа шийдвэрлүүлж хугацаа алдахгүй байх. Гуравдугаарт, төрийн үйлчилгээг цахим болгох тал дээр хувьсгал хийж чадлаа. Одоо 230 гаруй үйлчилгээг интернэт холбогддог газар болгон онлайнар бүртгүүлээд эрхээ эдлэх бүрэн боломжтой. Тохируулга, цахим гарын үсгийн асуудлууд байгаа, үүнийг шийдэж чадвал энэ үйлчилгээ бүрэн утгаараа хэрэгжих бололцоотой болж байгаа юм.

-Уг үйлчилгээний төвийг байгуулахад хэдэн төгрөгийн хөрөнгө зарцуулсан бэ?

-Нэгдсэн үйлчилгээний төвийг байгуулахад манай Тамгын газрын ажилчдын 2-3 жилийн судалгааны үр дүн харагдаж байгаа. Бид их хэмжээний хөрөнгө мөнгө оруулаагүй. Барилга, засварын ажилд л 680 сая орчим төгрөгийн санхүүжилт хийсэн. Энэ нь засвар үйлчилгээ, техник хангамж, дотоод тоноглол зэрэг зүйлд зарцуулагдсан юм.

-Дараагийн хоёр нэгдсэн үйлчилгээний төв хэзээ байгуулагдах вэ?

-Одоо Дүнжингаравын нэгдсэн төв үйл ажиллагаа цэгцрээд эхэлчихлээ. Хоёр сарын дараа ХУД болон СХД-ийн төвийг байгуулна.

Дүнжингаравын нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвөөс дорх байгууллагуудтай холбоотой үйлчилгээг авах боломжтой:

Төвөөс дараах үйлчилгээнүүдийг авч болно

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- Захирагчийн ажлын алба
- Улаанбаатар Дулаан сүлжээ ТӨХК
- Улаанбаатар Цахилгаан түүгээх сүлжээ ТӨХК
- Мэдээлэл, холбооны сүлжээ ТӨХК
- Ус сүвгийн удирдах газар
- Нийслэлийн Архивын газар
- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Нийслэлийн Агаарын чанарын алба
- Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар
- Нийслэлийн Боловсролын газар
- Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар

- Нийслэлийн Өмчийн харилцааны газар
- Нийслэлийн Улсын бүртгэлийн газар
- Нийслэлийн Нийгмийн даатгалын газар
- Нийслэлийн Хөдөлмөрийн газар
- Нийслэлийн Нийгмийн халамжийн үйлчилгээний газар
- Нийслэлийн Авто замын газар
- Нийслэлийн Татварын газар
- Нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
- Нийслэлийн Соёл, урлагийн газар
- Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар
- Нийслэлийн Онцгой байдлын газар

Худалдан авалт

Ү.Энхтайван: Тендерт оролцогч хариуцлагажиж, төрийн байгууллагад хяналт тавих хэрэгтэй

Ц.ЭЛБЭГ

Энэ жилийн Улаанбаатар форум худалдан авалтыг онцолж байна. Мэргэжлийн байгууллагаас баримталж буй чиг хандлага, зарчмын талаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын орлогч Ү.Энхтайвантай ярилцлаа.

-Нийслэл хотоос хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, худалдан авалтын талаар яриагаа эхлэх үү?

-Нийслэл хот өргөжих тусам дэд бүтцээ сайжруулах, томоохон хэмжээний бүтээн байгуулалт хийх, нийгмийн асуудлаа шийдвэрлэх хэрэгцээ үүсч бүтээн байгуулалт, дэд бүтцийн чиглэлээрх худалдан авалтыг түлхүү хийж байна. Сүүлийн таван жилд Улаанбаатар хот төсвийнхөө бараг тавин хувийг хөрөнгө оруулалтад зарцуулж, энэ хэрээр худалдан авалтад илүү анхаарч байгаа. Дэлхийн хотууд нийт орлогынхоо 25-45 хувийг хөрөнгө оруулалтад зарцуулж, төвлөрсөн худалдан авалтыг мэргэжлийн байгууллагаар зохион байгуулж буй дүр зураг харагдаж байна.

-Худалдан авах ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулж мэргэжлийн байгууллага байгуулснаар ямар өөрчлөлт гарав?

-Мэргэжлийн байгууллага ажилласнаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох, худалдан авах ажиллагааны зохистой бүтэц тогтолцоог бий болгох, нэгдсэн хяналтын системийг хэрэгжүүлэх, чадавхитай хүний нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого үйл ажиллагаа бодитоор хэрэгжиж байна. Бид Улаанбаатар хотын худалдан авах ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Хэдийгээр баримт бичиг бүрэн албажаагүй ч мэргэжлийн байгууллагыг төлөвшүүлэх, худалдан авах ажиллагааг илүү үр дүнтэй, илүү ил тод, мэргэжлийн түвшинд явуулах бодлого, зарчмаа тодорхойлж, алхам алхмаар урагшилж байна гэсэн үг. Анхнаасаа бид тендерийн орчинг шударга, ил тод, нээлтэй болгохоос ажлаа эхлүүлсэн.



2013 онд төлөвлөх, зохион байгуулах бүх л үе шатанд ямар зөрчил гарч болох вэ гэдгийг тодорхойлж “Ашиг сонирхлын зөрчлийн зураглал”-ыг гаргасан. Үүнийхээ дагуу уг зөрчлүүдийг засаж залруулах арга замаа тодорхойлж, зохих ёсоор шийдэл гаргаж, түүнийгээ баримталж байгаа. Жишээлбэл, илт үндэслэлгүй хэт өндөр төсөв төлөвлөж зөрүү гаргадаг зөрчил өнөөдөр бүрмөсөн арилсан. Учир нь зураг төсвийг харилцан хянаж, алдааг залруулсны дараа тендерийг зарлах зарчмыг бид тогтоож чадлаа. 2013 оны нэгдүгээр сард зарласан манай эхний нэг ажилд 650 сая төгрөгийн ажлыг 1.3 тэрбум төгрөгөөр төлөвлөж батлуулсан тохиолдол гарсан. Манай инженерүүд шинжилгээ, дүгнэлт хийгээд 650 сая төгрөгийн тендер зарлаж зөрүүг төсөвт буцаасан.

-Тусгай инженерүүд ажил нэг бүрийн төсөв, зургийг хянаж ажилладаг гэсэн үг үү?

-Дутуу төсөвлөх, ямар нэг ажлыг хоёр газар давхар, эсвэл дахин, ашиггүй төлөвлөх гээд зөрчил үүсдэг. Тухайлбал, Дунд голын ар талаар шинээр зам тавих төлөвлөлт нь 1.3 тэрбум төгрөгийн

төсөвтэй дугуйн замын хамт орж ирсэн. Гэтэл өөр компани тэр трассын дагуу дугуйн замын ажил гүйцэтгэж байх жишээтэй. Энэ нөхцөлд аль нэг компани сул мөнгө авах, эсхүл хоёр компанийн нэг нь ажлаа хийгээд нөгөөгийнхөө мөнгийг хувааж авах зэргээр ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй. Мэргэжлийн байгууллага ажиллаж, төвлөрсөн худалдан авалт хийдэг болсноор энэ мэт алдаа зөрчлийг арилгаж төсвийн хөрөнгийг хэмнэхээс гадна аж ахуйн нэгжүүд хохирол амсах нь багассан гэж болно.

-Тендерийн сонгон шалгаруулалтыг шударга болгох талаар юуг анхаарч, өөрчилсөн бэ?

-Боловсон хүчнийг чадавхжуулах, шаардлага хангахгүй оролцогчийг шалгаруулахгүй байх, шударга бус хандах зэрэгт дэвшил гаргаж, энэ төрлийн зөрчлүүд буурсан. Ямартай ч худалдан авах ажиллагааг бүхэл тогтолцоогоор нь зөв зүгт чиглүүлсэн. Хурал дээр хэн нэгэн хүнийг дарамтлах, шахалт үзүүлж саналыг нь эргүүлэх боломжгүй болсон. Яагаад гэхээр хурлын бүх л процессыг дуу, дүрс бичлэгээр хянаж, төв серверт ▶

▶ архивлаж байна. Мөн нээлтийн үеэр өрсөлдөгчийг нь байлцуулж байгаад бичиг баримтыг хуулийн байгууллагад бүртгэлтэй лацаар битүүмжилж, гадны нөлөө оруулах өөрчлөхөөс сэргийлдэг болсон. Оролцогч бүрт шалгарсан, шалгараагүй үндэслэлийг маш нарийн тайлбараар хүргүүлж байгаа. “Танайх тэнцсэнгүй” гэдэг хариу хэзээ ч өгөхгүй. Үр дүнд нь тендерт оролцогчдын тоо өсч, гомдлын тоо буурлаа. 2013 онд нэг тендерт оролцдог өрсөлдөгчдийн тоо дунджаар 3.3 байсан бол 2015 онд ес болсон. Сүүлийн хоёр жилд 20-30 оролцогчтой тендерүүд ч олон байсан. Нэгж тендерт оролцож байгаа өрсөлдөгчдийн тоо өсч байгаа нь мэдээлэл хүргээмжтэй байгаагаас гадна тендерт ялах магадлалтай гэсэн итгэл нэмэгдэж байгаагийн илэрхийлэл байх.

-Цахим систем нэвтэрснээр ямар давуу болон сул тал гарч байна вэ?

-Хүний оролцоог бууруулах эхний алхам нь цахим систем юм. Давуу тал нь тусгай код ашиглан нэг удаа л татаж авахаар програмчлагдсан “KOICA”-гийн систем учир ямар нэг байдлаар мэдээлэл задрах, алдагдах зүйлгүй. Боловсон хүчин чадваржиж, систем нэвтэрч, хяналт сайжрахын хэрээр нэгж тендерийг зохион байгуулах хугацаа буурч үүнийг дагаад ашиг сонирхлын зөрчил орох магадлал ч багассан гэж үздэг.

Цаашид компаниудыг бүртгэлжүүлээд, мэдээллийг баталгаажуулж оролцогчийн чадварыг автоматаар үнэлдэг болох нь гол дэвшил юм. Компаниас зөвхөн үнэ, техникийн саналыг авч, худалдан авалтыг зохион байгуулна гэсэн үг. Өнөөдрийн түвшинд бид зөвхөн ирүүлсэн материалыг үзээд тендерийн үнэлгээ хийх биш хуулийнхаа хүрээнд аль болох өрсөлдөөн үүсгэж ялахгүй жижиг шалтгаанаар өрсөлдөөнөөс хасахгүйг эрмэлзэж байна. Тиймээс ч нэлээд олон байгууллагаас баримт нотолгоо цуглуулж үнэлгээндээ ашигладаг. Төр санах ойгоо ашиглаж, мэдээлэл солилцоо сайжирсан учир хуурамч материал бүрдүүлж тендерт ялах огт боломжгүй.

-Авлигын эсрэг ямар санаачилга, ажил хэрэгжүүлж байгаа вэ?

-Хуйвалддаг, авлига авдаг нөхдүүд сууж байгаад л тендерийг шийдчихдэг

юм шиг ойлголт одоог хүртэл явдаг. Нэг дарга хэсэг ажилтнаа удирдаад шийдвэр гаргаж тендер өгдөг түүх улирч баларсан шүү дээ. Хотын дарга тендерийн ажил тус бүр дээр түр хугацаагаар баг томилж захирамж гаргадаг. Энэ багт доод тал нь таван өөр байгууллагын төлөөлөл орно. Иргэний төлөөлөл, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл, чиглэлийн өөр өөр төрийн байгууллагын мэргэжилтнүүд саналын тэгш эрхтэй оролцдог. Харин нарийн бичгийн даргаар нь манай мэргэжлийн байгууллагын төлөөлөл яг ижил эрхтэй ажилладаг. Мэргэжлийн холбоод аж ахуйн нэгжүүдийнхээ эрх ашгийг хамгаалж тендер шударга явж байгаа эсэхийг хянах боломж нээлттэй.

Цаашид компаниудыг бүртгэлжүүлээд, мэдээллийг баталгаажуулж оролцогчийн чадварыг автоматаар үнэлдэг болох нь гол дэвшил юм. Компаниас зөвхөн үнэ, техникийн саналыг авч худалдан авалтыг зохион байгуулна гэсэн үг.

Гэхдээ анхаарах ёстой гурван зүйл бий. Удирдах албан тушаалтан болон түүний удирдлагад буй ажилтныг хамт томилохгүй, нэг багаар олон тендер зохион байгуулахгүй байхыг анхаарах ёстой. 2013, 2014 онд хотын даргын орлогчид үнэлгээний хороог даргалдаг байсан бөгөөд 250-570 ажлыг зургаа, долоон хүн даргалах учир ачааллыг зохицуулах, хурлын тоог цөөлөх буюу нэг удаагийн хуралдаанаар хэд хэдэн асуудал зэрэг шийдэх зорилгоор дунджаар нэг үнэлгээний хороонд 8-10 ажил ногдуулсан.

Хамгийн ихдээ нэг орлогч 40-50 ажлын үнэлгээний хороог даргалж байсан тохиолдол бий. Энэ нь сонгон шалгаруулалтын чанарт нөлөөлөх, багийн гишүүд тохиролцох, харилцан буулт хийх хандлага үүсч болзошгүй байсан. Иймээс тендерийг тухайн дүүргийн Засаг дарга нарт нь хариуцуулж нэг үнэлгээний хороонд ногдох ажлын дундаж тоог зургаа байхаар зохицуулсан. Сүүлд Сангийн яам дахин авч үзээд чиглэл хариуцсан хэлтсийн дарга нар үнэлгээний хороог ахалж байхаар шийдвэр гаргалаа. Дээрээс нь хөндлөнгийн хяналт, шалгалт эрс сайжирсан. Нэгж тендерийг Сангийн яам, Аудитын байгууллагууд шалгаж байна. Мөн Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын агентлаг, Нийслэлийн дотоод хяналт шалгалтын алба түүврээр болон ажил тус бүрээр шалгаж хянаж байна. Дүгнэлтүүд харьцангуй сайн, цөөн тооны жижиг зөрчлүүд гарч байгаа.

-Шууд гэрээний хувьд нээлттэй зарлах ёстой байсан гэдэг ч юм уу

маргаан үүсэх эрсдэл их гардаг уу?

-Шууд гэрээ байгуулах нь өөрөө хуультай. Тэр хуулийг давсан шийдвэр гарна гэж үгүй. Ер нь бол шууд гэрээ байгуулах эрх үүсчихсэн ажилд цаг хугацаа хэмнэх үүднээс шаардлага хангасан нэг компанитай гэрээ байгуулах эрхтэй. Гэхдээ бидний хувьд дор хаяж гурван компаниас үнийн санал авч өрсөлдүүлдэг зарчимд шилжсэн. Тендерт оролцогчдын бүртгэлээс чадавхитай компанийг шүүх учир гол өрсөлдөөн үнийн санал байна гэсэн үг. Өнгөрсөн жил нийслэлд хэд хэдэн автозамын тендерт шууд гэрээ байгуулсан. Нээлттэй зарлаад 150 орчим компани санал ирүүлснээс чадавхийн шалгуурт тэнцсэн 20 компанийг багц бүр дээр хуваарилан санал авч шалгаруулсан. Тэгэхээр үүнийг ханцуйдаа тохиролцож байна гэж болохгүй биз дээ.

-Эдгээр өөрчлөлтийг тендерт оролцогчид хэр хүлээж авдаг вэ? Тэдэнд анхаарах, мэдээлэл болгох зүйл юу байна вэ?

-Шалгуур өндөрсөөд, зохион байгуулалт нарийсаад ирэхээр зарим аж ахуйн нэгжүүд сүрддэг юм уу, хэн нэг хүнээр аргалуулах гэж оролддог байдал ажиглагдах юм. Өнгөрсөн жилүүдэд үнэлгээний хороонд ажилладаг төрийн албан хаагчид, иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг мөн тендерт оролцогчдоо чадавхжуулах зорилгоор хэд хэдэн удаа практик сургалт зохион байгуулсан.

Тендерт оролцогч хариуцлагажиж төрийн байгууллагад хяналт тавьж шахалт үзүүлж, шүүмжилдэг, гомдолдог байх хэрэгтэй. Дараагийн тендерт дахин таарна гэж эмээгээд хэн нэг мэргэжилтэн, даргын талаар гомдол гаргахгүйгээр хохирч үлдэж болохгүй. Манайх үнэлгээний хорооны нарийн бичгийн даргыг сольж томилж байна. Тендерийн гомдлыг нээлттэй хүлээн авч, хариуцлагатай шийдвэрлэдэг хяналт шалгалтын байгууллагууд бий.

-Төр үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, дотоодын бараа бүтээгдэхүүнээ худалдан авах нь зөв гэж Хотын дарга ярьдаг. Үүнийг бодлого үйл ажиллагаандаа хэрхэн тусгадаг вэ?

-Бодитой жишээ “Экобус”. Монгол Улс төдийгүй нийслэл хот дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан авах сонирхолтой. Гэхдээ эрх зүйн зохицуулалт бүрхэг, тунхаглалын чанартай яваад байна. Монголд үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнийг ▶

► гаднаас авахыг хориглосон мөртлөө Монголд угсарсан, үйлдвэрлэсэн, бойжуулсан гэдэг ойлголтыг хуульд тодорхой ялгаж зааглаагүй байгаа юм. Мөн Сангийн ямнаас гаргасан “Давуу эрхийн журам”-д хуулиа хязгаарласан заалтууд бий. Манай байгууллагын хувьд хуулийн үндсэн заалтаа барьж ажиллаж байна. Жишээлбэл, эм эмнэлгийн хэрэг сэл худалдан авах тендерт давуу эрх тооцохоор зарлаж, Монголд тариур үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжээс нийт барааныхаа 75 хувийг авахаар баталгаажуулсан компанид давуу эрх тооцож шалгаруулсан.

-Энэ жил бодлогын болоод зохион байгуулалтын хувьд авч хэрэгжүүлэх шинэлэг ажил юу байгаа вэ? Тендерт оролцогчдод тавьдаг шалгуур шаардлагад өөрчлөлт орох уу?

-Тендер зохион байгуулалтын хувьд бүх ажил хуулийн дагуу маш цэгцтэй явж байгаа. Сая төрийн байгууллагын зохион байгуулалт, архивын улсын үзлэг болж, Нийслэлийн хэмжээнд долоон байгууллагыг төв коммис шалгаж, манайд 98.99 үнэлгээ өгсөн бөгөөд улсын хэмжээнд гуравдугаар байранд орсон. Өөрөөр хэлбэл, тендер зохион байгуулалт хуулийн дагуу, тендерийн холбогдолтой бүх бичиг баримт цэгцтэй, бүрэн архивлагдсан гэсэн үг.

Бид өнгөрсөн жил аж ахуйн нэгжийн лавлагааг төрийн байгууллага хоорондын сүлжээг ашиглан шуурхай, хялбар солилцдог боллоо. Манай байгууллага нийслэлийн агентлаг, дүүргүүдийг нэгтгэсэн www.tender.ub-procurement.mn динамик системтэй болж, 2015 онд нийслэлд зохион байгуулсан тендерийн үе шат, оролцогч нэг бүрийн мэдээллийг бүртгэлээ. Энэ жил Засгийн газраас төрийн болон төсвийн хөрөнгөөр хийгдэж буй худалдан авалтыг бүртгэх нэгдсэн цахим бүртгэлийн систем шинээр бэлдэж байна. Нэг системд шилжсэнээр цахим үнэлгээ рүү алхам ойртохоос гадна тендер оролцогчид зөвхөн нэг л системээс төрийн бүхий л шатны худалдан авалтын мэдээллийг авах, төрийн санах ойд буй компанийн мэдээллээ баталгаажуулан шинэчилж байх шинэ боломж бүрдэх юм.

Өөр нэг зүйл бол Нийслэл худалдан авалтад даатгалын системийг ашиглах, бүтээн байгуулалт, үйлдвэрлэлтийг нийгмийн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй байдал руу чиглүүлэх эрмэлзэлтэй байна. Төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдэд

ойр орчиндоо аюулгүй, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулдаггүй, цагийн хуваарийн дагуу ажилладаг, аль болох байгаль орчинд ээлтэй техник, технологи ашигладаг байх шаардлага, стандартыг бид тавина. 2020 он гэхэд Засгийн газар хөрөнгө оруулалтынхаа 20-иос доошгүй, 2030 он гэхэд 30-аас доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй худалдан авалтад зарцуулах зорилт тавьсан.

Мөн тендер оролцох аж ахуйн нэгжүүд маш олон төрлийн батлан даалт гаргаж мөнгөн харилцаа үүсгэдэг. Худалдан авах чиглэлээр Азид тэргүүлдэг Солонгос, Сингапур, Тайваньд худалдан авалттай холбоотой батлан даалтуудыг даатгалаар зохицуулдаг. Баялаг бүтээгчид хөрөнгөө банкинд дэмий түгжихгүй мөн даатгалын систем хөгжих сайн талтай. Цаашлаад төрийн хөрөнгө оруулалтыг чанартай байлгах тал дээр даатгалын байгууллагууд давхар хяналт тавьж,


эрсдэлийн үнэлгээ хийж ажиллах юм. Бид энэ асуудлаар даатгалын байгууллагуудтай хамтран ажиллахад бэлэн байна. Шийдэл, төслөө хотын даргад танилцуулж хөрөнгө оруулалтын чанарыг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулахаас гадна аж ахуйн нэгжийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд даатгалын системийг ашиглах санаачилга амжилттай хэрэгжинэ гэж итгэж байна.

-Эдийн засгийн нөхцөл байдлын улмаас санхүүгийн шалгуур үзүүлэлтийг уян хатан байлгах боломжтой юу?


-Боломж бий. Борлуулалтын орлогын хэмжээг заавал олон жилийн дунджаар тооцох шаардлагагүй аль болох хөнгөлөлттэй нөхцөл тавьж өрсөлдөөн үүсгэх бодлого барина. Эдийн засгийн шалгуураас гадна байгаль орчин, нийгэмд ээлтэй хандлагыг бий болгоход чиглэсэн шаардлага тавихыг тендер сонирхогчид, үйлдвэрлэл эрхлэгчдэд дуулгая. ■

Нийслэлийн худалдан авах газар


НХААГ-т зохион байгуулсан тендерийн өрсөлдөөн ба гомдлын харьцаа




НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ 2016



Зохион байгуулагч байгууллага/төсөвт өртөг/



Зохион байгуулагч байгууллага/тендер/



ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ХУДАЛДАН АВАЛТ

Инженерийн шугам сүлжээ

Авто зам Гүүр хоолой Замын байгууламж

Техник тоног төхөөрөмж


Барилга байгууламж

Тохижилт ногоон байгууламж

Зөвлөх үйлчилгээ

Цахилгаан дамжуулах

Мэдээллийн технологи




БАТЛАГДСАН ТӨСӨВ /ТЭРБУМ ТӨГ/

НИЙТ АЖИЛД ЭЗЛЭХ ХУВЬ

АЖЛЫН ТОО

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР



НИЙТ ГАЗАР НУТГИЙН ХЭМЖЭЭ, ГА, ЗОРИУЛАЛТААР

	61479.5	Хот тосгон бусад суурин газар
	5871.5	Зам шугам сүлжээний газар
	244143.6	Хөдөө аж ахуйн газар
	74043.3	Ойн сан бүхий газар
	4078.1	Улсын тусгай хэрэгцээний газар
	5871.5	Усны сан бүхий газар

ХҮН АМ

▶ Хүн ам: (2014)

1 341 486



▶ Шилжин ирсэн хүн:
861 400

▶ Төрөлт: **37 672**

▶ Шилжин явсан:
10 009



▶ Нягтшил:

279 / км²





▶ Гэрлэлт:


7933

▶ Цуцлалт
2293


▶ ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ
ХҮН АМЫН ТОО:
861 400




▶ ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ
НИЙТ ХҮН АМЫН
65%



ХҮН АМЫН ӨСӨЛТ ↑



ОРОН СУУЦНЫ БА ГЭР ХОРООЛОЛ



АГААРЫН БОХИРДОЛ



БОЛОВСРОЛ



Байгаль орчин

Улаанбаатар Монгол Улст



Газар нутаг
0.3%

Хүн ам
44%

ДНБ
63%

Хадгаламж
84%

Авто тээврийн хэрэгсэл
84%

Гаргасан зээл
77.9%



Богд уулын арын шинэ зам

Дэд бүтэц

Хөгжилд хөтлөх замууд

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Хотын зам. Нэгэн үе бөөн нүх, нөхөөс болсон энхэл донхол байсан үе одоо дурсамж болжээ. Улаанбаатарын олон жолоочын сайхан, муухай дурсамжууд нь тэр цаг үетэйгээ хуучирсан байх. Өнгөрсөн хэдэн жилд хотын доторх замууд саруулхан, саадгүй, уулзварууд уужим болсон. Нэлээд ч их хөрөнгө хүч хаясан биз. Харин өнгөрсөн нэг жилийн хувьд хотын алслагдмал хязгаарт хүрэх замуудад илүүтэй анхаарсан жил байлаа.

Зуны хэдэн сард хот эзгүйрч, хөл татардгийн шалтгаан нь амралт зугаалгын улирал тохиодогтой холбоотой. Энэ үе нь нийслэлийн нүүдэлчид зусландаа буудаг цаг. Үүнтэй холбоотойгоор хотын замын ачаалал төв зам дагуу бус зуслан чиглэлд төвлөрдөг. Хамгийн их ачаалал үүсдэг нь хойд чиглэлд. Энэ чиглэлд зуны улиралд 100 мянга гаруй тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцдог гэсэн тоо бий. Бараг нийслэлийн замын хөдөлгөөнд оролцож буй нийт тээврийн хэрэгслийн тэн хагас нь гэсэн үг. Гэтэл тус чиглэлийн замд 30-40 жил огт засвар шинэчлэл хийгээгүй, жолооч нарын төдийгүй зорчигчид ч явахаасаа халширдаг болоод байлаа. Дамбадаржаагийн цагдаагийн посттой уулзвараас Шадивлангийн шинэ уулзвар-Шаргаморьт-Хандгайт чиглэлийн

16.35 километр авто замыг өнгөрсөн онд бүрэн шинэчилсэн. Энэ замыг өргөтгөж шинэчилснээр тээврийн хэрэгсэл тогтмол хурдтай явж, хотын төв зуслангийн хооронд зорчих хурд нэмэгдэж байна.

Нийслэлийнхний зуслангийн нэг төв нь Гачуурт. Нийслэлийн зүүн бүсэд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Улиастай-Гачуурт чиглэлийн замыг барьж ашиглалтад оруулснаас хойш мөн л 30-аад жил өнгөрчээ. Хуучин авто замын зорчих хэсгийн өргөн долоон метр, нийт далангийн өргөн 10 метр байсныг өргөтгөн шинэчилснээр далангийн өргөн 12 метр, зорчих хэсгийн өргөнийг найман метр хоёр эгнээтэй болгосон юм. Шинээр 27 цэгт автобусны буудал байгуулж, замын трассын дагууд байрлах 36 болон 18 урт метр төмөр бетон хоёр хуучин гүүрийн ачаалал даах чадварыг нэмэгдүүлжээ. Замын турш урд талаараа гэрэлтүүлэгтэй, хойд талаар явган хүний зам шинээр барьж өргөтгөсөн байна. Найман цэгт ус зайлуулах төмөр бетон хоолойг засварлаж шинээр нэг төмөр бетон хоолойг хийж гүйцэтгэсэн аж. Тус авто зам, замын байгууламжийг засварлан шинэчилснээр БЗД-ийн 20, 23, 28-р хорооны оршин суугчид болон Гачуурт чиглэлд явах тээврийн хэрэгсэлтэй иргэд аваар осолгүй, ая тухтай зорчих нөхцөл бүрдсэн. Мөн

авто зам дээгүүр хөдөлгөөнд оролцох хурд нэмэгдсэнээс гадна авто машинуудад шатахууны хэмнэлт гарч, орчны агаарын бохирдол буурч, тээврийн хэрэгслийн элэгдэл багасч оршин суугчдын амьдралын багалгаажих түвшин дээшлэх зэрэг байгаль орчин, нийгэмд үзүүлэх дам нөлөө, ач холбогдол ихтэй юм.

Дараагийнх нь, Хан-Уул дүүргийн алслагдсан хорооны иргэдийн олон жилийн хүлээлт, хүсэлт болсон Өлзийт хорооллоос Биокомбинат-Шувуун фабрик чиглэлийн 9.06 километр авто замын ажлыг өнгөрсөн жил хийж гүйцэтгэлээ. Өлзийт хорооллын иргэд зам сайтай, сургууль, цэцэрлэгтэй болж, хотын төв рүү нийтийн тээврээр зорчдог болох хүсэлтээ үргэлж илэрхийлдэг байв.

Харин 2015 онд эдгээр асуудлыг бүрэн шийдэж, шинэ автозам, нийтийн тээврийн үйлчилгээ тэдэнд хүрлээ. Тус замыг 1991 онд барьснаас хойш бас л их засвар, шинэчлэлийн ажил огт хийгээгүй аж. Карьерийн болон хүнд даацын авто машинууд зорчсоны улмаас эвдрэл гэмтэл ихээр гарч байгаа тул шинэ зам бариулах иргэдийн хүсэлтийн дагуу тус замыг Концессын гэрээгээр “Ди Ар Жэй” ХХК он дамжин гүйцэтгэжээ. Гүйцэтгэгч 2014 оны тавдугаар сард ажлаа эхлүүлж өнгөрсөн оны есдүгээр сард авто замын барилгын ажлыг бүрэн дуусгасан юм. Ингэснээр зам нь хоёр эгнээ зорчих хэсэгтэй, зорчих хэсгийн хоёр талд гурван метрийн явган зам, нийт уртад 26 ширхэг ус зайлуулах төмөр бетон хоолой, 8700 урт метр аюулгүйн хашилт хайстай, суурьшлын бүс болон эхлэл төгсгөл хэсэгтэй нийт 5000 урт метр гэрэлтүүлэгтэй болж ирж бүрэн шинэчлэгджээ.

Нэгэнт хотын зам харилцаанд гарсан өөрчлөлтийн тухай хөндөж байгаа учир хотын дотор хийсэн нэг том ажлыг дурдалгүй өнгөрч болохгүй. Нарны замыг 19 дүгээр хорооллын арын замтай холбох 1.5 км авто зам, 58.18 урт метр төмөр бетон гүүр, төмөр зам доогуур нарны замтай холбогдсон 22 урт метр нүхэн гарцыг шинээр байгуулсан. Зам ашиглалтад орсноор Нарны зам болон Дунд голын замын ачаалал 800 машин/цаг. 19 дүгээр хорооллын арын замын ачаалал 20-30 хүртэл хувиар буурах гэж тооцоо бий. Түүнчлэн дүүргийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл явах гол замуудын нэвтрүүлэх чадвар сайжирч улмаар хотын баруун хэсгийн замын хөдөлгөөний урсгал нэмэгдэн төвийн хэсэгт хөдөлгөөний ачаалал буурах юм. Шинээр барьсан зам нь долоон метр өргөн, хоёр эгнээтэй бөгөөд ▶

▶ 1.5 метр өргөнтэй явган хүний зам, ногоон байгууламж, бүрэн гэрэлтүүлэгтэйгээс гадна гурван метр өргөн дугуйн замыг давхар шийдэж өгсөн. Төмөр зам доогуурх нүхэн гарцын хувьд жижиг тэрэг явахад зориулагдсан. Ийнхүү галт тэрэгний цагийн хуваариас үл хамааран төмөр замаар нэвтрэх боломжтой боллоо.

Эцэст нь дурдах зүйл бол эртнээс яригдсан автобусны тусгай замтай болох асуудал. Төслийн эхний шатны санхүүжилт шийдэгдлээ. Хөтөлбөрийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас нийтдээ 215.9 сая ам.доллар, Дэлхийн байгаль орчны байгууллагын буцалтгүй тусламжаар 1.5 сая ам.доллар, Засгийн газраас 57 сая ам.долларын хөрөнгө


оруулалтыг гурван үе шаттай хийх юм. Нэгдүгээр шатны санхүүжилтийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 59.9 сая ам.долларын хөнгөлөлтэй болон энгийн эх үүсвэрийн холимог зээл, Дэлхийн байгаль орчны байгууллагын 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламж, Засгийн газрын 17 сая ам.долларын санхүүжилт хийж ажлыг эхлүүлэхээр болсон. Энэ хөрөнгөөр босоо тэнхлэг 77 км зам болон дэд бүтцийг сайжруулах, Энхтайвны гүүрний өргөтгөл, автобусны буудлууд байгуулж тохижуулах, автобусны байршил тогтоох удирдлагын систем нэвтрүүлэх ажлыг хийх юм. Тусгай замын автобустай болсноор зөвхөн нэг чиглэлд л цагт 8000-25000 зорчигчийг тээвэрлэдэг болох юм. ■

ажлыг цаашид ч үргэлжлүүлэхээр 68 шинэ байршил тодотгон, тодорхой судлагааны ажлуудыг хийж байгаа юм байна. Тэгэхээр иргэд газаргүй үлдчихвий гэж айн суух хэрэггүй аж.

Хийж буй ажлынхаа талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, Улаанбаатар хотын захиргааны болон Нийслэлийн өмчийн харилцааны газрын цахим хуудас гэх мэт олон сувгаар хүргэж байгаа нь иргэдэд олон талт мэдээллийн эх сурвалж болох төдийгүй сонголт хийх давуу талууд олгож байгааг Ц.Шижир дурдсан. Улмаар нийслэлийн оршин суугчид тухайн газар хотоос хэдэн км зайд орших болон зам, шугам сүлжээ ямар байхаас эхлээд нийгмийн үйлчилгээний дэд бүтцүүдэн байгуулалт гээд газартай холбоотой бүх мэдээллийг авч, үүндээ үнэлэлт дүгнэлт хийн хүсэлтээ илгээж байгаа аж. Харин цахим ертөнцөд нэвтрэх боломжгүй иргэдэд хүрэх үүднээс нийслэлийн 152 хороонд сургалт, семинар, уулзалт зэргийг зохион байгуулахын зэрэгцээ 18001285 гэсэн тусгай утсаар санал, хүсэлт хүлээн аван тэдэнд заавар, зөвлөгөө өгч байгаа

Өмч

Марафон



Б.ҮҮРИЙНТУЯА

Иргэдийн дунд “үндэсний сугалаа” явуулан орон байртай болохыг нь шийддэг жишгийг цэцэрлэгийн насныханд ч туршиж эхэлсэн өнгөрсөн намраас. Сонгогдох гэсэн иргэдийн марафон. Үүнтэй адил зарчмаар иргэд цахимаар газар өмчлөөд нэлээд хугацаа өнгөрчээ. Үр дүн юу байв?

Сонгогдох аз нь ивээсэн 68 мянган иргэн газартай болоод байна. Газартаа тэд шууд очоод бууриа сэлгэх цаг хараахан болоогүй ч 52 байршилд, давхардсан тоогоор 923168 хүнээс шалгарч албан бичиг баримт бүхий эдийн засгийн эргэлтэд орох чадамжтай, тодорхой үнэ бүхий объектийн эзэд болсон.

Иргэдэд газар цахимаар өмчлүүлэх ажил өнгөрсөн оны хаалтаа арванхоёрдугаар сард хийсэн. 2015 оны

сүүлийн “сонгон шалгаруулт” өнгөрсөн арванхоёрдугаар сарын 14-30-ны хооронд бүртгэлээ явуулсан бөгөөд 140 мянган иргэн бүртгүүлжээ. Дахин 8000 иргэний газрын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа талаар Нийслэлийн өмчийн харилцааны газрын Газар өмчлөл, өмчийн менежментийн хэлтэсийн ахлах мэргэжилтэн Ц.Шижир хэлсэн бол тэдний асуудал саяхан шийдэгдэн 8088 иргэн газраа өмчлөх эрхтэй болжээ. Улмаар 76 орчим мянган иргэн газраа өмчлөн авчээ. Зөвхөн хуваарилалт хариуцаж буй тус газраас мэдээлэхдээ газар өмчлөл гурван чигт (цахимаар газар өмчлүүлэх, зуслангийн зориулалтаар эзэмшиж байгаа болон гэр хорооллын газруудыг үргэлжлүүлэн өмчлүүлэх) зүглэж байгаа. Түүнчлэн цахимаар газар өмчлүүлэх

гэдгийг холбогдох газраас хэлсэн.

Өндөр настан, асран хамгаалагчгүй иргэд харьяа дүүрэг, хороонд хандах боломж бүрэн нээлттэй төдийгүй хүсэлт гаргасны дагуу цахимд бүртгэж өгөх зэрэг ажлыг холбогдох байгууллага, анхан шатны нэгжүүд (хороо) зохион байгуулж иргэдэд дэмжлэг үзүүлж ажилласан байна.

Үе шаттай хэрэгжих энэ ажил 2018 он хүргэл явах, шаардлагатай бол үргэлжлэх бөгөөд улс төр орчихгүй бол тэр үед Улаанбаатарын бүх оршин суугч газар эзэмшигч болчихсон байх юм байна. Энэ нь ч газар өмчлөлийн үндсэн гол зорилго.

Иргэдийн хамгийн түгээмэл асуудаг зүйл нь дэд бүтэцтэй холбоотой байдаг аж. Эрчим хүч, зам тээвэр газар эзэмших болсон хэн бүхний хувьд чухал. Тэгвэл газар өгсөн нь үнэн, авсан бол бусдыг ▶

2003-2014

11 жилийн
хугацаанд

98000

хүнд газар олгосон

2015

1 жилийн
хугацаанд

76000

хүнд газар олгосон

**Газрын цахим бүртгэл ирэх
хоёр жил улс төрийн золиос
болчихгүй бол үргэлжилнэ**

► нь өөрсдөө шийд гээд орхихгүй гэдгийг албаны эх сурвалж хэлсэн. Тийм ч учраас Нийслэлийн ерөнхий төлөвлөлтийн газраас төлөвлөгөө баталсны дараа хуваарилалтыг Нийслэлийн өмчийн харилцааны газар оноогдсон үүрэг, гарсан захирамжийн дагуу гүйцэтгэж буй. Өмчлөлд оноож буй байршлуудын дийлэнхэд эдгээр асуудлыг шийдвэрлэн заажээ. Харин цахилгаан ороогүй, жишээлбэл Улайстайд үүнийг зохицуулахаар ажиллаж байгаа талаар дууллаа. Харин хашаагаа хагтах гэтэл нэгдсэн журмаар орон сууц барина эсвэл хэдий иргэний өмч ч гэлээ зоргоороо ашиглах эрхгүй гэх мэт яриа дэгдсэнийг тодруулахад иргэний шууд өмч учир ямар зориулалтаар ашиглах ёстой зэрэгтэй холбоотой албан заалт, хориг байхгүй гэдгийг Ц.Шижир уламжилсан. Иргэд гагцхүү өмчилж буй газрын хэмжээндээ тааруулан ашиглах эрхээ эдлэх учиртай аж.

Газартай болох марафонд оролцох боломж ямар ч байсан 2018 он хүртэл нээлттэй. Бүртгүүл. Энэ удаа сонгогдсонгүй гэхэд ирэх удаа гэсэн найдвар байх нь. Хоёр жилийн турш. Хэрэгцээт мэдээллийг харин албаны эх сурвалжуудын бий болгосон нээлттэй сувгуудаар дамжуулан авах нь ам дамжсан ямар ч ярианаас итгэж болохуйц нь гэдгийг иргэд мөн санах хэрэгтэй. ■

Газрын цахим бүртгэлийн талаар та юу хэлэх вэ?

Д.Баярмөнх/СХД-ийн 27 хорооны иргэн/

-Газар өмчлөлийг цахим бүртгэлээр явуулдаг болсон нь маш сайн зүйл болсон.



Хамгийн анхны цахим бүртгэлийг нийслэлийн долоон байршилд зарлахад манай 4 настай охинд газар таарсан. Таарах таарахдаа хамгийн их хүн бүртгүүлсэн Сонгинохайрхан дүүргийн Соёондын аманд олгогдсон. Цахим бүртгэлийн эхний ээлж хүлээлттэй байсан болоод ч тэр үү, маш их өрсөлдөөнтэй байсан. Соёондын аманд гэхэд л 20 гаруй мянган хүн бүртгүүлж, түүнээс 4000-д нь л газар олгогдохоор байсан. Тэгэхээр энэ бол маш шударга зүйл болсон. Газар өмчлөл 2003 онд анх эхэлсэн цагаасаа л хүнд суртал, арын хаалга, авлигатай холбоотой хардлагын үгс зүүлттэй явсан асуудал шүү дээ. Цахим бүртгэл үүнд цэг тавьж чадсан гэж бодож байна.

Г.Цэрэнсүрэн/БНСУ, Тэжон хот/

-Өнгөрсөн хавар цахимаар газар таарсан гэж ах дүүсээсээ сонсоод, миний Монголын тэнгэр намайг мартаагүй юм байна гэж маш их баярласан. Эх орноосоо гарч, харийн бэр болсныхоо төлөө сайн сайхан зүйл ховор сондог надад энэ бол аавын нөмөр шиг санагдсан. Би харийн бэр болж дэлхийгээр тархсан сайхан монгол эмэгтэйчүүдийн нэг төлөөлөл шүү дээ. Харийн хүнтэй суусан эмэгтэйчүүдийг гаднынхан ч, хамт гадаадад байгаа элэг нэгт монголчууд нь ч сайн үг хэлдэггүй, нүд үзүүрлэдэг.



Гэтэл эх нутаг нь холоос харж үзэж байна гэдэг үнэхээр сайхан. Газрыг цахим бүртгэлд оруулж, гадаад дахь монголчуудаа мартаагүй гэдгээ харуулж, тэднийг эх орондоо үл хөдлөх хөрөнгөтэй болох боломжийг олгох сайхан ажил зохион байгуулж буй төрийн байгууллагынханд баярлалаа гэдгээ уламжилъя.

И.Багтогтох/Чингэлтэй дүүргийн иргэн/

-Манай ах дүү, хамаатан садангуудын ихэнх нь цахим бүртгэлээр газартай болсон. Хоёр настай охиноос маань эхлээд 80 настай ээжид маань хүртэл таарсан. Ялангуяа настай хүний хувьд ээж маань газар таарсан байна гэж дуулгахад их л баяртай байсан. Би ч гэсэн ээжийнхээ баярлахыг хараад давхар баяр төрж суулаа. Тэр газар дээр очиж амьдрах амьдрахгүйдээ гол нь биш, шударга зарчмаар явагдаж байгаа шалгаруулалтаас аз таарч байгаа нь өөрөө тухайн хүндээ баярлах сэдлийг өгдөг байх.



Тэр бүлийн гишүүдийнхээ газрыг тоолбол, нийслэлийн Сонгинохайрхан, Налайх, Багануур, Багахангай гээд нэлээд олон газар бий. Одоо тэгээд хотын захиргааны зүгээс тэр газруудын төлөвлөлтийг өмнөх алдаанаасаа сургамж авч, одоогийн дахин төлөвлөлттэйгээ уялдуулж ямархуу суурин газар болгох вэ гэдэг дээр нэлээд бодох хэрэгтэй байх.

Х.Төрмөнх/Оюутан/

-Миний бие Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны иргэн, бас оюутан. Цахимаар газартай болох талаар юу ч мэдээгүй бодоогүй явсан чинь хамаатны маань ах эгч хоёр манай гэрийнхнийг цахим бүртгэл болох тоолонд байнга бүртгүүлсээр байгаад ганц би ч биш, манай гэрийнхнийг бүгдийг нь газартай болгож өгсөн. Ах, эгч хоёртой энэ дамшрамд баярлалаа гэж хэлье.



Надад өнгөрсөн хавар СХД-ийн Хүй долоо худгийн хөндий гэдэг газарт газар өмчлөх эрх таарсан. Эр хүний хувьд наадам болж, хурдан морь уралддаг газарт таарсанд их бэлэгшээж байгаа. Газар дээрээ гоё орчин үеийн хаус барьж, утаагүй орчинд ая тухтай амьдарна гэж мөрөөдөж байгаа. ■



ТИТАНИУМ

карт

Монголд АНХ УДАА



UnionPay Your Way

Үеүрөг дэлхийд гарлаа...

Мэргэжилтний үг

С.Энхцэцэг: Арбитр нь маргааныг шуурхай шийдвэрлэдгээрээ шүүхээс ялгаатай

Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Арбитрын дарга С.Энхцэцэгтэй ярилцлаа.

-Арбитрийг иргэд, олон нийт сүүлийн үед нэлээд сонирхох боллоо. Арбитр гэж ямар байгууллага байдаг, ямар чиг үүрэгтэй талаар эхлээд танилцуулна уу?

-Бизнесийн аливаа гэрээ хэлцлээс үүссэн маргааныг гэрээний талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр мэргэшсэн хөндлөнгийн этгээдээр шийдвэрлүүлэх шүүхийн бус арга механизм гэж ойлгож болно. Арбитр нь түр болон байнгын хэлбэртэй. Тодорхой маргааныг шийдвэрлүүлэх зорилгоор талууд нэг удаа байгуулсан арбитрыг түр арбитр буюу олон улсын нэршлээр Ad hoc гээд байгаа юм. Байнгын арбитр бол бизнесийн маргаан шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан байнгын үйл ажиллагаа бүхий институт. Манай хуулиар Худалдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын дэргэд байнгын арбитрыг байгуулж болохоор хуульчилсан байдаг. Байнгын арбитрын нэг онцлог нь маргаан шийдвэрлэх өөрийн дүрэмтэй байх явдал юм. Аль нэг арбитрыг сонгосон талууд тухайн арбитрын маргаан шийдвэрлэх дүрмийг мөн дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг.

Арбитраар хэрэг хянан шийдвэрлэх арга нь дэлхий нийтэд 220 гаруй жилийн түүхтэй бөгөөд Монгол Улсын хувьд анх 1929 онд Шүүх арбитрын яам байгуулагдан улмаар Улсын Арбитрын Газар болон үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүхтэй.

-Шүүхээс юугаараа ялгаатай болон давуу талтай вэ?

-Гол ялгаа нь маргааныг талуудын чөлөөт тохиролцоон дээр үндэслэсэн, мэргэжлийн өндөр түвшинд, уян хатан, зардал чирэгдэл багатай, шуурхай шийдвэрлэдэг тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, талууд маргаанаа шийдвэрлэх



арбитрчаа сонгох, тодорхой үндэслэлээр арбитрчийг татгалзан гаргах, маргаан шийдвэрлэх ажиллагааны журмыг тохиролцох, арбитрын ажиллагаа явуулах газар, хэлээ сонгох, мөн маргаанаа шийдвэрлэх хэлбэрээ сонгох тухайлбал биечлэн оролцох хуралдаан, эсхүл зөвхөн нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргах аргыг сонгох эсэх нь талуудын хувьд чөлөөт сонголт гэж ойлгож болно.

Бас нэг том давуу тал нь арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байдаг. Энэ нь арбитрын шийдвэрийг давж заалдах гэсэн ойлголт байхгүй. Зөвхөн Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд харшилсан эсхүл маргааныг шийдвэрлэх явцад процессын журам зөрчсөн тохиолдолд л хүчингүй болохоор хуульд заасан байдаг.

Заавал биелэгдэх шинжийн хувьд Монгол Улс 1958 оны Нью Йоркийн “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай” конвенцэд 1995 онд нэгдэн орсон учраас манай улсын арбитрын шийдвэр дэлхийн 156 оронд заавал биелэгдэх онцлогтой. Нөгөө талаар бизнесийн харилцаа улам нарийн төвөгтэй, олон улсын чанартай болж байгаа өнөө үед аливаа

маргааныг мэргэшлийн өндөр мэдлэг, ур чадвартай гадаад, дотоодын мэргэжилтэн арбитрчаар шийдвэрлүүлэх боломжтой болж байгаа юм.

Харин шүүхээр маргаан хянан шийдүүлэхэд талууд шүүгчээ сонгох, маргаан шийдвэрлэх ажиллагааны журам, аргыг сонгох боломжгүйгээр барахгүй, давж заалдах, хяналтын гээд олон шаг дамжлага ихтэй. Гэхдээ арбитрын тогтолцоог хэт чөлөөт, либерал гэж ойлгож болохгүй. Арбитрын шийдвэрийг биелүүлэх, арбитрын хариуцлага өндөр байх, талуудын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах шаардлагын үүднээс зарим харилцаанд шүүхийн оролцоо байхаас аргагүй. Олон улсын практикт ч ийм байдаг. Гэхдээ энэ нь зохистой түвшинд, хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд байх ёстой.

-МУХАҮТ-ын дэргэд арбитр байхад дахин шинийг байгуулах шаардлага байгаа юм уу, чухам юугаараа ялгаатай вэ гэх мэт асуулыг хүмүүс сонирхож байгаа?

-Улаанбаатар хотын Худалдааны Танхим нийслэл хотын хөрөнгө оруулагчдад ээлтэй, цэвэр, тунгалаг засаглал бүхий бизнесийн таатай, тогтвортой орчин болгох зорилт тавьж, улмаар олон улсын бизнес, санхүүгийн төв болгох алсын хараатайгаар 2015 онд байгуулагдан ажиллаж байна. Нийслэлд бизнес эрхлэгчид нэгдэж танхимаа байгуулж болох эрх нь хуулиар нээлттэй. Хаана ч нээлттэй байдаг, байх ч ёстой асуудал. Хоёр танхимын зорилго, чиг үүрэг, алсын хараа нь өөр юм. Ихэнх бизнес эрхлэгч Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг. Манай танхимын зорилго тодорхой. Хотоо амьдрахад ая тухтай сайхан хот болгоё, татвар, хөрөнгө оруулалтын таатай эрх зүйн орчинтой байя, ажлын байрыг олноор нь нэмэгдүүлье гээд санал санаачилга гаргах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд гар бие, дуу хоолойгоо нэмэрлэе, ажлаас нь хамтран хийлцье гэсэн бодолтой, сэтгэлтэй бизнес эрхлэгчдийн

► нэгдэл юм.

Хотын танхим нь нийслэлд бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд бизнесийн харилцаатай холбоотой маргааныг шуурхай, олон улсын стандартад нийцүүлэн шийдвэрлэх зорилгоор дэргэдээ арбитр байгуулсан. Манай хуулиар арбитрыг тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын дэргэд байгуулж болохоор заасан тухай би дээр хэлсэн. Нэгд, хуулиараа нээлттэй. Хоёрт, манай улсад арбитрын тогтолцоо сайн хөгжөөгүй, олон улсын стандартын, түвшинд нийцсэн үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаагай санал нийлэхгүй хүн гарч ирэхгүй байх. Монгол Улс чөлөөт зах зээлийн харилцаанд орсноос хойш хөрөнгө оруулалт, худалдааны чиглэлийн олон улсын гэрээ конвенцуудад нэгдэж өөртөө үүрэг хүлээж, дотоодын хууль тогтоомжийг ч олноор нь баталсан. Гадаадын нөлөө бүхий компаниудтай хамтран ажиллах явцад эдгээр гэрээ, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, нөгөө талаар төрийн зүгээс татварын болон хөрөнгө оруулалтын бусад таагүй, үндэслэлгүй судалгаагүй бодлогын уршгаар олон улсын шүүх, арбитрт хариуцагчаар дуудагдаж хэд хэдэн удаа ялагдсан түүхтэй. Марубени, Алтандорнод Монгол гэх мэт ганц хоёр том хэрэгт ялсныг эс тооцвол. Энэ байдлыг өөрчилж, арбитрыг хөгжлийн өндөр түвшинд гаргая, олон улсын жишиг, түвшинд ойртоё, бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг шударгаар хамгаалах зорилго тавьж эхнээсээ олон улсын туршлага, хууль тогтоомж болон НҮБ-ын олон улсын арилжааны арбитрын загвар хуулийг судалж, дүрэм, журмаа ИСС буюу олон улсын Худалдааны танхимын дэргэдэх арбитрын дүрэм, стандартад нийцүүлэн боловсруулсан.

Манай арбитрын дүрэм өөрөө олон улсын шаардлагад нийцсэн, сайн дүрэм байж гэмээнэ хөрш орнууд болон гуравдагч орны бизнесүүд маргаанаа УБХТанхимын дэргэдэх арбитраар шийдүүлэх, манай дүрмээр дэлхийн аль ч улсад арбитрын хуралдааныг явуулж маргаанаа шийдвэрлүүлж чадна. Ер нь арбитрын ажиллагаа хууль болон арбитрын дүрмийн дагуу, маш нарийн процессоор явах учиртай. Гагцхүү процессын алдаа гаргахад л хүчингүй болох аюул байдаг тул мэргэжлийн баг маш өндөр хариуцлагатай зохион байгуулах ёстой юм.

Мөн арбитрчдын бүрэлдэхүүнээ

салбар бүрийн ялангуяа эрчим хүч, уул уурхай, дэд бүтэц, барилга, хөрөнгө оруулалт, худалдан авалтын чиглэлээр мэргэшсэн, туршлагатай өндөр мэдлэг, ур чадвартай, салбартаа нэр хүнд бүхий мэргэжилтэн арбитрч болон хуульчдаас бүрдүүлсэн байгаа. Манай олон улсын арбитрч хуульчид гэхэд Австрали, Сингапур, Европын Холбооны Улс, Швейцарь, АНУ болон Англи гэх мэт нийтийн болон иргэний эрх зүйн тогтолцоо бүхий орнуудын төлөөллөөс бүрдсэн.

-Арбитрын хараат бус, бие даасан байдлын тухайд?

-Бүрэн хараат бус, бие даасан байдалтай ажиллаж байна. Энэ нь өөрөө УБХТанхимын дэргэдэх арбитрын бас нэг онцлог юм. Өөрөөр хэлбэл, манай арбитр Танхимын доторх нэгж биш, Танхимын удирдлагын зүгээс Арбитрын үйл ажиллагаанд оролцдоггүй, Танхим болон танхимын гишүүдээсээ хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж байгаа цаашид ч энэ байдлаа хадгална. Олон улсын нэр хүндтэй арбитрууд ч бие даасан, хараат бус байдагтаа нэр хүнд нь оршдог.

-"Улаанбаатар-Худалдан авалт 2016" чуулган болоод хог, бизнесийнхний түншлэл, хамтын ажиллагаанд арбитрын үүрэг, ач холбогдол чухам ямар байх вэ?

-Форумаар Нийслэл хувийн хэвшлийнхэнтэй хамтарч ажиллах төсөл хөтөлбөрүүдээ танилцуулж, санал болгож хэрхэн цаашид хамтран ажиллахаа ярилцана. Аливаа хамтын ажиллагаа, түншлэл гэдэг бол тэгш эрх, шударга ёсны зарчим дээр тулгуурлаж байж харилцан үр ашигтай, тухайн төсөл ч урт хугацаанд амьдрах, цэцэглэх чадвартай байх учиртай.

Энэ удаагийн форумд санал болгох төсөл хөтөлбөрүүдийг Нийслэл өөрөө санаачилж хувийн хэвшлийнхэнд санал болгож, хамтран ажиллаж ингэхдээ тэгш, шударга, нээлттэй, ил тод зарчмаар явъя гэж байгаа нь үнэхээр дэвшилтэй. Төр, хувийн хэвшлийн түншлэл өмнө нь байгаагүй, цоо шинэ зүйл биш. Өмнө нь ч төрийн ажлыг хувийн хэвшлийнхэн хийж ирсэн, бараа, ажил үйлчилгээгээр хангаж байсан. Чухам юу нь буруу байсан бэ гэхээр шийдвэрийг төр дангаараа гаргаад байсан явдал юм. Төрийн шийдвэртэй маргалдаад шүүхэд очдог, шүүх нь улстөрчид, төрийн албан тушаалтны шахалт дарамт, нөлөөнд автаж улс төрийн шийдэл гаргадаг.

Эцэстээ хувийн хэвшил хана мөргөөд

эрсдлийг нь үүрээд хоцордог. Хамтын ажиллагаа л юм бол талууд тэгш эрхтэй оролцож, хамтарч шийдвэрээ гаргаад, эрсдэл, хариуцлагаа тэгш хүлээж, хамтдаа хөгжиж, маргаан гарвал шударгаар, хөндлөнгийн хараат бус этгээдээр шийдүүлэх ёстой. Энэ л зарчмаар арбитр хувийн хэвшлийнхний төртэй хийсэн хэлцэл, хамтын ажиллагаанд гарсан маргааныг нь ил тод, эрх тэгш зарчмаар шийдэж өгье гэсэн үүрэг хүлээж оролцож байна.

-Талууд маргалдсаны дараа бус маргаан гарахаас өмнө бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор арбитрын үүрэг оролцоо байж болох уу? Байвал ямар хэмжээнд?

-Арбитр маргааныг хараат бус, шударгаар шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага хэдий ч бид маргаан гараасай гээд л хүлээгээд суух биш бизнес эрхлэгчдийнхээ эрх ашгийг хамгаалах УБХТанхимын үндсэн зорилго, чиг үүргийн хүрээнд Танхимын гишүүн аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнесийн аливаа гэрээ хэлцлийн хууль зүйн үндэслэлийг хянаж өгөх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллах болно.

-Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар хэлэлцэж байгаа. Энэ хууль батлагдсанаар арбитрын тогтолцоонд шинэчлэл бодитоор гарах уу? Энэ хуулийн үзэл баримтлалын талаар танай арбитрын байр суурь ямар байгаа вэ?

-Засгийн газраас Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж одоо УИХ-аар хэлэлцүүлж байна. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнөх шатанд манай арбитрын зүгээс үндэслэл, судалгаа бүхий санал өгсөн. Энэ хууль бол НҮБ-ын Олон улсын Худалдааны эрх зүйн Комиссын Олон улсын Худалдааны арбитрын тухай Загвар хууль болон МУ-ын онцлогт нийцсэн хууль болж чадсан гэж үзэж байгаа. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Арбитрын хууль 2003 онд батлагдсан.

Мөн л сайн хууль. Гэхдээ Арбитр бол үндэстэн дамнасан маргааныг шийдвэрлэдэг институт болохынхоо хувьд бусад салбартай харьцуулахад олон улсад загварчлагдсан нэг хуультай, олон улсын стандартыг дагаж мөрдөх шаардлага тавигддаг цорын ганц салбар юм. Энэ утгаараа бид өөрийн орны арбитрын эрх зүйн зохицуулалтыг НҮБ-ын Арбитрын загвар хуульд нийцүүлэхээс өөр арга байхгүй. ■

Зөвлөлдөх ардчилал

“Иргэдийн оролцоо, хотын маргааш”

ХУЛАН

Нийслэлийн Засаг даргын санаачилгаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн сантай хамтран дэлхийн 22 улсад амжилттай явагдаж, нэвтэрсэн зөвлөлдөх санал асуулгыг “Иргэдийн оролцоо- хотын маргааш” нэрийн дор Улаанбаатар хотноо зохион байгуулсан юм. Нээлтийн эхэнд Нийслэлийн ИТХ-ын дарга Д.Баттулга хэлэхдээ “Нийслэлийн шинэчлэлийн баг аливаа шийдвэр гаргахдаа иргэдээсээ асуух зарчмаар ажиллаж ирсэн. Харин энэ удаад бид ирэх жилүүдэд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн томоохон төсөл хөтөлбөрт иргэн таны саналыг авч, зөвлөлдөх гэж байна. Өөрөөр хэлбэл, таны саналаар бид бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлнэ. Цаашид ч иргэдийн оролцоог хангасан саналыг тусгасан шийдвэр гаргаж ажиллах болно” хэмээн тодотгов.

Зөвлөлдөх санал асуулгаар нийслэлээс хэрэгжүүлэх урт хугацааны 14 томоохон төсөл хөтөлбөрийг иргэдэд танилцуулж, тэдний санал тус бүрийг тусгах юм. Уг асуулгад оролцогчдыг 20 бүлэгт хуваасан бөгөөд бүлэг тус бүр ирэх жилүүдэд нийслэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн талаар мэдээлэл авч, харилцан санал солилцжээ.

Энэхүү санал асуулгын үеэр Стэнфордын Их сургуулийн Зөвлөлдөх ардчиллын хүрээлэнгийн захирал, Профессор Жэймс С.Фишкин хэлэхдээ “Зөвлөлдөх санал асуулгыг дэлхийн 23 улсын 40 гаруй хотод амжилттай явуулж, тухайн хотын багагүй асуудлыг иргэдтэй зөвлөлдөн шийдвэрлэсэн. Тиймээс

Улаанбаатар хотод хэрэгжүүлэх урт хугацааны төсөл хөтөлбөрт анх удаа иргэдийн саналыг авахаар болсон нь маш чухал алхам болж байна. Зөвлөлдөх санал асуулга нь удирдлагууд өөрийн үзэл бодол, бодлогоо ард түмэнд тулгах бус тэдэнд танилцуулж, саналыг нь тусгаж өөрөөр хэлбэл, төрийн бодлого олон нийтийн хоорондох зайг нөхөж өгдөг аргачлал юм. Энгийн санал асуулгаас огт ялгаатай. Санал асуулгад оролцогчдод илүү давуу тал, үр дүнтэй байдаг. БНХАУ-ын орон нутагт явуулсан өөр санал асуулгад иргэдийн 70 хувь нь уг асуудлыг дэмжиж байсан бол зөвлөлдөх санал асуулгаар 28 хувь болж байх жишээтэй. Энэ нь олон нийт уг асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, анализ хийн бодитойгоор хариулж, санал өгсөнд байгаа юм” гэлээ. Уг зөвлөлдөх санал асуулгыг АНУ, Их Британи, Австрали, Дани, Болгар, БНХАУ зэрэг оронд 40 гаруй удаа амжилттай явуулж байсан аж.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл “Бид иргэдийн төлөөллийн байгууллагаар орон нутгийн үйл ажиллагааг яаж удирдуулах вэ гэж эрэл хайгуул хийсний үр дүнд “Зөвлөлдөх Ардчилал” гэсэн энэ аргачлалыг сонгон авсан юм. Цаашид Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтынхаа ажилд шаардагдах хөрөнгө, хэрэгцээ, зураг төсөл, газрын байршлыг хүртэл иргэдэд мэдээллэж, тэднээр тодорхойлуулдаг болохоор ажиллаж байна” гэж онцлов.

Улаанбаатар хотын оршин суугчдын дотроос санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон иргэд өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 12-13-нд цуглан хоёр хоногийн турш хотын мастер төлөвлөгөөнд тусгагдсан томоохон дэд бүтцийн төслүүдийн талаар зөвлөлдөв. Хөтөлбөрийн дагуу иргэд жижиг бүлгийн хэлэлцүүлэгт оролцохын зэрэгцээ нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр зээлээр санхүүжих 14 төслийн эерэг, сөрөг талуудын талаар мэргэжилтэн шинжээчдээс асуун нэмэлт мэдээлэл авсан байна.

Зөвлөлдөх санал асуулгын үр дүн

Анхан шатны судалгааг санамсаргүй түүврийн аргаар сонгосон 1502 иргэдээс авсан. Иргэдээс авсан санал асуулгад өргөн хүрээг хамарсан, мөн иргэдийн Засгийн газарт итгэх итгэл, олон нийтийн хэлэлцүүлгийн талаарх үзэл бодлыг тодорхойлох асуултууд мөн багтсан аж.

Зөвлөлдөх санал асуулгын үр дүнд хамгийн өндөр үнэлгээг авсан төсөл бол “Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан техникийн шинэчлэлт” байв. Энэхүү төсөл нь төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн барилгуудын дулаан техникийн шинэчлэлийг хийхэд чиглэсэн юм. Түүний дараагаар усны урсгалыг сэргээн сайжруулж, гол мөрний сав газрыг нөхөн сэргээх зорилготой “Туул, Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах” төсөл оржээ. Мөн зөвлөлдөөний өмнө болон дараа хамгийн өндөр үнэлгээтэй зорилтуудаар агаарын бохирдлыг бууруулах, ус болон газар хөрсний бохирдлыг бууруулах зорилтууд шалгарсан байна. ■

Зөвлөлдөх санал асуулгаар

- Улаанбаатар метро
- Туул усан сан цогцолбор
- Туулын хурдны зам
- Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк
- Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк
- Эко парк байгуулах
- Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах
- Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан техникийн шинэчлэлт
- Угсармал орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах
- “Бага тойруу”-гийн хуучин барилгыг дахин төлөвлөн, барилгажуулах
- Монгол наадам цогцолбор,
- Экологийн коридор байгуулах
- Туул, Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах
- Улаанбаатар хотыг хийн түлшээр хангах гэсэн төслүүд дээр иргэдээс санал авсан юм.

Хотын хөгжил иргэдийн нүдээр

Н.Цогт

(Баянзүрх дүүргийн 6-р хорооны иргэн):




-Ер нь хот байгуулалт сайн хөгжиж байна. Өндөр өндөр барилгууд босч, зам тээвэр аятайхан болчихлоо. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилд тулгарч буй саад бэрхшээлийг нь арилгаад цаашид явуулах хэрэгтэй. Улаанбаатар хотын хувьд шинэ дэвшил. Наад зах нь хотын утааг багасгахад хэрэгтэй

ажил.

Д.Батцолмон

(Баянзүрх дүүргийн 7-р хорооны иргэн):



-Хөгжиж байгаа шүү дээ. Манай хот юм юмтай л болж байна. Жил ирэх бүр хотын зам сайжирч байна. Гэр хорооллыг барилгажуулах ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Гэр хороололд амьдарч байгаа иргэд үргэлж тэндээ амьдрахыг хүсэхгүй. Тохитой тухтай орон сууцанд амьдрахыг хүсч л байгаа.

Д.Мөнхжаргал

(Баянгол дүүргийн 4-р хорооны иргэн):



-Барьж байгаа барилгуудыг харахад хөгжиж байгаа мэт боловч газар зохион байгуулалт тааруу санагддаг. Мөн эрчим хүч, инженерийн шугам сүлжээний хувьд даацаа дийлэхүү гэдэг дээр эргэлзээ төрдөг. Гэр хорооллыг дахин төлөвлөх шаардлагатай ч нэлээд хөрөнгө хугацаа шаардагдах байх. Ер нь энэ ажлыг үргэлжлүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Г.Мэндхүү

(Баянзүрх дүүргийн 4-р хорооны иргэн)



-Өнөөдрийг 10, 15 жилийн өмнөх байдалтай харьцуулахад Улаанбаатар хотын өнгө төрх сайн тал руу өөрчлөгдсөн гэж боддог. Хотын авто замууд сайжирсан. Зуны улиралд зүлэгжүүлэлт, цэцэг тарих гээд хотоо өнгөлөг болгох ажлууд хийдэг болсон. Гадаадын аль ч хотод энэ бол байх ёстой л зүйл. "U money" карт гаргаж нийтийн тээврийн үйлчилгээнд мэдэгдэхгүйц өөрчлөлт

гарсан. Гэхдээ Улаанбаатар хотод хийх зүйл их байгаа гэж боддог. Жишээ нь авто замын түгжрэл. Бид түгжрэлд их цаг үрж байгаа. Түгжрэлээс болж цаг хугацаанаас гадна эдийн засгийн хөгжил ч саарч байгаа. Түгжрэлд зогсох машин хэчнээн түлш үр дүнгүй шагааж утаа болгож байгааг хэн ч тооцоолоогүй байх. Нэг сая орчим оршин суугчтай Улаанбаатар хотод метроны сүлжээтэй болох ажил эхлээсэй гэж боддог. Уг нь хотын иргэд хандив цуглуулаад ийм бүтээн байгуулалт эхлүүлж болох л байх. Дархан хотод шинэ бүтээн байгуулалт хийхдээ бүх аж ахуйн нэгж, оршин суугчдаасаа дэмжлэг авдаг туршлага байдаг юм билээ.

Д.Энхзаяа

(Хан-Уул дүүргийн 2-р хорооны иргэн)



-Улаанбаатарт их зүйл өөрчлөгдсөн. Нэг үеэ бодоход юм бүхэн арай цэгцтэй болж ирж байна. Харин хүмүүсийн сэтгэлгээ хэвээрээ л байна. Хүмүүсээ хотын соёлд сургахаас дараагийн

ажлаа эхэлмээр байна. Талын монголчууд тэр чигээрээ суурин иргэншилд суралцах шаардлага яалт ч үгүй бий болжээ.

Б.Хулан

(Баянгол дүүргийн 6-р хорооны иргэн)



Нийслэлд гарч буй өөрчлөлтүүд таалагдаж байгаа. 88 хувийн үнэлгэ өгнө өө. Одоо дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламжаа нэмж, илүү олон цэцэрлэгт хүрээлэнтэй, амарч тухлах газартай болмоор байна. Утааны асуудлыг шийдэж чадахгүй байгаа юм чинь ядаж зун дугуй унаж, явган алхах сайхан замтай болмоор байна. Харин тэр Даншиг наадам надад үргүй зардал юм шиг санагдсан.

Харин улсын баяр наадмаа илүү гоё зохион байгуулахад анхаарсан нь дээр болов уу. Мөн захын дүүргүүдийн дэд бүтцийг илүү хөгжүүлэх хэрэгтэй байгаа. Гэрэл, зам, цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэх хэрэгтэй. Гэр хорооллын иргэд ч гэсэн сайхан орчинд амарч тухалж чөлөөт цагаа өнгөрүүлэхийг хүснэ. Тэгвэл ганц үндэсний цэцэрлэгт хүрээлэнг зорьсон замын түгжрэл үүсэхгүй шүү дээ. ■

Тогтвортой хөгжил

“Ногоорох” шийдэл

Б.ЦЭЦЭН

Тэнгэр баганадсан барилгуудтай, зам дүүрэн машинтай, түмэн олон хүнтэй л бол өндөр хөгжилтэй хүчирхэг хот гэх ойлголт XXI зуун гарахад бүдгэрч, өдгөө бараг ой модон дунд байгаа мэт сэтгэгдэл төрүүлэм ногоон байгууламж олонтой, иргэд нь барагтаа машин унах шаардлага гардаггүй, эрчим хүчний хэмнэлт өндөртэй орчинг хамгийн таатайд тооцох болж. Энэ бол “Ногоон” хот хэмээх хөгжлийн хандлага даяаршиж буйн илрэл.

Дээрх хандлагатай Улаанбаатар хот ч хөл нийлүүлэн 2012 онд орон нутгийн сонгуулийн дараах удирдлагын шинэ бүтэцдээ экологи ногоон хөгжлийн асуудлыг оруулж ирсэн. “Өдийг хүртэлх хугацаанд Нийслэлээс дэлхийн бусад хоттой хамтран ажиллах тэр тусмаа бүс нутгийн хэмжээнд идэвхийлэн манлайлах зорилго тавьж ирсэн” гэж Нийслэлийн

Засаг даргын Экологи ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ хэллээ. Үүний нэг илрэл нь 2015 оны есдүгээр сард Зүүн Хойд Азийн хотуудын удирдлагын түвшинд ногоон хөгжлийн форум зохион байгуулсан юм. Чуулганы үеэр Улаанбаатар хот ногоон хөгжлийг эргэж буцалгүйгээр сонгон хөгжинө гэдгээ зарлан, хамтран ажиллах саналуудаа хэлэлцэж, өмнөө байгаа бүс нутгийн хэмжээний сорилтуудаа давах боломжуудаа хэлэлцэв.

Мөн өнгөрсөн оны 12 сард болсон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан COP21 дээд хэмжээний хуралд Зүүн Хойд Азийн хотууд ногоон хөгжлийн чиг баримжааг сонгон хөгжиж байгаа ба үүн дундаа Улаанбаатар хот бүс нутгаа уриалж байгаа гэдгийг Э.Бат-Үүл дарга онцлон дуулгасан.

Парисийн гэрээ хэлцэл цаг уурыг тогтворжуулахгүй гэхдээ энэ хэлцлийн хүрээнд гаргаж буй хичээл зүтгэл олон зүйлийг хийх боломжуудыг бий болгоно. Тус хурлын хамгийн том үр дүн нь 200 гаруй улс нэгдсэн дэлхийн дулаарлын өсөлтийн хэмжээг хоёр градусаар бага хэмжээнд барих гэрээнд гарын үсэг зурсан явдал юм. Тус гэрээнд туссанчлан дэлхийн хамгийн баян орнууд 2020 он гэхэд хөгжиж буй орнуудад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх гамшгаас сэргийлэх зорилгоор 100 тэрбум ам.долларыг жил бүр зарцуулахаар боллоо. Энэхүү санхүүжилтээс хүртэгчдийн нэг нь манай улс байж болох ба түүний тулд санаачлага гаргаж, ажил хийх хэрэгтэйг холбогдох мэргэжилтнүүд учирлаж байна. Дэлхийн бүх улсад тулгарч байгаа нийтлэг сорилт нь цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөллүүд. Манай улсын нутаг ▶



ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

▶ дэвсгэр цаг уурын өөрчлөлтөд өртөмтгий байгаагийн нэг илрэл нь цөлжилтийн тархац. Энэхүү асуудал Монголын хилийг, цаашлаад далайг гаталж бусад улсад нөлөөллөө үзүүлээд эхэлчихсэн. Тиймээс бусад орон тэр дундаа нөлөөллөл нь мэдрэгдээд эхэлсэн Япон Солонгост бидний ногоорох төлөвлөгөөнд туслах хүсэл зориг, шаардлага байна. Нөгөөтэйгүүр энэ нь бизнесийнхэн ногоон гэх тодотголтой бизнес эрхэлбэл санхүүжилт илүү хүртэх боломж гэсэн үг.

Өдгөө манай урд хөрш хүртэл тогтворгүй хөгжлийн замаар замнаж, байгаль орчноо сүйдэлж байснаа ухаарч “ногоорох” оролдлогууд хийж буй. Үүний тод илрэл нь дэлхийн ногоон хөгжлөөрөө тэргүүлэгчдийн эгнээнд багтдаг Сингапуртай Тьянжин хот хамтран тэднээс суралцаж Эко-хот болохоор чармайж буй нь юм. Одоогоос 15 жилийн өмнө уул уурхайн салбарын өлгий нутаг Австралийн Сидней хамгийн ногоон бус хотуудын нэгт жагсдаг байсан бол өдгөө хамгийн өндөр тогтвортой өсөлтийн индекстэй хотуудын нэгээр цойлж байна.

Харин Улаанбаатарын хувьд ногоон хөгжлийн стратегийг боловсруулах ажил эцсийн шатандаа явж байгаа ба энэ оны эхний улирал гэхэд баглуулах хүлээлт бий. Энэ бичиг баримт 2020 он хүртэл нийслэл ямар ажлууд хэрэгжүүлэх, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд санхүүжилтийг хэрхэн шийдэх, олон улсын хэмжээнд харилцаагай байгаа хотуудтай хэрхэн хамтрах мөн 2020 он гэхэд ямар зорилтуудад хүрчихсэн байх вэ гэх зэрэг олон ажлыг тодорхой болгосон байгаа аж.

Ногоон хөгжил гэдэг нь хүрээлэн буй орчноо хайрлаж хадгалах замаар эдийн засгийнхаа өсөлтийг нэмэгдүүлэх тогтвортой хөгжлийн загвар. Тухайлбал, аливаа бүтээн байгуулалтад хүрээлэн буй орчиндоо ээлтэй байх хөгжлийн нэмэлт шаардлагыг л тавина гэсэн үг. Улаанбаатар хот ногоорохын тулд олон сорилтууд бий. Мэргэжилтнүүдийн хэлж байгаагаар бол 2020 он хүртэл чадах хэмжээндээ зургаан сорилт дээр тулж ажиллахаар тодорхойлсон аж: уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, агаарын бохирдол, усны гачигдал ба бохирдол, хог хаягдал, хөрсний бохирдол, олон нийтийн мэдлэг оролцоо сул. Эдгээрээс хамгийн хэцүү даалгаврыг нь иргэдийн хандлагад өөрчлөлт хийх явдал хэмээн Т.Бат-Эрдэнэ дарга хэллээ. Гэвч тэрбээр хэлэхдээ өрхийн хэмжээнд тулж ажиллабал, уг том өөрчлөлт биеллээ олох том суурь болно гэсэн.

Улаанбаатарын эрэмбэ

Ногоон хөгжил буюу эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж буй хөгжлийн гол шинжүүдийг хадгалсан хотуудыг хэмждэг, эрэмбэлдэг үзүүлэлтүүд байдаг. Тухайн хотын хогийн, бохирусны, агаарын, гээврийн менежмент гэх мэт. Жишээлбэл хог хаягдал нь нэг үйлдвэрийн түүхий эд болоод дуусах биш дам, дамаа цаашлаад дахиад нэг үйлдвэрийн түүхий эд болох ёстой гэж үзэх болж. Тухайлбал, энэ тал дээр Сингапур улсыг харж болох бөгөөд тус улс тэг хаягдалтай, автомашингүй орон болно гэдэг уриа дэвшүүлэн ажиллаж байна. Хүн амын төвлөрөлөөс үүдэлтэй бас нэг сөрөг үзэгдэл нь бохир ус. Бохир усыг хэрхэн цэвэршүүлэн байгальд нийлүүлж, хэрхэн дахин ашиглаж байгаа вэ гэдэг менежмент. Мөн нийтийн тээврийн хэрэгсэл, барилгуудад ухаалаг шийдэл ашиглах зэрэг үзүүлэлтүүд бий.

Одоохондоо Улаанбаатар энэ хэмжээсүүдээр харвал нэгэнд нь ч дөхөж очихгүй байгаа. Гэхдээ тэдгээрт хүрэх бодит оролдлогуудыг ямартай ч хийгээд эхэлсэн. Тухайлбал, өнгөрсөн жил орчин үеийн 50 автобусыг оруулж ирж үйлчилгээнд нэвтрүүлсэн, энэ жилээс хог боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр техник эдийн засгийн үндэслэлийг нь гаргуулаад явж байна. Бүтээн байгуулалтуудыг эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдал бага, ухаалаг тодотголтой ангилал руу шилжүүлэх алхмыг мөн өнгөрсөн жилээс хийгээд эхэлсэн байна. Нэг жишээ нь Чингэлтэй дүүргийн тавдугаар хороонд хуучин орон сууцыг дахин засварласан. Эрчим хүчний хэмнэлт энэ барилга дээр л гэхэд 30-40 хувь байжээ. Хэрвээ бид өнөө 1100 хуучин барилгаа сэргээн засварлаж, эрчим хүчний хэмнэлт хийвэл дахиад 3,4-р хорооллын хэмжээний барилгуудыг эрчим хүчээр хангах бололцоотой болно. Ирэх жилийн хувьд хийх томоохон ажлуудын нэг нь “Ногоон” худалдан авах ажиллагаа. Энэ бол бүтээгдэхүүн үйлчилгээнд “ногоон” гэх тодотголтой шаардлагуудыг тавина гэсэн үг.

“Бидний өдийг хүртэлх ажлууд мэдээж хангалттай биш. Гэхдээ бид нэг нэгээр нь хийж байна. 2030 он гэхэд Улаанбаатар Азийн хэмжээндээ ногоон хотуудын нэг болно гэдэгт итгэх хэрэгтэй” хэмээн Нийслэлийн Засаг даргын Экологи ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ итгэл дүүрэн хэлж байна. ■

